



Европын Холбоо  
санхүүжүүлэв



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



UN  
DP

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ  
“МОНГОЛ УЛСАД ТХЗ-ТОЙ УЯЛДСАН  
ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

# ЖИЛИЙН ТАЙЛАН



(2022 ОНЫ 11 САРЫН 21 – 2023 ОНЫ 11 САРЫН 20)



## ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

Тайлангийн хугацаа	2022 оны 11 дугаар сарын 21 – 2023 оны 11 дугаар сарын 20-ын өдөр
Санхүүжүүлэгч	Европын Холбоо
Улс	Монгол Улс
Төслийн нэр	<u>ACA/2020/418-930 BS TA</u> Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь
Төслийн зорилго, зорилт	Төслийн зорилго нь Монгол Улс дах хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөрийг дэмжих бөгөөд үүнд: i) тодорхой үйл ажиллагааг шууд хэрэгжүүлэх болон бодлогыг сайжруулах замаар хөдөлмөр эрхлэх чадавх, боломжийг нэмэгдүүлэх ii) төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах замаар хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн салбарт үр дүнд чиглэсэн, үр нөлөөтэй, нотолгоонд суурилсан бодлого, төсвийн төлөвлөлтийн санаачилгыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.
Төсөл эхлэх/дуусах огноо	2020 оны 10 дугаар сарын 01 - 2024 оны 4 дүгээр сарын 01
Хамтран хэрэгжүүлэгчид	НҮБХХ, ХХААБ, ОУХБ
Үндэсний болон орон нутгийн түвшний хамтрагчид	Сангийн Яам Эдийн Засаг, Хөгжлийн яам Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам Боловсрол, шинжлэх ухааны яам Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Их Хурал Үндэсний Аудитын Газар Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо Залуучуудын хөдөлмөрлөх эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудыг багтаасан Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ ИНБ болон судалгаа/хэвлэл мэдээллийн байгууллагууд Орон нутгийн Засаг захиргаа
Төслийн үр шимийг хүртэгсэд	Залуучууд Тариаланчид, малчид Алслагдсан орон нутгийн залуучууд, зорилтот бүлгүүд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Охид, эмэгтэйчүүд Албан бус эдийн засагт ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүс Ажилгүй, бүрэн бус хөдөлмөр эрхэлдэг хүмүүс, Ажил хайгчид
Төслийн нийт төсөв	7,400,000 евро
Холбоо барих хүн	Матильда Димовска НҮБХХ-ийн суурин төлөөлөгч Matilda.dimovska@undp.org

## ТОВЧЛОЛ

АХ	Ажлын хэсэг
БОУСА	Боловсролын олон улсын стандарт ангилал
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГШҮ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
ДАКУМ	Сургалтын хөтөлбөр боловсруулах
ДХГХ	Дунд хугацааны гүйцэтгэлийн хүрээ
ДХЗХ	Дунд хугацааны зарлагын хүрээ
ДХМТХ	Дунд хугацааны макро төсвийн хүрээ
ДХТХ	Дунд хугацааны төсвийн хүрээ
ЕХ	Европын холбоо
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ЖАТ	Жилийн ажлын төлөвлөгөө
ЗГХХГ	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар
ЗДЗТ	Зөв дадал-зан төлөв суулгах
ЗЗХС	Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ
ЗИШ	Зарлагын болон институцийн шинжилгээ
ИНБ	Иргэний нийгмийн байгууллагууд
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
МХҮАҮЭХ	Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХС	Олон улсын хөдөлмөрийн стандарт
СЗСҮХ	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
СНТ	Стратегийн нийцлийн төлөвлөлт/төлөвлөгөө
СоЯ	Соёлын яам
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТМБС	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТХХТ	Төр-хувийн хэвшлийн түншлэл
ТША	Төсвийн шинжилгээний алба
УА	Удирдлагын академи
УЖХТ	Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮДСНУ	Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага

ҮДСТ	Үр дүнд суурилсан төсөвлөлт
ҮЗХ	Хөгжлийн зорилтот хөтөлбөр (Дунд хугацааны хөгжлийн бодлого)
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХНХЕГ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ерөнхий газар
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХҮДХ	Хөтөлбөрийн хөгжлийн үр дүнгийн хүрээ
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан
ХЭДҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөл
ХЭДХ	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр
ШУТИС	Монгол улсын шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЯҮДХ	Яамны үр дүнгийн хүрээ

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ТӨСЛИЙН ХУРААНГУЙ .....	2
1. ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ .....	6
2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ .....	8
3. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ҮР ДҮН.....	11
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ А. БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ.....	14
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ В. ТӨСВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ .....	25
БҮРЭЛДЭХҮҮН С. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ: .....	34
БҮРЭЛДЭХҮҮН Д. ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ .....	52
4. ХАМТЫН АЖИЛЛАГАА .....	59
5. МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	60
6. ТӨСЛИЙН УДИРДЛАГА .....	63
7. БЭРХШЭЭЛ/ЭРСДЭЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ .....	64
8. СУРГАМЖ БОЛОН ЦААШДЫН ЧИГЛЭЛ .....	64
9. САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	65
10. ДАРААГИЙН ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ.....	65
2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	65
11. ХАВСРАЛТ .....	65

## 1. ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Тайлант хугацаанд төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд дараах томоохон ажлуудыг хэрэгжүүлж, холбогдох үр дүнд хүрсэн байна. Төслийн бүрэлдэхүүн хэсэг (А) буюу бодлого, төсвийн уялдааг хангах зорилтын хүрээнд үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх чиглэлд салбар дундын болон удирдлагын түвшний зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий **ажлын хэсгийг** төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2 дугаар тогтоолоор 2023 оны 3 сард байгуулсан ба тус баг нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, хяналт шинжилгээ ба үнэлгээ, болон нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Тэрчлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулах чиглэлд төслийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллаж харагдахуйц ахиц дэвшлийг гарган ажиллалаа. Анх удаа 2024 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө болон Дорноговь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө (ЖХТ)-г **үр дүнд суурилсан аргачлал, маягыг** ашиглан боловсруулан гаргасан ба Дорноговь аймгийн боловсруулсан ЖХТ нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалаар үндэсний болон салбарын түвшний үр дүнд аймгийн түвшинд буулган бодлого төсвийг холбож боловсруулсан улсын хэмжээний анхны оролдлого болсон юм. Үүний дүнд, тус ЖХТ нь бүх аймаг, орон нутагт 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсөвлөлтөө хийхэд хэрэглэх, сайжруулахад туслах загвар байдлаар хэрэглэгдэх боломжтой болсон.

2023 онд төслийн баг үндэсний болон орон нутгийн түвшний төлөвлөгөө, төсөвлөлт болон тайлагналын үйл явцад оролцогч талуудыг үр дүнд суурилсан төсөвлөлтийн талаар ерөнхий ойлголт, мэдээллээр хангах зорилгоор **Үр дүнд суурилсан төсөвлөлтийн гарын авлага** боловсруулсан. Тус гарын авлага нь мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангах зорилготой ба цаашид бусад салбаруудад болон төсөвт байгууллагуудад ҮДСТ хэрэгжихийн хэрээр, сургамжид үндэслэн шинэчлэгдэнэ.

2023 онд нийтдээ 6 Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Соёлын яам (СЯ), Биеийн тамир, спортын үндэсний хороо (БТСҮХ), Үндэсний аудитын газрын нийт 10 салбар нь 2024 оны төсвийн төслөө үр дүнд чиглэсэн зарчмуудыг баримтлан боловсруулж Сангийн яаманд (СЯ) хүргүүлсэн. Тэрчлэн 2024 оны Төсвийн тухай хуулийн<sup>1</sup> Хавсралт 1-д суурь түвшин болон хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд тусгагдсан. Туршилтын яамд болох ХНХЯ болон ХХААХҮЯ-ны 2023 оны эхний **хагас жилийн үр дүнгийн мэдээлэл бүхий төсвийн гүйцэтгэлийн тайлангийн** төслийг шинэ аргачлал, маягтын дагуу боловсруулан, холбогдох яамдад танилцуулаад байна.

Үр дүнд чиглэсэн аргачлалыг ашиглан аудит хийхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Аудитаар бодлого, төсвийн уялдаа, үр дүнгийн шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшинг оновчтой тодорхойлсон эсэх, тэрчлэн салбарын ажилтнуудад үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмжийг өгөхөд түлхүү анхаарал хандуулж ажилласан. Түүнчлэн Үндэсний аудитын газраас **Монгол улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд** хийсэн гүйцэтгэлийн аудитад **судлаачдыг хөндлөнгийн шинжээчээр** оролцуулсан. Энэхүү хамтын ажиллагаа нь гүйцэтгэлийн аудитын чанар, ил тод, найдвартай байдлыг сайжруулахад чиглэсэн төдийгүй тухайн шинжээчдийн багаар 2024 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын тооцоололд дүн шинжилгээ хийлгэж, түүхэн өөрчлөлтийн чиг

---

<sup>1</sup> Төсвийн тухай хуулийн төслийг СЯ-наас УИХ-д 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн барьсан.

хандлагад суурилсан судалгааны аргыг ашиглан ирэх оны төсвийн орлого, зарлагын төсөөллийг боловсруулсан.

Өмнөх жил төслийн хүрээнд гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээнд үндэслэн **2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд** (ХЭДХ)-ийн загварыг шинэчлэн, 2023 оны 2-р сард Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний зөвлөл (ХЭҮЗ)-өөс баталсан. Хөтөлбөрүүдийн шинэчилсэн загварын хувьд орон нутагт илүү боломжуудыг олгосон, хүн амын бүлгүүдэд чиглэсэн байдлыг арилгах замаар сангийн уян хатан байдлыг нэмэгдүүлсэн, хөтөлбөрүүд доторх давхардлыг арилган, илүү бодит гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (ГШҮ)-ийг оруулах байдлаар ҮДСТ-ийн аргыг шингээсэн, гүйцэтгэлд суурилсан тайлагналтыг оруулсан зэрэг давуу талуудтай.

Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн туршилтын арга хэмжээнүүдийн үр дүнд түшиглэн i) хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ, ii) энтрепренёршип, дадлагажих хөтөлбөр, мэргэжлийн түр сургалт, хоршоодыг дэмжих үйл ажиллагааны төрөл, загвар аргачлалыг шинэчлэн боловсруулж ХНХЯ-нд хүлээлгэн өгсөн. **Профайлинг буюу хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ хийх аргачлал, удирдамжийг** Засгийн газраас батлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хэрэглэж эхэлсэн.

Профайлингийн үйлчилгээ үзүүлэх төсвийг 2023, 2024 оны ХНХЯ-ны төсөвт тусгав. Профайлингийн үйлчилгээний жишиг зардлыг Төслийн техникийн багаас боловсруулан, төсөв бэлтгэх үйл явцад ашигласан. “Ажил олгогчийг дэмжих төсөл” (дадлагажих хөтөлбөр)-ийн төсөв нь ХЭДС-ын төсөвт туссан. 2023 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний жишиг зардал 2023/2024 оны ХЭДС-ын жишиг зардлыг ХЭ-г дэмжих арга хэмжээ, үйл ажиллагааны өмнөх зардал дээр үндэслэн тус тус шинэчлээд байна.

Төр-Хувийн Хэвшлийн Түншлэл (ТХХТ)-ийн 2 загварыг Монгол хос бөхт тэмээний сүү болон Дотор махны нэмүү өртгийн сүлжээнд бий болгон хөгжүүлж байна. Ингэний сүү үйлдвэрлэгч малчдын хоршоог Өмнөговь аймгийн Ханбогд, Хагас эрчимжсэн ингэний сүүний аж ахуйг Ханхонгор сумдад тус тус байгуулж, Солид Партнерс Групп ХХК (SPG LLC), ТЭСО Групп зэрэг хувийн хэвшил, ХХААХҮЯ болон орон нутгийн захиргаад зэрэг төр, ХААИС, ШУТИС зэрэг шинжлэх ухаан-боловсрол, болон Монголын Махны Холбоо, Монголын Үндэсний Мал Эмнэлгийн Холбоо зэрэг төрийн бүс байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Төслийн хүрээнд зохион байгуулсан “Agripreneurship Challenge” буюу ХАА-ын салбарын шинэлэг, инновацлаг бүтээгдэхүүн, бизнесийг шалгаруулах тэмцээнд 100 гаруй гарааны бизнес компаниуд амжилттай оролцсон байна. Тэмцээнд шалгарсан шилдэг гурван гарааны компанийг бизнесээ өсгөн томруулахад нь зориулж инновац шингээсэн бүтээгдэхүүн, бизнесийн хөгжил, урт хугацааны өсөлтийг нь дэмжих тусгайлсан бойжуулалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх зэргээр техникийн туслалцаагаар хангахын хамт шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэв.

“2021-2025 он хүртэлх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн (ХАБЭМ) Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө”-г боловсруулахад ХНХЯ-нд дэмжлэг үзүүлсэн. Мөн ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг (ХАБЭМ)-г дэмжих тогтолцооны тухай 187 дугаар конвенцод нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд хуулийн нийцлийн дүн шинжилгээг хийхэд ХНХЯ-ыг дэмжиж ажилласан байна. Энэхүү конвенц нь ОУХБ-ын үндсэн конвенцуудын дотроос Монгол Улс нэгдэн ороогүй цорын ганц конвенц юм.

ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцуудад нэгдэн орох талаар ХНХЯ-наас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба төслийн хүрээнд Засгийн газар болон нийгмийн түншлэгч байгууллагуудад техникийн болон үйл ажиллагааны/логистикийн дэмжлэг үзүүлж ажилласан. Хамтын ажиллагааны үр дүнд нэгдэн орох хуулийн төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар ажиллаж байна.

## 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Төслийн зорилгод хүрэхэд нөлөөлж болохуйц хууль эрх зүй, бодлого, институцийн орчинд гарсан гол өөрчлөлт, үйл явдлуудыг тус хэсэгт тоймлон хүргэв.

**Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт** (2023 оны 7 дугаар сарын 7)-өөр төсвийн ил тод, хариуцлагатай, тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр дараах үндсэн гурван өөрчлөлтийг тусгасан, үүнд: i) Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг (ДХТХМ) боловсруулахад үндэслэл болгон ашигладаг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг УИХ-ын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулна (8.1.2 зүйл), Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Эдийн засаг, хөгжлийн яам боловсруулна (12<sup>2</sup>.1 зүйл), Төсөвт өрийн удирдлагын үзүүлж буй нөлөөллийг богино- болон дунд хугацаанд тооцдог байсныг урт-хугацаанд мөн тооцохоор сунгасан<sup>2</sup>. Эдгээр өөрчлөлтүүдийг тусгаснаар макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн зориулалтыг төсвийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд илүү тодорхой болгохын зэрэгцээ жилийн төсвийн төслийг ДХТХМ-ийн хамт өөрчилдөг уламжлалыг зогсоохыг зорьсон. ii) Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог заавал хангах (28<sup>1</sup> зүйл), төсвийн хэлэлцүүлгийг салбар салбараар зохион байгуулах, iii) Төсвийн тусгай шаардлагад өөрчлөлт оруулах тухай хэлэлцэхэд УИХ-ын гишүүдийн ирц өндөр байх (Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.7 зүйл), төсвийн тооцооллыг үндэслэлгүй хийх (70.4 зүйл), түүнчлэн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно хэмээн тусгасан. Сүүлийн энэ заалт нь төсвийн сахилга батыг сайжруулах зорилготой хэдий ч төсвийн ангилал тус бүрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнд суурилсан төсөвлөлтийн зарчмаас нэг алхам ухарч буйг харуулж болзошгүй.

**Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар**<sup>3</sup> (ЗГХХГ)-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Тус газар нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх үндсэн чиг үүрэгтэй (ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар байгуулах тухай тогтоол, 5.11.1 зүйл). Тиймээс ЗГХХГ нь үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг ялангуяа хяналт, шинжилгээ, үнэлгээний шатанд нэвтрүүлэх чиглэлээр төслийн хамтран ажиллах гол байгууллага болсон. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай Засгийн газрын 206 дугаар тогтоолд (2020) өөрчлөлт оруулах чиглэлээр ЗГХХГ ажиллаж эхлээд байна.

### Хөдөлмөр эрхлэлтийн салбар

Хөдөлмөрийн хяналтын чиг үүргийг 2023 оны 1 дүгээр сараас эхлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд (ХНХЯ) шилжүүлсэн бөгөөд, энэхүү өөрчлөлтийн хүрээнд хөдөлмөрийн хяналтын системийн удирдлага, хяналтаар хангах, хөдөлмөрийн хяналтын журмуудыг шинэчлэн боловсруулах Салбарын хяналтын газрыг ХНХЯ-нд байгуулсан. Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх нийт 162 улсын байцаагч ХНХЯ-ны Салбарын хяналтын газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ), Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ), нийслэл, аймаг, дүүргийн холбогдох төрийн захиргааны байгууллагад чиглэл тус бүрээр томилогдон ажиллаж байна.

<sup>2</sup> <https://montsame.mn/mn/read/325581>

<sup>3</sup> In Mongolian - Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар



Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн 5-10 жилийн таамаглал судалгааг хийнэ гэдгээ ХНХЯ 2023 онд зарласан. 2013 оны туршилтаас хойш хийгээгүй тус судалгаанд Засгийн газар нийт 750 сая төгрөг төсөвлөсөн.

### Боловсрол/МБС-ын салбар

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт өргөн барьсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталснаар удаан хүлээгдсэн хууль хүчин төгөлдөр болсон. Шинэчилсэн найруулга бүхий МТБС-ын тухай тус хууль<sup>4</sup> нь нийт 8 бүлэг, 32 зүйл заалттай бөгөөд өмнөх хуультай харьцуулахад илүү өргөн хүрээг хамарсан.

МБС-ын тухай хууль (2009.02.13)	МТБС-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2023.07.07)
<p>Бүлэг 1. Нийтлэг үндэслэл</p> <p>Бүлэг 2. Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага, зохион байгуулалт</p> <p>Бүлэг 3. МБС-ын агуулга, стандарт</p> <p>Бүлэг 4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг</p> <p>Бүлэг 5. Бусад зүйл</p>	<p>Бүлэг 1. Нийтлэг үндэслэл</p> <p>Бүлэг 2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын агуулга, хөтөлбөр, стандарт</p> <p>Бүлэг 3. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, зохион байгуулалт</p> <p>Бүлэг 4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт, элсэлт, төгсөлт</p> <p>Бүлэг 5. Мэргэжлийн болон техникийн боловсролын харилцаанд оролцогчид</p> <p>Бүлэг 6. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо</p> <p>Бүлэг 7. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын төсөв, санхүүжилт</p> <p>Бүлэг 8. Бусад</p>

МТБС-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад (2023) шинэчлэлийн дараах гол заалтууд багтсан, үүнд: i) МТБС-ыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй илүү нийцүүлэх; ii) багш, суралцагсдыг тасралтгүй хөгжүүлэх; iii) МТБС-ын байгууллагуудын хагас бие даасан байдлын бүрдүүлэх; iv) ажлын байранд шаардлагатай үр чадвар, чадамжуудыг эзэмших боломжуудыг нэмэгдүүлэх зорилгоор цахим шилжилт, уян хатан сургалтыг хөгжүүлэх; v) түншлэлийг өргөжүүлэх; vi) санхүү, удирдлагыг сайжруулах зэрэг багтсан.

Түүнчлэн, МТБС-ын төсөв, санхүүжилттэй холбоотой дараах шинэ заалтуудыг тусгасан: i) Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын зардлыг сургалтын үр дүн, чанар, гүйцэтгэлд үндэслэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ (28.1 заалт); ii) Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого нь олон эх үүсвэрээс бүрдэнэ, тухайлбал өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, Засгийн газрын тусгай сангаас хуваарилсан хөрөнгө; iii) Олон талт болон БШУЯ-ны төлөөллөөс бүрдсэн МТБС-ын Зөвлөл МТБС-ын төсвийн хуваарилалтыг шийдвэрлэнэ; iv) нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардалд үндэслэн МТБС-ын байгууллагын санхүүжилтийн хэмжээг тооцно. Ийнхүү мэргэжлийн өөрийн өртөгт суурилан санхүүжилтийн хэмжээг тогтоох

<sup>4</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16759959076531>

болсон нь цалин, халаалт зэрэг төсвийн зүйл/орцод суурилсан уламжлалт аргачлалаас нэг алхам урагшилж буйг харуулж байна.

МТБС-ын тухай шинэчилсэн хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр БШУЯ-наас 2023 онд хэд хэдэн арга хэмжээг аваад байна. Үүнд:

- Мэргэжлийн болон техникийн боловсролын газар нь БШУЯ-ны Дээд боловсролын газраас тусдаа газар болон бүтцийн өөрчлөлт хийгдсэн.
- Үйл ажиллагааны үр ашиг болон сургалтын чанарыг сайжруулах зорилгоор МТБС-ын байгууллагуудыг нэгтгэх ажлын бэлтгэлийг хангаж байна. Санал болгож буй бүтцийн тус өөрчлөлтийн дагуу төрийн МТБС-ын байгууллагуудын тоо 45-аас 37 хүртэл цөөрөх төлөвтэй байна.
- МТБС-ын байгууллагад олгож буй мэргэжлүүдийн жагсаалтыг Боловсролын олон улсын стандарт ангилаллын (ISCED, 2011) дагуу шинэчилсэн. Ингэснээр сургалтын хөтөлбөрийн хүрээнд олон мэргэшлээр бэлтгэх давуу талтай бөгөөд улмаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн Мэргэшлийн үндэсний хүрээг хөгжүүлэх суурь бий болж, цаашдын боловсрол, сургалтын боломжуудыг нээж өгөх юм. Одоогоор 10 салбарын хүрээнд нийт 286 хөтөлбөрийг шинэчлэн ангилсан.

### **Хүнс, хөдөө аж ахуйн салбар**

Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 онд эхлүүлсэн Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөдөлгөөний хүрээнд ирэх таван жилд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, Монгол Улс хүнс экспортлогч орон болох томоохон зорилт тавьсан. 2023 онд Хүнсний ногооны ургацын хэмжээ сүүлийн жилүүдэд байгаагүй түвшинд хүрч, дотоодын нийт хэрэгцээний 80 хувийг хангасан.

Хөдөө аж ахуйн салбарт ноос, ноолуур, сүү, малын арьс шир, улаан буудай гэсэн 5 төрлийн бүтээгдэхүүний татаас (урамшуулал) ноогдуулдаг. ХХААХҮЯ-наас эдгээр бүтээгдэхүүний нийлүүлэлт их хэмжээгээр нэмэгдсэнийг мэдээлсэн бөгөөд үүнд татаасын бодлого ихээхэн нөлөөлсөн хэмээн үзэж байна. 2023 онд сарлагийн хөөврийн татаасыг нэмсэн бөгөөд 2024 оноос олгож эхлэх юм.

### 3. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ҮР ДҮН

#### ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮР ДҮН- БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

##### Төслийн зорилт 1-д оруулсан хувь нэмэр:

Зорилт 1	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	2023 оны Гүйцэтгэл
Төсвийн багц хөтөлбөрүүд бодлого, үр дүнтэй уялдсан байна	Үр дүнд суурилсан ДХЗХ, салбарын болон ТХЗ-ын зорилтот түвшин бүхий жилийн төсвийн санал боловсруулж, СЯ-тай хэлэлцсэн яам, салбарын тоо	2 төсөл (байгаль орчин& эрүүл мэнд) (2019)	6 салбар (40%)	<b>Хугацаандаа хэрэгжиж байна.</b> 6 Төсвийн ерөнхийлөн захирагч буюу ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ, СЯ, БТСҮХ, УАГ-ын нийт 10 салбарын 2024 оны төсвийн төслийг үр дүнд чиглэсэн аргачлалаар боловсруулсан.
	Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж, илгээсэн салбарын тоо	0	4 салбар	<b>Хугацаандаа хэрэгжиж байна.</b> ХНХЯ-ны 2 салбар, ХХААХҮЯ-ны 4 салбарын 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн болон үр дүнгийн тайланг бэлтгэсэн.

2023 онд нийтдээ 6 Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Соёлын яам (СЯ), Биеийн тамир, спортын үндэсний хороо (БТСҮХ), Үндэсний аудитын газрын нийт 10 салбарын 2024 оны төсвийн төслийг үр дүнд чиглэсэн зарчмуудыг баримтлан боловсруулж Сангийн яаманд (СЯ) хүргүүлсэн. Доорх хүснэгт үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн жилийн ахиц дэвшлийг харуулсан.

ҮДС төсвийн элементүүд	2021	2022	2023	2024
Үр дүнд суурилсан төлөвлөлт	Хэрэгжээгүй	Хэрэгжээгүй	Үр дүнд суурилсан дүнд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (Үндэсний зорилтот хөтөлбөрүүд)-г боловсруулсан.	Улсын болон аймаг, нийслэл, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалууд батлагдсан. 2024 оны улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад энэхүү аргачлалын зарим хэсгийг ашигласан.
Төсвийн удирдамжид үр дүнд суурилсан төсвийн загвар маягтуудыг тусгасан.	БОАЖЯ, ЭМЯ, БШУЯ	БШУЯ, ХНХЯ, ХХААХҮЯ	БШУЯ, ХНХЯ, ХХААХҮЯ (дахин сайжруулсан)	БШУЯ, ХНХЯ, ХХААХҮЯ (харьяа төсвийн байгууллагуудыг хамруулан

				боловсронгүй болгосон)
Үр дүнд суурилсан төсөвлөлтийн хүрээнд хөтөлбөрийг дахин ангилах (бодлого ба төсвийн хөтөлбөрүүдийн уялдааг хангах)	Өөрчлөлтгүй	Өөрчлөлтгүй	Туршилтын яамдын хувьд санал болгож буй төсвийн хөтөлбөрийн ангиллыг боловсруулсан.	Шинэчилсэн төсвийн хөтөлбөрийн ангиллын маягт/загвар -ын төслийг боловсруулсан (бодлого ба төсвийн хөтөлбөрүүдийг уялдуулан)
СЯ-с төсвийн төслийг үр дүнд суурилсан байдлаар хянах			Сангийн яам ба туршилтын яамдын хооронд төсөв хянах хэлэлцүүлэгт зориулж Үр дүнд суурилсан төсвийн хяналтын хуудсыг боловсруулж, заримыг нь ашигласан.	СЯ болон туршилтын яамдуудын (ХНХЯ, ХХААХҮЯ, БТССУХороо) хооронд үр дүнд суурилсан хяналтын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.
Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэл ба үр дүнгийн тайлагнал	Төсвийн гүйцэтгэлийн тайлан, үйл ажиллагааны тайлангууд, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд ихэнхдээ хэт ерөнхий эсхүл үйл ажиллагаанд суурилсан байсан.	Төсвийн гүйцэтгэлийн тайлан, үйл ажиллагааны тайлангууд, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд ихэнхдээ хэт ерөнхий эсхүл үйл ажиллагаанд суурилсан байсан.	Туршилтын яамдын үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон ба СЯ-ны төрийн сангийн системийг ашиглан тэдгээрийг тайлагнах боломжтой болсон.	БШУЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн тайлан, ХХААХҮЯ-ны болон ХНХЯ-ны 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлангуудыг боловсруулсан.
Хөтөлбөрийн төсвийн зарлагын шинжилгээ	Салбарын зардлын шинжилгээ (зарим хөтөлбөрийн бүрэлдэхүүн бүхий) – ЭМЯ, БШУЯ	Салбарын зардлын шинжилгээ (ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ, Зам болон тээвэр <sup>5</sup> ); Төсвийн зарлагын шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл хөтөлбөрөөр байхгүй.	Салбарын зардлын шинжилгээ (соёл, спорт); Хөтөлбөрөөр 2023 оны төсвийн зарлагын шинжилгээний шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл 2024 оны эхээр бэлэн болно. (хөдөлмөр эрхлэлт эрхлэлт, хөдөө аж ахуй)	Анхны төсвийн зарлагын шинжилгээг хөтөлбөрөөр хийх болно. (ажил эрхлэлт, хөдөө аж ахуй)

<sup>5</sup> Хяналт нь ТХЗ-ын хамтарсан сангийн санхүүжилттэй НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, НҮБХХ, НҮБХС хамтран хэрэгжүүлж буй "ТХЗ-ын санхүүжилтийн нэгдсэн аргачлалыг МУ-д хэрэгжүүлэх нь" хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн. (2020 - 2022)

Төсөв боловсруулах, хянах хэлэлцүүлэгт үр дүнгийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн зарлагын шинжилгээг ашиглах	Тоо мэдээлэл дутмаг учраас боломжгүй	Тоо мэдээлэл дутмаг учраас боломжгүй	Тоо мэдээлэл дутмаг учраас боломжгүй	Үр дүнгийн тоо мэдээллүүд бий болох тохиолдолд боломжтой.
Орон нутгийн захиргаад	Завхан аймгийн төсвийн зарлагын шинжилгээ хийгдсэн	Хөвсгөл аймгийн төсвийн зарлагын шинжилгээ хийгдсэн	21 аймаг, нийслэлийн хувьд үр дүнд суурилсан удирдлагын сургалтууд хийгдсэн.	21 аймаг, нийслэлийн хувьд үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал ба хяналт шинжилгээ үнэлгээний сургалтууд хийгдсэн; Дорноговь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, болон төсөв үр дүнд суурилсан арга зүй, маягтуудыг ашиглаж хийгдсэн.

## ДЭД ЗОРИЛТЫН ТҮВШНИЙ ҮР ДҮН

### БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ А. БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

Уг бүрэлдэхүүний хүрээнд төсөл дараах дөрвөн үндсэн үр дүнд хүрэхийг зорьсон:

- А.1 Үр дүнгийн мэдээлэлд үндэслэсэн стратегийн төсөвлөлт (ДХЗХ)
- А.2 Үр дүнгийн мэдээлэлд үндэслэсэн төсвийн танилцуулга,
- А.3 Нотолгоонд суурилан төсөв боловсруулах,
- А.4 Үр дүнд суурилсан төсөвлөлт, ТХЗ-д чиглэсэн төсвийн төлөвлөгөө боловсруулах СЯ, салбарын яамдын чадавхыг бэхжүүлэх

#### А.1 ҮР ДҮНГИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭСЭН СТРАТЕГИЙН ТӨСӨВЛӨЛТ (ДХЗХ)

##### Төслийн дэд зорилтын хэрэгжилтийн явц

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	Хэрэгжилт 2023
А.1.1 ДХЗХ-г шинэчлэх төлөвлөгөө боловсруулна	А.1.1.1. ДХЗХ болон ҮДСТ-ийн шинэчлэлийн замын зураглал, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах	0 (2019)	Замын зураг	<b>Хэрэгжиж байгаа.</b> Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын ажлын хэсэг Улсын бүтээмжийн хорооны дэргэд байгуулагдаж, өнгөрсөн хоёрдугаар сард стратегийн уулзалт хийсэн.
	А.1.1.2. Төлөвлөгөөний биелэлтэд жил бүр үнэлгээ хийх	-	1	
А.1.2 Үр дүнд суурилсан ДХЗХ-г боловсруулах тогтолцоо бүрдэнэ	А.1.2.1. ДХЗХ-ний удирдамж, маягт шинэчлэгдэж, СЯ баталснаар үр дүн, тэргүүлэх чиглэлд суурилсан төсвийн хэлэлцүүлэг хийгддэг байх	БОАЖЯ туршилт (2019 он)	Бүх туршилтын яамд	<b>Хэрэгжсэн.</b> Үр дүнд суурилсан төлөвлөлтийн (бүх яамд) болон төсөвлөлтийн маягт (бүх туршилтын яамд)-ыг ЭЗХЯ, СЯ-наас боловсруулж баталсан.
	А.1.2.4. Сонгосон яамд үр дүнд суурилсан ДХЗХ, төсвийн саналаа боловсруулсан байх	БОАЖЯ туршилт (2019 он)	4-өөс багагүй	<b>Хэрэгжсэн.</b> Үр дүнд суурилсан төсвийг 4 яам, 1 Үндэсний хороо, УИХ-ын дэргэдэх байгууллага боловсруулсан (ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ, СоЯ, БТСҮХ and YAГ).
	А.1.2.5. Сонгосон яамдын үр дүнд суурилсан ДХЗХ-г хэлэлцсэн байх	БОАЖЯ туршилт (2019 он)	4	<b>Хэрэгжиж байгаа.</b> ҮДС төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. (ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ, БТСҮХ ).

**А.1.1 ДХЗХ-г шинэчлэх төлөвлөгөө боловсруулна, А.1.2. Үр дүнд суурилсан ДХЗХ-г боловсруулах тогтолцоо бүрдэнэ. А.2.1 Төсвийн хөтөлбөрүүд бодлого, үр дүнтэй уялдсан байна, А.2.2 ҮДСТ-ийн хяналт, шинжилгээ, тайлагнал<sup>6</sup>.**

<sup>6</sup> The results achieved under these sub-sections are closely inter-related, therefore, were combined to present more logical flow.

Дэлхий дахинд үр дүнд суурилсан төсвийн тогтолцоонд шилжих нь ихээхэн цаг хугацаа, нөөц шаарддаг үйл явц гэж үздэг. Үр дүнгийн мэдээлэлд үндэслэсэн стратегийн төсөвлөлт буюу Дунд хугацааны зардлын хүрээ (ДХЗХ) нь үр дүнд суурилсан төсөвлөлтийн ахисан түвшний хэлбэр бөгөөд энэ түвшинд стратегийн төсөвлөлтийг урт, дунд хугацааны үр дүнгийн хүрээ болон салбарын шалгуур үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлийн болон санхүүжилтийн өгөгдөл дээр үндэслэн хэрэгжүүлэх боломж бүрддэг. Төслийн 2022 оны жилийн тайланд дурдсанчлан дунд хугацааны төсөвлөлтийг ДХТХМ, ДХТХ, ДХГХ гэсэн гурван дараалсан үе шатлалаар ангилан ДХЗХ гэсэн ерөнхий малгай нэр томъёоллоор тодорхойлдог.

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ) нь олон жилийн хугацаан дах салбарын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх төсвийн хязгаарыг дээрээс доош чиглэсэн багц төсөвлөлт.
- Дунд хугацааны төсвийн хүрээ (ДХТХ) нь доороос дээш чиглэсэн зардлын хүсэлтэд үндэслэн тохируулга хийсэн дээрээс доошоо чиглэсэн төсвийн хуваарилалт.
- Дунд хугацааны гүйцэтгэлийн хүрээ (ДХГХ) нь Дунд хугацааны төсвийн хүрээний бүтэц дээр үр дүнгийн зорилтот үзүүлэлтүүд болон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг агуулсан төсөвлөлт.

Төслийн энэхүү дэд зорилт нь ДХЗХ болон ДХГХ -ээр дамжуулан Төрийн санхүүгийн удирдлагын нэг бүрэлдэхүүн болон Стратегийн төсөвлөлтийн хуваарилалтын чиг үүргийг сайжруулахад чиглэгдсэн. Төсөл 2020 онд хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улс Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг (ДХТХМ) хэрэгжүүлсээр байгаа ба энэ нь үр дүнгийн хүрээнд стратегийн хуваарилалтад хийхэд хязгаарлагдмал нөлөө үзүүлдэг. ДХТХ-ний зарим бүрэлдэхүүн хэсгүүд хийгдэж байгаа боловч ДХТХ болон ДХГХ рүү шилжих шилжилт хараахан хийгдээгүй байна. Тиймээс энэ хүрээнд олон улсын туршлага судлахаар Армен, Бразил, Уганда, Өмнөд Африк, Гана, Өмнөд Солонгос, Казахстан, Европын зэрэг орнуудыг хамруулсан суурь судалгаа хийж, үүнд үндэслэн ДХТХ болон ДХЗХ боловсруулах аргачлалын төслийг боловсруулж байна. Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-аас 2023 оны жилийн эцэс гэхэд Монгол Улсад ДХТХ-г нэвтрүүлэх боломж, нөхцөлийн талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Өнгөрсөн гурван жилийн хугацаанд ДХТХ болон ДХГХ-г нэвтрүүлэхэд шаардлагатай элементүүдийг үүсгэсэн бөгөөд үүн дээр тулгуурлан 2023 онд дараах үйл ажиллагааг шинээр нэвтрүүлсэн. Үүнд:

- Монгол Улсын бүтээмжийн хорооны дэргэд Үр дүнд суурилсан удирдлагыг нэвтрүүлэх Ажлын хэсэг байгуулагдан 2023 оны 2 дугаар сард анхны хурлаа хийлээ. Гол яамдын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг нь үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын (IRBM) цахим систем нэвтрүүлэх үйл явцыг удирдлагаар хангана гэсэн хүлээлттэй байна. Төслийн зүгээс ажлын хэсэгт цахим платформын дизайн боловсруулахад техник туслалцаа үзүүлэн ажиллаж байна.
- **Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн** төслийг Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны тавдугаар сард боловсруулан баталсан аргачлалын дагуу үр дүнд суурилсан арга зүйн хүрээнд шинэчлэн боловсрууллаа. Мөн ЭЗХЯ-аас улс болон аймаг нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг баталсан бөгөөд эдгээр аргачлал нь салбар яам болон орон нутагт ажиллаж буй бодлого боловсруулагчдыг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах арга зүйгээр хангаж өгсөн. Эдгээр аргачлалууд нь шинэчлэн батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар хүчингүй болсон “ Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг орлож байна. Төслийн зүгээс арга зүйг үр дүнд суурилсан удирдлага, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулан боловсруулах, яамд болон бусад оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэгт дэмжлэг үзүүлэн ажилласан.
- Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд туссан үндэсний хэмжээний зорилтууд нь салбар болон орон нутгийн түвшинд дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын суурь болох

бөгөөд үүнд тулгуурлан яам болон хөтөлбөрийн түвшний үр дүнг ч шатлан боловсруулах юм. ХЗХ батлагдах асуудал хоёр жил гаруй хугацаанд хүлээгдэж байна. Одоогоор ХЗХ-ийн төслийг УИХ-ын 2023<sup>7</sup> оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр Засгийн газарт өргөн барихаар төлөвлөсөн байна.

- Монгол улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг ЭЗХЯ-аас үр дүнд суурилсан маягт, аргачлалын дагуу боловсруулсан. Энэ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулагдсан анхны тохиолдол тул төлөвлөгөөний төсөл боловсруулах бүх үе шатанд нийт салбар яамд болон орон нутгийн байгууллагуудын оролцоог бүрэн хангасан. Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө нь 2024<sup>8</sup>, оны тавдугаар сарын 30-ны өдөр УИХ-аар батлагдсан бөгөөд энэ нь 2024 оны улсын төсвийг үр дүнд суурилсан зарчмаар боловсруулах үндсэн нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Төслийн зүгээс үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх техник туслалцааны хүрээнд дараах аргачлалуудыг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд:

1. **Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал** (2023 оны 5 сар)
2. **Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал** (2022 оны 12 сар)<sup>9</sup>
3. **Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал**<sup>10</sup> (2023 оны 5 сар)

Төслийн баг нь дээрх аргачлалд тусгагдсан арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилсан ба мөн УЖХТ-ний төслийг тус арга зүгээр боловсруулахад хамтран ажилласан. Тус аргачлал нь ҮСНУ-ын үзэл баримтлалд тулгуурласан бөгөөд хөгжлийн төлөвлөлтийн гурван төрлийн уялдаа холбоог сайжруулахад чиглэгдсэн а) урт, дунд хугацааны бодлогыг богино хугацааны бодлогын зорилттой уялдуулах, б) босоо (үндэсний, салбарын, яамдын болон хөтөлбөрийн түвшний үр дүнгийн уялдаа) болон хэвтээ чиглэлийн үр дүнгийн уялдаа (үндэсний зорилтот үр дүнг аймгуудад хуваарилах), мөн в) төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, тайлагналыг бүх түвшинд уялдуулах.

Энэхүү аргачлал нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд шинэлэг, сүүлийн 30 жилийн хугацаанд Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг боловсруулахад хэрэглэгдэж байсан аргачлалаас ялгаатай тул бүрэн хэмжээгээр, түүштай хэрэгжээгүй байна. Төслийн 2023 оны төлөвлөлтийн үйл явцаас олж авсан, ажигласан гол сургамжуудын заримыг дурдвал:

- i) Богино, дунд, урт хугацааны бодлогын хоорондын арга зүйн уялдаа холбоо нь нэн чухал бөгөөд учир нь ийм уялдаа холбоогүйгээр нэгтгэсэн болон хосолсон хөгжлийн үр дүнд хүрэх боломжгүй юм;
- ii) Олон жилийн төсөв, хөтөлбөрт суурилсан төсөвлөлтгүйгээр бодлого, төсвийн хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх боломжгүй;
- iii) Бодлогын үр дүнг хэрэгжилтийн түвшинд хүргэхийн тулд албан хаагчдын гүйцэтгэлийн тогтолцоо болон хариуцлага механизмыг бий болгох шаардлагатай;
- iv) Зорилтод үр дүнд хүрэхийн тулд төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, ХШҮ, хэрэгжилтэд хамтарсан арга барилаар ажиллахын ач холбогдол нь бүх шатны оролцогч талуудад тодорхой болсон;
- v) Төрийн албан хаагчдын их хэмжээний механик ажлын ачаалал болон бусад хүчин зүйлсээс үүдэн мэдээллийн нэгдсэн системийн хэрэгцээ өндөр байгаа нь тодорхой болсон, тухайлбал: боловсон хүчний халаа сэлгээ; залгамж халааг төлөвлөхгүй байх; нотолгоонд суурилсан шийдвэр гаргахгүй байх, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцохгүй байх гэх зэрэг.

<sup>7</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16759902715531> (List of agenda items for Parliamentary Autumn Session 2023)

<sup>8</sup> Resolution No. 39, Parliament of Mongolia

<sup>9</sup> The methodology on formulating National ADP was approved on December 21, 2022.

<sup>10</sup> The methodology on formulating Capital and local government ADP was approved on May 8, 2023



## A.2 ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

### Төслийн дэд зорилтын хэрэгжилтийн явц

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтод түвшин 2023	Хэрэгжилт 2023
A.2.1 Төсвийн хөтөлбөрүүд бодлого, үр дүнтэй уялдсан байна	A.2.1.1. Бодлогын чиглэлийг төсвийн хөтөлбөрийн бүтэцтэй харьцуулан зураглах	0	4 салбар	<b>Хэрэгжсэн.</b> 6 ТЕЗ (ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ, СоЯ, БТСУХ and ҮАГ) 10 салбарыг хамарсан төсвийн хөтөлбөрийн бүтцийг 4 түвшний үр дүнгийн төлөвлөлтийг ашиглан уялдуулсан.
	A.2.1.2. ТХЗ-д нийцсэн хөтөлбөрийн төсвийн ангиллын шинжилгээ	0	4 салбар	<b>Хэрэгжиж байгаа.</b> 6 ТЕЗ-ын түвшинд хийсэн. ХЗХ батлагдсанаар ТХЗ-ын уялдаа хангагдана.
	A.2.1.3. ТХЗ-ын зорилтуудыг улсын төсвийн Хавсралт 1-д нэгтгэх	2 салбарын төсөл (2019)	4 салбар	<b>Хэрэгжиж байгаа.</b> 6 ТЕЗ-ын түвшинд сайжирсан.
A.2.2 ҮДСТ-ийн тайлагнал	A.2.2.1. Үр дүнгийн мэдээлэлд үндэслэсэн төсвийн тайлагнал	0	4 төсвийн гүйцэтгэлийн тайлан	<b>Хэрэгжиж байгаа.</b> 3 тайлан бэлтгэгдсэн (ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ).
A.2.3 ТХЗ-ын Иргэний төсөв	A.2.3.1. Иргэдийн төсөвт бодлогын тэргүүлэх чиглэл, үр дүнг нэгтгэх	0 (2018)	ТХЗ-ын тэргүүлэх чиглэл	<b>Хэрэгжиж байгаа.</b> 2024 оны төсөв батлагдмагц 2024 оны Иргэдийн төсөвт бодлогын тэргүүлэх чиглэл, үр дүнг тусгана

**A.2.1 Бодлого, үр дүнтэй уялдсан төсвийн хөтөлбөр.** 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Монгол Улсын төсвийн хөтөлбөрүүд нь Сангийн яамны төсөв боловсруулах систем дээр бодлого болон үр дүнтэй уялдаагүй хэвээр байна. Төсвийн гүйцэтгэлд оролцогч бүх талууд систем дээр хөтөлбөрийн түвшний КРІ болон хөтөлбөртэй холбоотой үр дүн, үйл ажиллагааг шууд харах боломжгүй байна. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлагын үнэлгээний тайланд (ДБ, 2021)<sup>11</sup> D үнэлгээ авсан цөөн үзүүлэлтүүдийн нэг юм.

Тайлант хугацаанд төсөвлөлтийг бодлого, үр дүнтэй уялдуулах чиглэлээр дараах ахиц дэвшил гаргасан. Үүнд:

- Дээр дурдсан ЭЗХЯ-наас баталсан үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлал болон сүүлийн хоёр жилийн туршилтын сургамжид тулгуурлан **үр дүнд суурилсан төсвийн заавар, маягтуудыг** 2023 онд шинэчилсэн. Үр дүнд суурилсан төсвийн шинэчилсэн заавар, маягыг Сангийн яамнаас 2024 оны төсвийн удирдамжид тусгасан. Төсвийн удирдамжид үр дүнд суурилсан есөн төсвийн маягт, болон төсвийн захирагч нарт зориулсан гурван хяналтын хуудас багтсан.

<sup>11</sup> <https://www.pefa.org/node/5006>

2024 оны Төсвийн тухай хуулийн 1-р хавсралтыг үр дүнгийн зорилтод түвшинг суурь түвшингийн хамт тусгадаг байхаар шинэчилсэн.

- Туршилтын яамдын (ХНХЯ болон ХХААХҮЯ) 2024 оны төсвийн саналыг үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалаар боловсруулахад төсөв бэлтгэх хугацаанд төслөөс дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан.
- Биеийн тамир, спортын улсын хороо, Үндэсний Аудитын Газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам зэргийг оролцуулан 2024 оны төсвийн саналыг үр дүнд суурилсан төсвийн аргачлалаар боловсруулсан яам, төсөвт байгууллагын тоо өссөн. Зарим салбар, хөтөлбөрийн төсвийн санал нь бусад хөтөлбөртэй харьцуулахад үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалтай илүү үйлдсэн. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр, нийгмийн халамжийн хөтөлбөр, мал аж ахуй хөтөлбөр, газар тариалан хөгжүүлэх хөтөлбөр, хүнс болон хөнгөн үйлдвэрийн хөтөлбөр, мал эмнэлгийн дэд хөтөлбөр, соёлын болон биеийн тамирын хөтөлбөр, хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөр болон мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр г.м.
- Дорноговь аймгийн Хөгжлийн Жилийн Төлөвлөгөө(ЖХТ)-г шинээр батлагдсан аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалаар туршиж боловсруулсан. 2024 оны аймгийн ЖХТ боловсруулах үйл явц нь өмнөх жилүүдийн зарим орон нутгийн (Завхан, Хөвсгөл болон **Дорноговь аймаг**) зарлагын шинжилгээ болон орон нутгийн төсвийн мэдээллийг санхүүгийн системд оруулах, төсвийн зарлагын бүртгэл, тайлагнал зэргийг сайжруулах хамтын ажиллагааны үр дүнд үндэслэн хийгдсэн. Дорноговь аймгийн боловсруулсан ЖХТ нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалаар үндэсний болон салбарын түвшний үр дүнд аймгийн түвшинд буулган бодлого төсвийг холбож боловсруулсан улсын хэмжээний анхны оролдлого болсон юм. Үүний дүнд, тус ЖХТ нь бүх аймаг, орон нутагт 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсөвлөлтөө хийхэд хэрэглэх, сайжруулахад туслах загвар байдлаар хэрэглэгдэх боломжтой болсон.
- Дорноговь аймгийн 2024 оны ЖХТ болон үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалаар боловсруулсан төсвийн санал нь аймгийн үр дүнд оруулах харьяа сумдын (хамгийн бага засаг захиргааны нэгж) хувь нэмэр, санал, оролцоог хангаснаараа онцлог болсон. Аймаг болон сумын бодлого төлөвлөлт, санхүүгийн албан хаагчид, СЯ-ны төлөөлөл, төслийн багийн бүтэн жилийн хамтын ажиллагааны үр дүнд аргачлалыг цаашид сайжруулахад чиглэсэн олон практик асуудлыг хөндөж, шийдвэрлэх мөн бүх оролцогч талуудад мэдлэг ойлголтоо сайжруулах, үр бүтээлтэй үйл явц болсон.
- 2023 онд төслийн баг үндэсний болон орон нутгийн түвшний төлөвлөгөө, төсөвлөлт болон тайлагналын үйл явцад оролцогч талуудыг үр дүнд суурилсан төсөвлөлтийн талаар ерөнхий ойлголт, мэдээллээр хангах зорилгоор **Үр дүнд суурилсан төсөвлөлтийн гарын авлага** боловсруулсан. Тус гарын авлага нь олон улсын сайн туршлага болох ҮДСТ/ҮДСНУ практик болон өнгөрсөн гурван жилийн хугацаанд Монгол Улсад хийгдсэн туршилтын ололт, сургамж дээр үндэслэн боловсруулагдсан. Гарын авлага нь мэргэжилтнүүдэд ажлын лавлах баримт бичиг болох зорилготой ба цаашид бусад салбаруудад болон төсөвт байгууллагуудад ҮДСТ туршилт хийгдэх тухай бүрд шинэчлэгдэнэ.
- Төсвийн ангиллыг шинэчилж албажуулах бэлтгэл ажлын хүрээнд бодлогын хөтөлбөрүүд болон одоо байгаа төсвийн хөтөлбөрүүдийн харьцуулсан хүснэгт боловсруулагдсан. Одоо байгаа

төсвийн хөтөлбөрүүдийг ЗГБЧҮ ангилалд суурилан үр дүнд чиглэсэн, бодлогын хөтөлбөрийн ангилал болгож солих эсвэл шинэчлэх нь маш их ажиллагаатай. Хэд хэдэн шатлал бүхий бүтэцтэй төсвийн ангиллыг шинэчлэх эхний санал боловсруулагдсан ба цаашид холбогдох салбаруудын оролцогч талуудтай хэлэлцүүлэхээр бэлтгэгдээд байна.

- Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлал нь салбаруудын хэрэгжүүлэх бодлогын хяналт болон үнэлгээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн тогтвортой байх шаардлагатай. 2023 онд тус хоёр аргачлалыг үялдуулахад чиглэсэн эхний алхмууд болох Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газартай хамтарсан сургалт болон хэлэлцүүлэг уулзалтууд хийгдсэн.

**А.2.2 Үр дүнд суурилсан төсвийн хяналт шинжилгээ, тайлан:** Үр дүнд суурилсан төсвийн тайлагналын системийг сайжруулж байна. Тухайлбал, үр дүнд суурилсан төсвийг хэрэгжүүлэх нэг гол ахиц дэвшлийн цэг нь санхүүгийн гүйцэтгэлийн мэдээлэл (төсвийн гүйцэтгэлийн тайлан) бүхий хөтөлбөрийн гүйцэтгэлийн үйл явцыг толилуулах явдал юм. Тус тайланг өнгөрсөн хугацаанд бодлогын хөтөлбөр болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн мэдээлэл хангалтгүйн улмаас боловсруулахгүй байсан.

Тайлагналын хугацаанд, СЯ-ны Төрийн сангийн газрын манлайлал дор төслийн баг үр дүнд суурилсан төсвийн хяналт-шинжилгээ болон тайлагналд чиглэсэн дараах ажлуудад үе шаттай ахиц гарган ажиллаад байна. Үүнд:

- 2023 онд засгийн газрын хяналт-шинжилгээ ба үнэлгээний систем болон төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлагналын системүүдийг үялдуулахын тулд **бизнес процессын шинжилгээ** хийсэн. Судалгааг төрийн сангийн нягтлан бодогчдын дүнд хийсэн ба түршилтын яамдын (ХНХЯ ба ХХААХҮЯ) төлөвлөлт, төсөвлөлтийн баримт бичгээс кейс судалгаа хийсэн. Тус шинжилгээгээр үйл явц бүрд заавар удирдамж, хариуцах албан хаагчид болон цагалбар зэрэг нь нэгдсэн биш, уялдаа хамааралгүй байгааг олж тогтоосон. Тухайлбал, 2020, 2021 оны УЖХТ-нд тодорхойлсон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, түүний зорилтот түвшин нь төсвийн тухай хуулийн хавсралт 1-д тодорхойлсон үзүүлэлтээс зөрүүтэй байсан. Үүний нэгэн адил, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь бодлогын болон төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл агуулдаггүй бөгөөд тэдгээрийг нэгтгэх болон тохируулах үйл явц хэвшээгүй байна.
- 2023 онд ХНХЯ болон ХХААХҮЯ-ны тодорхойлсон үр дүн болон шалгуур үзүүлэлтэд үндэслэн үр дүнд суурилсан төсвийн тайлагнал болон гүйцэтгэлийн тайлагналын аргачлал, маягыг боловсруулах зорилгоор **Үр дүнд суурилсан төсвийн тайлагналын кэйс судалгаа** хийгдсэн. Тус судалгаагаар гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, түүний зорилтот түвшинг сайжруулж, үялдуулахаас гадна мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах давтамж, цагалбарыг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гүйцэтгэлийн мэдээтэй үялдуулах шаардлагатай талаар зөвлөмж санал болгосон.
- СЯ-ны Төрийн сангийн хэлтэст үр дүнд суурилсан **төсвийн болон гүйцэтгэлийн тайлагналын аргачлалын** төслийн хувилбарыг боловсруулахад төслийн зүгээс дэмжиж ажилласан. СЯ тус аргачлалын маягт болон арга зүйг хянаж байгаа бөгөөд аргачлал нь жилд хоёр удаа төсвийн тайлагнал хийхэд удирдамжаар хангах юм.
- Түршилтын яамд болох ХНХЯ болон ХХААХҮЯ-ны 2023 оны эхний **хагас жилийн үр дүнгийн мэдээлэл бүхий төсвийн гүйцэтгэлийн тайлангийн** төслийг шинэ аргачлал, маягтын дагуу боловсруулсан. Тус тайлангийн олон нийтэд хүртээл болгох хэвлэмэл хувилбар хийгдэж байна.

10 сарын 18-ны өдөр тайлангийн үр дүнг ХНХЯ болон ХХААХҮЯ-ны удирдлага болон бодлого төлөвлөлт, төсөв болон төсвийн тайлагнал хариуцдаг албан хаагчдад толилуулсан. Нийтдээ 89 оролцогчид тус үүлзалт хэлэлцүүлэгт оролцсон ба үйл ажиллагааны хүрээнд тулгарч буй сорилт, цаашид сайжруулах шийдлийн талаар санал солилцсон. **2022 оны боловсролын салбарын төсвийн тайлагнал болон гүйцэтгэлийн тайлан** боловсруулагдсан. Энэ нь төсвийн тухай хуулийн 54.5 зүйлд заасан шаардлагад нийцсэн, санхүүгийн болон гүйцэтгэлийн мэдээллийг холбосон салбарын төсвийн хөтөлбөрийн анхны удаагийн тайлан болсон. Энэ явцад цаашид сайжруулах шаардлагатай олон зүйлс тодорхойлогдсон боловч дээр дурдсанчлан тус тайлан нь цаашдын 2024, 2025 оны төлөвлөлт, төсөвлөлт болон тайлагналын циклийн урьдач болон суурь чухал мэдээллийг агуулснаараа онцлогтой.

- Төслийн дэмжлэгтэйгээр, Төрийн сангийн хэлтэст яам, хөтөлбөр болон арга хэмжээ бүхий төсвийн болон гүйцэтгэлийн тайлагналыг холбох цахим системийн бүтэц болон хөгжүүлэлтийн судалгаа хийгдэж эхлээд байна. Санал болгох цахим системийн бүтэц нь давхардсан, уялдаа холбоогүй үйл явцаас сэргийлэх үүднээс Засгийн Газрын Удирдлагын Мэдээллийн Системтэй шууд холбогдох зорилготой.

**А.2.3 ТХЗ-ын Иргэний төсөв.** Хүлээгдэж буй үр дүн, түүнд хуваарилсан төсвийн талаарх мэдээллийг салбар, яамдаар энгийн хэлбэрээр олон талын оролцогч талуудад ойлгомжтой, ашиглахад хялбар хэлбэрээр танилцуулах нь улсын болон орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах нэг чухал асуудал юм. ТЗСХҮ-ний тайланд (2021) “Шилэн данс, тэр дундаа төрийн цахим хуудсанд иргэдэд чиглэсэн төсвийн баримт бичиг, мэдээллийн хүртээмж өндөр байгааг онцлон тэмдэглэсэн боловч “Засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал байгааг онцолсон. Тиймээс засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл тэр бүр ил тод байдаггүй. Түүнчлэн, хөтөлбөрүүдийг ангилах арга нь олон улсын жишигт бүрэн нийцсэн төрийн чиг үүргийн нөөцийн хуваарилалтын харьцуулсан дүн шинжилгээг дэмждэггүй.”<sup>12</sup> гэж онцолсон байна.

Тайлангийн хугацаанд төсөл нь Сангийн яамны төсвийн ил тод байдлын хангах санаачилгад дэмжлэг үзүүлэн Иргэдийн ТХЗ-ын төсвийн хүрээнд дараах ахиц дэвшлийг гаргасан. Үүнд:

- 2022 онд төсөл нь 2023 оны төсвийн талаар үр шим хүртэгчийн байр сууринаас мэдээлэл агуулсан “Иргэний төсөв” товхимлыг бэлтгэхэд СЯ-нд дэмжлэг үзүүлсэн. “Иргэний төсөв” товхимлыг шинэчлэн, ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжих хөтөлбөрүүд дэх төсвийн хуваарилалтын зураглалыг тусгасан. 2024 оны Иргэдийн төсөв” товхимол гарсан.
- ТХЗ-ын тэргүүлэх салбарыг хариуцсан яамдын талаарх мэдээллийг харуулсан **төсвийн хуваарилалтын хяналтын самбарыг** нийтийн хэрэгцээнд зориулан боловсруулж байна. Хяналтын самбарыг Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан үзэх боломжтой бөгөөд яамнаас гарсан үр дүн, хөтөлбөрийн гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтуудын талаар мэдээлэл агуулсан байна.

### А.3 НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ

Төслийн дэд зорилтын хэрэгжилтийн явц

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтод түвшин 2023	Хэрэгжилт 2023
------------	------------------	--------------	----------------------	----------------

<sup>12</sup> <https://www.pefa.org/node/5006>

А.3.1 Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын дэмжих салбарын төсвийн зарлага, институтийн шинжилгээ	А.3.1.1. ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийн салбарын төрийн үйлчилгээ, төсвийн үр нөлөө, өгөөжийг судлах	0	1	<b>Хэрэгжиж байгаа.</b> Өмнөх жилийн зардлын тойм судалгаанд үндэслэн ХЭДХ болон ХЭДС-н төлөвлөлт, санхүүжилт, хуваарилалтын журамд өөрчлөлт оруулсан.
	А.3.1.2. Нотолгоонд суурилсан төсөв боловсруулах төсвийн зарлагын болон институтийн шинжилгээ	0	1 PEIR on SDG priority sector	<b>Хэрэгжиж байгаа.</b> Хүүхэд хамгаалал, соёл урлаг, биеийн тамирын чиглэлээр 3 ТЗШ боловсруулсан. Дорноговь аймгийн жишээн дээр тулгуурлан орон нутгийн төсвийн зарлагын судалгаа хийсэн.
А.3.2. Салбарын хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлийг сайжруулна	А.3.2.2 Тэргүүлэх чиглэлийг тогтоох, ДХЗХ-тэй уялдуулах хүрээнд ажлын байран дээрх дэмжлэг үзүүлэх	0	1 салбар	<b>Хэрэгжиж байгаа.</b> Аргачлалын төслийг боловсруулж байна.
	А.3.2.3. ТСУ-ын стратегитай уялдуулан төслийн үнэлгээ, сонгон шалгаруулах арга зүйг сайжруулах	-	арга зүйг нэвтрүүлэх	
А.3.3. Бодлогын өртөг тооцоололтыг сайжруулах	А.3.3.1. Үндэсний хөтөлбөрүүдийн зардлын тооцоолол хийх	3 тооцоог хийсэн	ТХЗ-ын салбаруудын өртөг тооцоолол хийх	<b>Хэрэгжиж байгаа.</b> ХЭДХ-ийн жишиг зардлыг зах зээлийн ханшид тулгуурлан дахин тооцоолсон. Бодлогын өртөг тооцох судалгаа хийсэн.

**А.3.1. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын дэмжих салбарын төсвийн зарлага, институтийн шинжилгээ.** Нийгмийн тодорхой зорилго, зорилттой (Жишээ нь: ТХЗ-ын тодорхой хүрээнд) хамаарах бодлогын болон зарлага, институтийн төлөв байдлын цогц дүн шинжилгээ хийх нь Сангийн яам, салбарын яам зэрэг гол оролцогч талуудад Дүнд хугацааны зарлагын хүрээ болон жилийн төсвийн тодорхой чиглэл, зөвлөмжөө боловсруулахад үр дүнтэй хэрэгсэл болно.

Тайлангийн хугацаанд нотолгоонд суурилсан төсвийн төлөвлөлтөд шаардлагатай судалгаа, өгөгдөл, нотлох баримтыг цуглуулах, дүн шинжилгээ хий, боловсруулах чиглэлд дараах ахиц дэвшил гарсан. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гүйцэтгэл, хүртээмж, үйлчилгээг хүргэх арга хэлбэрийг сайжруулах зорилгоор 2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөр арга хэмжээний загварчлал, түүний үр ашгийн судалгааг хийсэн. Энэ нь 2022 онд төслийн хүрээнд хийгдсэн **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ**- гэсэн судалгааны ажлын зөвлөмжийн дагуу хийсэн судалгаа юм. 2023 онд хийгдсэн ХЭДС-ын гүйцэтгэл, хүртээмж, үйлчилгээг хүргэх арга хэлбэрийг сайжруулах судалгааны үр дүнд, зөвлөмж боловсруулж хэд хэдэн арга хэмжээг авсан.

i) **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны төсвийн төсөлд** гурван аймгийн (Дорноговь, Өвөрхангай, Орхон) 2023 оны төсвийн саналаа ҮДСТ-ийн зарчим, арга барилыг ашиглан, ХЭДС-ийн судалгааны үр дүнг тусгаж түршилтын журмаар боловсруулсан. Түршилтын үр дүнг СЯ, ХНХЯ-нд танилцуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бусад аймаг, дүүрэг түршилтын аргачлалыг нэвтрүүлэхээр тохиролцсон.

ii) ХЭДС-ийн санхүүжилтийн хуваарийг хөнгөвчлөх зорилгоор аймаг, дүүрэгт ХЭДС-ийн дэд сангуудыг бий болгосон.

iii) **ХЭДС-ны төсвийн төлөвлөлтийн саналыг бэлтгэх журмыг** боловсруулж, цаашид хэрэгжүүлэхээр баталсан. Энэхүү журам нь ҮДСТ-ийн зарчим, агуулгын багтаасан журам юм.

iv) **ХЭДХ-ийн гол арга хэмжээний жишиг зардлыг** шинэчлэн, ХНХЯ-аар батлуулсан. Энэхүү шинэчилсэн жишиг зардлын дагуу ХЭДС-ийн 2023 төсвийн төслийг боловсруулсан.

v) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны төсвийн төслийг доороос дээш төсвийн саналыг нэгтгэх аргачлалын дагуу аймаг, дүүрэг тус бүрийн саналд үндэслэн боловсруулсан. Төсвийн төлөвлөлт, төсөв боловсруулах үйл явцад орон нутгийн нийт байгууллагуудын удирдлага, албан хаагчид идэвх, санаачилгатай оролцон, саналаа цаг хугацаанд ирүүлж амжилттай ажилласан. Энэхүү сайжруулсан доороос дээш төсвийн төлөвлөлтийг боловсруулах туршилтын үр дүнд орон нутгийн хүн ам зүйн статистик мэдээлэлд үндэслэсэн, орон нутаг бүрийн бодит хэрэгцээ, эрэлт шаардлагыг харгалзсан ХЭДС-ын 2023 оны төсөв боловсруулагдсан. Төслийн зүгээс Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүрэг дэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, нийслэлийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хөтөлбөрийн үр дүн, гарц, гол шалгуур үзүүлэлтүүдийг үнэн зөв тодорхойлох замаар ХЭДС-ын төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгоход дэмжлэг туслалцааг тасралтгүй үзүүлж ажиллаж байна. Мөн түүнчлэн, төслийн хүрээнд Дорноговийн **Айраг сум** (сум - засаг захиргааны хамгийн жижиг нэгж)-д үр дүнд суурилсан зарчим, арга барилд нийцүүлэн ХЭДС-ийн төсвийн төслийг боловсруулсан.

- **Төсвийн зарлагын шинжилгээ:** Төслийн нэгж болон Засгийн газар, УИХ-ын байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хамтаар бусад талуудаас ирэх хамтын ажиллагааны хүсэлт, санаачлаг болон идэвх өсөж байна. Төслийн хүрээнд 2023 онд **соёл, биеийн тамир, хүүхэд хамгааллын** гэсэн гурван салбарт төсвийн зарлагын шинжилгээг хийж, байгаль орчин, эрчим хүчний салбарын зарлагын шинжилгээг мөн гүйцэтгэх бэлтгэл ажил хангагдаж байна.

ТЗИШ-ний чанарыг сайжруулахын тулд төсөл нь олон улсын сайн туршлага, арга зүйг тусгасан **Төсвийн зарлага, институтын шинжилгээний арга зүйн гарын авлагыг** боловсруулсан. Түүнчлэн, төрийн бүтээмж, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх боломжит шийдлүүдийг санал болгох зорилгоор төрийн албан хаагчийн ажлын чиг үүрэг, бүтэц, тэдгээрийн давхцал, давхардал, дутагдлыг хянах нарийн арга/аргачлалаар хангах **чиг үүргийн хяналтын удирдамжийг** боловсруулсан. Энэхүү санал болгож буй чиг үүргийн удирдамжийг Дорноговь, Орхон, Өвөрхангай аймагт **чиг үүргийн шинжилгээ** хийж туршсан ба туршилтын явцад гарсан сайжруулах санал зөвлөмжийг тусган удирдамжийг эцэслэн боловсруулна.

**А.3.3 Бодлогын өртөг тооцох аргачлалыг сайжруулсан.** Хөтөлбөрийн төсөв тооцоход, бодлогын түвшинд буюу дээд шатанд хөтөлбөрт нөлөөлөх төсвийн тооцооллыг хийх, мөн доороос дээш нарийвчилсан хөтөлбөрийн өртгийн тооцоолол хийх аль аль нь төсөв боловсруулах үйл явцыг саадгүй, уялдаатай, үр дүнтэй явуулахад гол үүрэг гүйцэтгэдэг. Зардлыг тооцох боловсронгуй процесс болон бодлогын эрэмбэлэлт хийх үйл явц (А.3.2)-ийг хослуулснаар дээд түвшний төсвийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангана. Бодлогын өртөг тооцох нь Монгол Улсын хувьд ялангуяа төсвийн шийдвэр гаргалттай холбоотой шинэ ойлголт юм.

Тайлангийн хугацаанд төсөл нь бодлогын өртгийг сайжруулах чиглэлд дараах ахиц дэвшил гаргасан. Үүнд:

- **Хөдөө аж ахуйн татаасын судалгааг** эцэслэн боловсруулж, цаашид нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-нд танилцуулсан. Судалгааны үр дүн ЭЗХЯ болон УИХ-ын Төсвийн шинжилгээний албаныхны сонирхлыг татаж, ЭЗХЯ-ны хүсэлтийн дагуу 2023 онд татаасаас гадна хэрэгжүүлж болох бодлогын хувилбарын өртөг тооцох судалгааг эхлүүлсэн. ҮДСТ-ийн зарчмын дагуу байнга хийгдэж байх шаардлагатай, хөдөө аж ахуйн татаасны өнөөгийн байдал, бодлогын үр нөлөөнд суурь судалгаа, үнэлгээ хийх ажлыг эхлүүлээд байна.
- **Бодлогын өртгийг тооцох судалгааг** 2023 онд Монголд анх удаа хийсэн бөгөөд энэхүү судалгаанд бодлогын өртөг тооцох тухай ерөнхий ойлголт, түүний зорилгыг, хэрэглээг тайлбарлаж, олон улсын сайн туршлагад тулгуурлан, бодлогын өртөг тооцох боломжит арга зүй, нэвтрүүлэх аргачлалыг санал болгосон. Бодлогын өртөг тооцох нь ирээдүйн шийдвэр гаргах процесст гүйцэтгэх үүрэг жил бүр нэмэгдэж, ялангуяа их хэмжээний төсвийн зардал шаардсан бодлогын арга хэмжээний хувьд найдвартай аргачлалыг ашиглан бодлогын өртөг тооцож, шийдвэр гаргалыг дэмжих сайн жишээг харуулах нь Төслийн тэргүүлэх чиглэл хэвээр байна.

#### А.4 ТХЗ, ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХАД САНГИЙН ЯАМ БА САЛБАРЫН ЯАМДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

##### Төслийн дэд зорилтын хэрэгжилтийн явц

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтод түвшин 2023	Хэрэгжилт 2023
А.4.1 Стратегийн Зөвлөх үйлчилгээ үзүүлнэ	А.4.1.1. Стратегийн зөвлөлдөх хороо (СЗХ)-ны уулзалтууд зохион байгуулж Зөвлөмж гаргах	0	1 уулзалт	<b>Хэрэгжсэн.</b> Стратегийн уулзалт 4-р сарын 4-нд болсон (Үр дүнд суурилсан удирдлагын ажлын хэсэг Улсын бүтээмжийн хорооны дэргэдэх)
А.4.2. Бүсийн сургалт, танилцах аялал зохион байгуулна	А.4.2.1. ДХЗХ-ний асуудлаар чадавх бэхжүүлэх, мэдлэг мэдээлэл солилцох	-	1 танилцах аялал	<b>Хэрэгжиж байгаа.</b> 2023 оны сүүлийн улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна
А.4.3 Ажлын байранд чадавх бэхжүүлэх сургалт явуулна	А.4.3.1. ҮДСТ-ийн хүрээнд СЯ, салбарын яамдын албан хаагчдад зориулсан сургалт	0	4	<b>Бүрэн хэрэгжсэн.</b>

**А.4.1. Стратегийн Зөвлөх үйлчилгээ.** Стратегийн зөвлөх үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилго нь үндэсний хамтрагч талуудын оролцоог үр дүнд суурилсан төсөвлөлт болон ДХЗХ-г амжилттай нэвтрүүлсэн олон улсын сайн туршлага дээр үндэслэсэн шинэчлэлийн стратегийн замын зураглалыг тодорхойлох үйл явцад дэмжлэг үзүүлэхэд оршино. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2023 оны 3 дугаар сарын 2 дугаар тогтоолоор Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх салбар дундын, өндөр түвшний зохицуулалтын механизмыг Ажлын хэсэг хэлбэрээр байгуулж, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөв, тайлагнал, ХШҮ, нэгдсэн тоон

системийг нэвтрүүлэх төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдан зохион байгуулах, үялдуулах үүрэг хүлээсэн.

Ажлын хэсгийн **зөвлөлдөх уулзалтыг** 2023 оны 4-р сард ЭЗХЯ-аар ахлуулсан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, СЯ, ЗГХЭГ, төслийн багийн төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Ажлын хэсэг нь бүтэн жилийн турш идэвхтэй ажилласан бөгөөд үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын системийн дижитал архитектурыг тодорхойлох ажлын даалгаврыг боловсруулснаар эхлээд байна.

**А.4.3. Ажлын байран дахь чадавх бэхжүүлэх сургалт.** Тайлангийн хугацаанд, дараах хоёр чиглэлээр хамтрагч талуудтай мэдлэг, мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Үүнд:

i) ДХЗХ/ДХТХ болон үр дүнд суурилсан удирдлагын тогтолцооны үзэл баримтлал, арга зүйн талаар суурь ойлголт, танилцуулга, сургалт, семинар, зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Энэ хүрээнд нийт 32 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, салбарын яамд, орон нутгийн засаг захиргааны нийт 1,895 төрийн албан хаагчдыг (733 эрэгтэй, 1162 эмэгтэй) хамруулсан байна. Тухайлбал, 165 удирдах түвшний албан хаагчид 2023 оны 01 дүгээр сард зохион байгуулсан 2024 оны улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалтад хамрагдаж, Дорноговь аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний сургалтад 76 албан хаагч (51 эмэгтэй, 25 эрэгтэй) хамрагдсан байна.

2023 оны 5 болон 6 дугаар сард зохион байгуулсан сургалтад үр дүнд суурилсан төсөв боловсруулах шинэ маягыг нэвтрүүлэх хүрээнд илүү анхаарч, салбарын яам, 21 аймаг, нийслэл, дүүргийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нийт 1,168 төрийн албан хаагч (475 эрэгтэй, 663 эмэгтэй) хамрагдсан байна.

ii) Бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналын аргачлал боловсруулах, аргачлалын дагуу төсөл бэлтгэх хүрээнд ажлын байран дээр холбогдох талуудтай хамтран багаар ажиллахад дэмжлэг үзүүлж ажиллав. Энэ хүрээнд үр дүнд суурилсан удирдлагын зарчим, үзэл баримтлалын дагуу үндэсний, салбарын, ТЕЗ-ын, хөтөлбөрийн шаталсан түвшинд үр дүн, холбогдох шалгуур үзүүлэлтүүд, суурь болон зорилтод түвшинг холбогдох талуудтай хамтран тодорхойлоход чиглэгдэж ажилласан.



## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ В. ТӨСВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсвийн хяналт, ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх гурван үндсэн чиглэлийг тусгасан. Үүнд:

- В.1 Төсвийн хяналтад УИХ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- В.2 Төсвийн шинжилгээ, гүйцэтгэлд хяналт тавихад ИНБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- В.3 Гүйцэтгэлийн аудитыг бэхжүүлж ил тод байдлыг хангах

### ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮР ДҮН – ТӨВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

Төслийн зорилт 2-4-т оруулсан хувь нэмэр:

Зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2023)	Хэрэгжилт 2023
Зорилт 2: ҮДСТ, Бодлого, төсвийн уялдааг хангахад УИХ-н хяналтыг сайжруулах	Үр дүнд суурилсан төсөв, зардлын үр дүнтэй байдлын талаар хийсэн төсвийн сонсголын тоо	0	4	<b>Хэрэгжиж байна.</b> Үр дүнд суурилсан төсөв болон зардлын үр дүнтэй байдлын талаарх төсвийн сонсгол албан ёсоор зохион байгуулагдаагүй, харин төсвийн хэлэлцүүлгүүд хийгдсэн.
Зорилт 3: ИНБ-ын төсөвт тавих хяналт	Төсвийн хэрэгжилтийн байдалд нь ИНБ-аас хяналт-шинжилгээ хийсэн салбар/яамны тоо (хувь)	0	4	<b>Хэрэгжиж байна.</b> Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд гүйцэтгэлийн аудит хийх ажилд ИНБ-ууд оролцсон.
Зорилт 4: ТХЗ-н хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит хийх	ТХЗ-ын тэргүүлэх ач холбогдолтой салбар, хөтөлбөрт хийсэн гүйцэтгэлийн аудитын тоо	0	2	<b>Хэрэгжсэн.</b> 3 гүйцэтгэлийн аудит хийгдсэн.

### В.1. ТӨСВИЙН ХЯНАЛТАД УИХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2023)	Хэрэгжилт 2023
В.1.1. Үр дүнд суурилсан бодлогын шинжилгээ, хяналт	В.1.1.1. Бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх	0	4 салбар	<b>Хэрэгжиж байна.</b> Төсвийн сахилга бат, ил тод болон хариуцлагатай байдлыг сайжруулах зорилгоор хийгдсэн судалгаанаас гарсан сургамж, ололтыг Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан. Бодлогын шинжилгээ, судалгаа 3 чиглэлээр хийгдэж байна.
	В.1.2.2. Төсвийн зарлагад үр өгөөжийн үнэлгээ хийх	0	1	<b>Хэрэгжиж байна.</b> УИХ-ын төсвийн хяналтын чиг үүргийг сайжруулах

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2023)	Хэрэгжилт 2023
В.1.2 Үр дүнд суурилсан төсвийн хяналт, шинжилгээ	(Нэгдсэн төсвийн 2 дугаар хавсралт)			зорилгоор ХЭДХ/ХЭДС болон ХАА-н татаасын зардлын үр дүнтэй байдалд хийсэн судалгааны үр дүнг УИХ-д танилцуулсан.
	В.1.2.3. Салбар, хөтөлбөрийн зарлагын шинжилгээг байнгын хороодоор хэлэлцүүлэх	0	2	<b>Хэрэгжсэн.</b> Хөдөлмөр, хөдөө аж ахуйн зарлагын шинжилгээг УИХ-ын Тамгын газарт хүлээлгэн өгч танилцуулсан.
	В.1.2.4. Зардлын үр ашигтай байдлын талаар төсвийн сонсгол хийх	0	4 бодлогын хэсэгт	<b>Хэрэгжиж байна.</b> Төсвийн сонсгол зохион байгуулагдаагүй, харин түршилтын яамд дээр хийсэн зардлын шинжилгээ болон 2024 оны төсвийн төслийн ерөнхий танилцуулгыг УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтэст хүргүүлэн УИХ-ын гишүүдэд танилцуулсан.
	В.1.2.5. Зарлагын чиг хандлагын шинжилгээний дүгнэлт бүхий товч мэдээллийг УИХ-ын гишүүдэд тогтмол хүргүүлж байх	0	1 шинжилгээ	<b>Хэрэгжиж байна.</b> Түршилтын яамд дээр хийсэн зардлын шинжилгээ болон 2024 оны төсвийн төслийн ерөнхий танилцуулгыг УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтэст хүргүүлэн УИХ-ын гишүүдэд танилцуулсан.
В.1.3. Бодлого, төсвийн нягт уялдааг хангахад УИХ-аас тавих хяналт	В.1.3.1 УИХ-аас баталдаг ДХТТ болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн уялдааг хангах чиглэлээр судалгаа хийх	0	1 судалгаа	<b>Хэрэгжиж байна.</b> Үндэсний болон орон нутгийн ЖХТ-г УИХ-ын холбогдох газруудад танилцуулсан.
	В.1.3.2. ДХТТ болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөр баримт бичгүүдийн уялдааг хангах аргачлалын гарын авлага боловсруулах	0	1	<b>Хэрэгжиж байна.</b> Бодлого төсвийн уялдааг хангах гарын авлагыг боловсруулж байна.
	В.1.3.3. Санхүүгийн болон үр дүнгийн гүйцэтгэлийн мэдээллийг ашиглан, төсвийн гүйцэтгэлийн өөрчлөлтийг судлах	0	2 тайлан	<b>Хэрэгжиж байна.</b> Түршилтын яамдуудын үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайланг УИХ-ын байнгын хороодод танилцуулахаар төлөвлөж байна.
В.1.4 Төсөвт хяналт тавих УИХ-ын чадавхыг сайжруулах	В.1.4.1. Жилийн төсвийн төслийн талаарх гарын авлага боловсруулах	0	1	<b>Хэрэгжиж байна.</b> Гарын авлагыг шинэчлэн боловсруулж байна.
	В.1.4.2. Мэдээлэл солилцох, туршлага судлах арга хэмжээг дэмжих	0	1 танилцах аялал	<b>Хэрэгжиж байна.</b> 2024 оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар ажиллаж байна.

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2023)	Хэрэгжилт 2023
	В.1.4.4. УИХ-ын гишүүдэд сургалт зохион байгуулах	0	1 сургалт	Хэрэгжиж байна. 3 сургалт зохион байгуулагдсан.

**В.1.1. Үр дүнд суурилсан бодлогын шинжилгээ ба хяналт. В.1.2. Үр дүнд суурилсан төсвийн хяналт, шинжилгээ. В.1.3 Бодлого, төсвийн уялдааг хангахад УИХ-аас тавих хяналт.**

Улсын Их Хурлаас батлагддаг хууль тогтоомж, бодлого болон шийдвэрүүдийн хэрэгжилтэд тавих хяналт, төсвийн төслийг нягтлан шинжлэх, ҮАГ-аас гаргасан тайлангийн зөвлөмжийг хэлэлцэх зэрэг арга хэмжээ нь УИХ-аас хийгддэг өдөр тутмын хяналтын ажлуудын нэг хэсэг юм.

Төсөл нь УИХ-аас гүйцэтгэх дээрх хяналт, хэлэлцүүлгийг үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхээр зорьж байгаа бөгөөд ингэснээр УИХ-ын гишүүд бодлого, төсвийн уялдааг хангах талаар илүү сайн ойлголттой болох юм. Төсвийн байнгын хорооноос бэлтгэх төсөв болон зарлагын шинжилгээ, зарлагын үр ашгийн талаарх төсвийн сонсголыг ҮДСТ-ийн зарчимд нийцүүлэн зохион байгуулах цаашлаад УИХ-ын гишүүдэд зориулан бэлтгэсэн зарлагын чиг хандлагын шинжилгээний тайлан, дүгнэлт бүхий танилцуулгыг УИХ-ын гишүүдэд тогтмол мэдээлэлдэг байх зэрэг арга хэмжээнүүд нь бодлого төсвийн уялдааг хянах гол арга хэрэгслүүд юм.

УИХ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний газар, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс болон Төсвийн байнгын хороо нь дээрх үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэх гол хамтрагч талууд юм.

Тайланд хугацаанд төсөл нь үр дүнд суурилсан бодлого, төсвийн шинжилгээ, хяналт болон бодлого төсвийн уялдааг сайжруулах үйл ажиллагаанд дараах ахиц дэвшил гаргасан. Үүнд:

- Үр дүнд суурилсан байдлаар ТХЗ-той холбогдох гурван тэргүүлэх сэдвээр бодлогын шинжилгээ хийгдэж байна: 1) Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг боловсруулах зорилгоор нэгдсэн төсвийн орлогын шинжилгээ, тооцоолол (ДХТТ/ДХГХ); 2) ЖДҮ-ийг дэмжих бодлогын судалгаа (10 тэрбум төгрөгийн зээл) мөн 3) Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээний бодлогын шинжилгээ. Уг гурван судалгаанаас гарах үр дүнг УИХ-д танилцуулах ба үр дүнд суурилсан бодлогын хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглагдах жишиг судалгаа болох юм.
- Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн мэргэжилтнүүд болон бусад холбогдох оролцогч талуудад хэрэгтэй бодлогын өртөг тооцох аргачлал боловсруулах ажил хийгдэж байна.
- УИХ-ын Төсвийн байнгын хорооны санаачилга болон Төслийн дэмжлэгтэйгээр төсвийн тогтвортой байдал, сахилга бат, ил тод болон хариуцлагатай байдлыг сайжруулах зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэсэн. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгийг ТБХ-ны манлайлал, удирдлага дор 2023 оны 4 дүгээр сард оролцогч талуудын дунд зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт бодлого боловсруулагчид, судалгааны байгууллага, олон улсын байгууллага, банк санхүүгийн байгууллага, ИНБ, ажил олгогч эзэд болон үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбоодын төлөөллүүд тус тус оролцсон. Хуулийн нэмэлт, өөрчлөлт 2023 оны 7 дугаар сард УИХ-аар батлагдсан.
- Төсвийн хяналт, олон нийтийн оролцоо: олон улсын харьцуулсан **судалгааны тайланг** боловсруулсан.

- ‘Төсвийн хяналтын нийтийн сонсгол, төсвийн нээлттэй хэлэлцүүлэг’ гарын авлагыг үр дүнд суурилсан ойлголтод үндэслэн олон нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг илүү үр ашигтай зохион байгуулахад УИХ-д дэмжлэг үзүүлэх зорилгоор бэлтгэсэн.
- Туршилтын яамдууд болон салбарт тулгарч буй асуудлууд, хөтөлбөрийн өнөөгийн явц байдал, ҮДСТ-ийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, институцийн чадавхыг сайжруулах цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөн төсөвт хяналт тавих УИХ-ыг үүргийг нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ” болон “Хөдөө аж ахуйн дэмжлэг урамшууллын судалгааны тайлан”-г УИХ-ын Тамгын газрын мэргэжилтнүүдэд 9 дүгээр сард танилцуулсан.
- ХНХЯ болон ХХААХҮЯ-ний холбогдох хөтөлбөрүүдийн 2024 оны төсвийн төслийн танилцуулгыг бэлтгэсэн. Мөн төсөвт хяналт тавих чиг үүргийг сайжруулах зорилгоор хоёр зарлагын шинжилгээг бэлтгэн УИХ-ын Тамгын газар болон Төсвийн байнгын хороонд танилцуулсан.
- Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн мэдээг анх удаа боловсруулсан ба УИХ-ын байнгын хороодод танилцуулахаар ажиллаж байна. Мөн Төсөл нь УИХ-ын гишүүдэд зориулсан ҮДСТ-ийн талаарх гарын авлагыг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.

**В.1.4. УИХ-ын Төсөвт хяналт тавих УИХ-ын чадавхыг сайжруулах.** Олон удаагийн 2 талт хамтарсан уулзалт болон хамтран ажиллах төлөвлөгөө батлагдсаны үр дүнд 2023 оноос эхлэн Төсвийн байнгын хороо, Хяналт шинжилгээ, үнэлгээний газар, болон УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэстэй нягт хамтын ажиллагааг өргөжүүлсэн.

Төсвийн байнгын хороо, Хяналт шинжилгээ, үнэлгээний газар, болон УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс нь 2023 оны 4 болон 6 дугаар саруудад тус тус зохион байгуулагдсан 2 удаагийн сургалтад идэвхтэй оролцож төслөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга, аргачлалын талаар сайн ойлголттой болсон. Тухайн **сургалт** нь үр дүнд суурилсан төсвийн хяналтыг институцийн түвшинд нэвтрүүлэх цаашдын хамтын ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход ач холбогдолтой байсан. Тус сургалтад нийт 109 оролцогч хамрагдсан ба үүнээс 44 нь эрэгтэй, 65 нь эмэгтэй байсан.

Мөн орон нутгаас сонгогдсон төлөөлөгчид болох Дорноговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдэд зориулсан үр дүнд суурилсан удирдлага, орон нутгийн төлөвлөлт, төсөвлөлт болон тайлагналын талаарх сургалтыг ‘Үр дүнд суурилсан удирдлага’ 2023 оны 9 дүгээр сард зохион байгуулсан. Ойролцоогоор 120 орон нутгийн гишүүн, төлөөлөгч сургалтад оролцсон.



*Зураг 1: ‘Үр дүнд суурилсан менежмент’ сургалт семинар, Дорноговь аймаг, 2023 оны 9-р сар*

## В.2 ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХАД ИНБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

### Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2023)	Хэрэгжилт 2023
В.2.1 Салбарын бодлогын шинжилгээ хийх	В.2.1.1. Бодлогын үр нөлөөний талаар хамтарсан судалгаа хийх	0	1 Бодлогын бичиг баримт	<b>Хэрэгжиж байна.</b> 2024 оны төсвийн төсөлд аудит хийх ажилд ИНБ-ын оролцоог ханган судалгааны тайланг УАГ-т хүргүүлсэн.
В.2.2 Төсөвт ИНБ-ын тавих хяналт	В.2.2.1. ҮДСТ-ийн зарчмыг баримтлан төсвийн хэрэгжилтэд тогтмол хяналт шинжилгээ хийх		1 төсвийн хяналт шинжилгээн ий тайлан	
	В.2.2.3. Төсвийн хяналт-шинжилгээний тайлангийн үр дүнгээр олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийх		1 үйл ажиллагаа	<b>Хэрэгжиж байна.</b> УАГ-аар аудитын тайлангийн үр дүнг олон нийтэд мэдээлсэн.
В.2.3 ИНБ, хэвлэл мэдээллийнхний Төсөвт хяналт шинжилгээ хийх, хяналт тавих чадавхыг сайжруулах	В.2.4.1. ИНБ-д зориулан ҮДСТ, төсөвт шинжилгээ хийх арга зүй аргачлал, асуудлаар сургалт зохион байгуулах	0	1	<b>Хэрэгжиж байна.</b> ИНБ-д төсөвт шинжилгээ хийх чадавх бэхжүүлэх чиглэлээр 1 сургалт, 1 зөвлөгөөн хэлэлцүүлэг зохион байгуулсан.
	В.2.4.3. 10 сумын сэтгүүлч, ажилтнуудад сургалт хийх	0	1	<b>Хэрэгжиж байна.</b> Парламентын сэтгүүлч нарт “Үр дүнд суурилсан төсөвлөлт” сэдэвт сургалт явуулсан. Үүний дараа сумын ажилтан албан хаагчдад зориулсан сургалтыг 11 сард явуулахаар төлөвлөж байна

### В.2.1 Салбарын бодлогын шинжилгээ ба Төсөвт хяналт, шинжилгээ хийх ИНБ-ын оролцоог хангах.

Иргэний нийгмийн байгууллагаас (ИНБ) төсөвт хяналт тавих хүрээ, чанарыг сайжруулах зорилгоор (УИХ болон УАГ) зэрэг хяналтын байгууллагуудын судалгааны үйл явцад хамтран бодлогын зөвлөмж, судалгааны ажил хийж байна.

УИХ, Сангийн яам нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд, ялангуяа ТХЗ-ын тэргүүлэх чиглэл болон Төсвийн Хавсралт 1-д заасан хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилтийн талаар гуравдагч болон хөндлөнгийн этгээдийн байр суурь, санал шүүмжийг сонсох сонирхолтой байдаг. Төслийн хүрээнд ҮДСТ-ийн аргачлалыг ашиглан төсвийн хөтөлбөрүүдэд санхүүгийн болон санхүүгийн бус хяналт, шинжилгээ хийхэд ИНБ-дад дэмжлэг үзүүлж байна. Тайлангийн хугацаанд төсөл нь ҮДСТ-ийн аргачлалыг ашиглан бодлогын шинжилгээ, бодлогын үр ашгийн талаарх хамтын судалгаа, ИНБ-ын төсвийн хяналтыг сайжруулах чиглэлээр дараах ахиц дэвшил гаргасан. Үүнд:

- 2022 онд ИНБ-аар төсвийн хяналт, шинжилгээ хийх ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролын салбарын төсөвт хяналт, шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн. Оролцогч 10 **ИНБ-ын төсвийн хяналт шинжилгээний нэгдсэн тайланг** 2023 оны 2 сард олон нийт түгээхээр бэлтгэсэн. (1-2 хуудаст үндсэн дүгнэлт, зөвлөмжийг багтаасан материал)

- УАГ-тай хамтран **2024 оны төсвийн төсөлд анализ** хийх ажилд **мэргэшсэн, академик судалгааны байгууллагыг оролцуулах загварыг** туршсан. Энэ судалгаагаар гүйцэтгэлийн аудитын шинжилгээний чанар, ил тод байдал, итгэл үнэмшлийг дээшлүүлэх зорилгоор 2024 оны оны нэгдсэн төсвийн орлого, зарлагыг шинжлэх, баталгаажуулах, түүхэн мэдээлэлд суурилсан төсвийн чиг хандлага ирэх онуудын прогноз /төсөөлөл/ боловсруулсан. УАГ-аас мэдээллээр ханган ажилласан нь цаашид чанартай шинжилгээ хийхэд мэдээллийн найдвартай, бодитой, хүртээмжтэй байдал чухал болохыг харуулсан.
- Судалгааны баг, ИНБ-ын хамтарсан зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 9 сард 2023 оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны төсвийн төслийн талаар зохион байгуулан санал бодлоо солилцлоо. Дээрх зөвлөлдөх уулзалтаар ИНБ-дад хяналт, шинжилгээ хийх боломж олгох, мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг сайжруулах, шинжээчид гаргасан дүгнэлт, зөвлөмж, арга зүй, аргачлалаа олон нийтэд ил тод байлгах, зарим салбарын зардлыг мөшгөх, гадаад өр зээлтэй холбоотой асуудал төрийн нууцад байгааг ил тод болгох, төсвийн эдийн засгийн ангиллыг өөрчлөх, төсвийн бодлого, хэрэгжилтийг хэмжих аргыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын зарцуулалтыг илүү ил тод болгох шаардлага байгааг онцоллоо. **Эдгээр саналыг** УАГ болон УИХ-ын Тамгын газрын хяналт шинжилгээний газарт эх хувиар нь уламжиллаа.

### **В.2.2. Төсөвт хяналт шинжилгээ хийх ИНБ-ын чадавхыг сайжруулах В.2.3. Төсөвт явцын хяналт хийх, хянах чиглэлээр ИНБ, хэвлэл мэдээллийн чадавхыг сайжруулах.**

2022 оны чадавхжуулах хөтөлбөрт хамрагдсан 10 ИНБ төсөвт анализ хийх болон гарсан дүгнэлтээ олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хүргэх аргазүйд суралцсан. Түүнчлэн ҮДСТ болон уламжлалт төсөвлөлтийн зарчмуудын ялгааг ойлгож мэдсэн. 2022 оны 10 сард ИНБ-дад, 2022 оны 12 сард парламентын сэтгүүлчид үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн сургалтыг хийсэн.

Төслийн хүрээнд 2023 онд УИХ-ын сэтгүүлчид болон нэр хүндтэй эдийн засагчид, төсвийн тоймчдын байнгын харилцан үйлчлэлийн платформыг өглөөний цай хөтөлбөрөөр эхлүүлсэн. УИХ-ын сэтгүүлчид, эдийн засагчид болон төсвийн тоймчид үр дүнд суурилсан төсөвлөлтөөр мэдээлэл авахын зэрэгцээ тэднээс эдийн засаг, төсвийн тулгамдсан асуудлуудаар мэргэжлийн байр суурийг сонслоо. Уулзалтын дараа төсвийн үр ашиг, өгөөжийн талаар өргөн хүрээтэй нийтлэлүүд хэвлэгдэн гарсан.

### **В.3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫГ БЭХЖҮҮЛЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ**

Үндэсний аудитын газрын 2023 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитад<sup>13</sup> гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, аудитын зорилго, зорилтыг тодорхойлох, хөгжлийн бодлогын үзүүлэлтүүдийг төсвийн төлөвлөлттэй уялдуулах, салбарын мэргэжилтнүүдэд зориулсан үр дүнд суурилан төлөвлөлт, төсөвлөлтийг сайжруулах, арга зүйн удирдамжаар хангах зэрэгтэй холбоотой дүгнэлт, зөвлөмжийг агуулсан болно.

<sup>13</sup> Эрүүл мэндийн санхүүжилт, үр нөлөө  
Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэл  
Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн

2022 оны улсын төсвийн нэгдсэн гүйцэтгэлийн аудит, 2024 оны төсвийн төслийн аудитын дүгнэлт, зөвлөмжид тус бүр үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, тогтвортой хөгжлийн зорилгын талаар тусган Үндэсний аудитын газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Үндэсний хөгжлийн зорилтууд болон ТХЗ-уудын хоорондын уялдаа холбоо, үндэсний хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн түвшинд анхаарч, гүйцэтгэлийн аудитын бүх үе шатанд ТХЗ-ын хэрэгжилт, ахиц дэвшлийг харгалзан аудитын дүгнэлтэд тусгасан.

- Үр дүнд чиглэсэн арга хандлагыг Гүйцэтгэлийн аудитын үе шат тус бүрд (Үндэсний болон Аймаг, Нийслэл) ашигладаг.
- Төсвийн төслийн аудитын явцад аудитын дүгнэлт, илрүүлэлтийг Урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах, Хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг сайжруулах, үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалд нийцүүлэх

### Төслийн дэд зорилгод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2023)	Хэрэгжилт 2023
В.3.1 ТХЗ уялдсан гүйцэтгэлийн аудит хийнэ.	В.3.1.1 Гүйцэтгэлийн аудит хийх	0	2	<b>Хэрэгжсэн.</b> Гүйцэтгэлийн аудитад мэргэжил, аргазүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. /Нийт 3 аудит/
В. 3.2 Аудитын иргэний танхим (Нийгмийн)	В.3.2.1. Үр дүнд суурилсан төсөвлөлт, аудитын тайланг танилцуулах	0	4 салбар	<b>Хэрэгжиж байна:</b> Үндэсний аудитын газар нь 2024 оны төсвийн төсөлд иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажилласан
В.3.3 Гүйцэтгэлийн аудитын чадавхыг сайжруулах	В. 3.3.1 Гүйцэтгэлийн аудитын талаарх туршлага судлах аялал	0	1	<b>Хэрэгжсэн.</b> Үндэсний аудитын газарт 3 удаа сургалт зохион байгуулж, 1 удаа туршлага судлах аялал зохион байгуулсан

### В.3.1 ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит хийнэ. В.3.2. Аудитын иргэний танхим( Нийгмийн).

Энэхүү дэд зорилтын хүрээнд урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, үндэсний хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн зорилго, зорилттой уялдуулан үр дүнтэй шинжилгээ хийх, гүйцэтгэлийн аудит хийхэд УАГ-т дэмжлэг үзүүлэхэд оршино. Өмнөх хоёр жилийн хугацаанд боловсруулсан гүйцэтгэлийн аудит, ТХЗ-той уялдсан төсөв, Үр дүнд суурилсан төсөвлөлттэй холбоотой мэргэжил, аргазүйн удирдамжууд нь аудиторчуудын байнгын хэрэглээний гарын авлага болсон.

Тайлант хугацаанд Төсөл нь бодлого, төсвийн уялдааг хангах, дүн шинжилгээ хийх, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн зарчмуудыг ашиглахад чиглэсэн дараах чиглэлээр гүйцэтгэлийн аудитад ахиц дэвшил гаргасан. Үүнд:

- **Гүйцэтгэлийн аудитын гарын авлага** -АДБОУС хэрэгжилтийн гарын авлага- Уг гарын авлагыг 2022 онд орчуулан аудитын стандартын хороогоор батлуулж, 2023 оноос гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаанд албан ёсоор хэрэглэж байна.
- **Үндэсний түлхүүр индикаторуудын боловсруулалт болон ашиглалтад аудит хийх удирдамж 5290, Төрийн бодлогын үнэлгээ удирдамж 9020** хоёр гарын авлагын орчуулж Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Эдгээр гарын авлага нь хөгжлийн жилийн төлөвлөгөөний аудит болон Төрийн бодлогод Үндэсний аудитын газар нь хөндлөнгийн үнэлгээ хийхэд зориулагдсан болно
- **2022 онд Улсын төсвийн төсөлд гүйцэтгэлийн аудит хийх арга зүйн зөвлөмжийг** үр дүнд суурилсан төсөвлөлтийн зарчим, ТХЗ хэрэгжилтийн аудитын зарчимд нийцүүлэн боловсруулсан. Үндэсний аудитын газраас 2024 оны төсвийн төслийн аудитыг гүйцэтгэхэд Төслийн зүгээс боловсруулсан аргачлалыг аудитын үйл ажиллагаанд хэрэглэж аудитын дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн.
- "Төрийн аудитын байгууллагын **гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагааны системийг** нийлүүлэх, тохируулах, суурилуулах, хүлээлгэн өгөх болон үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт"-ыг Үндэсний аудитын газрын хүсэлтийн дагуу боловсруулж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн. Гүйцэтгэлийн аудитын цахим программ, төсвийн мониторинг хийх вэб платформ нэвтрүүлэх даалгаврыг Гүржийн Үндэсний аудитын газартай танилцах аялалд оролцсон аудиторүүд бэлтгэн хүргүүлсэн.

**В. 3.3 Гүйцэтгэлийн аудитыг чадавхжуулах.** 2023 онд Үндэсний аудитын газар нь гүйцэтгэлийн аудит чадавхжуулах төсөлд идэвхтэй хамтран ажиллаж, өнгөрсөн хоёр жилийн хугацааны ололт амжилтыг бататгасан.

- 2022 оны 11-р сард зохион байгуулсан ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын цахим сургалтад (нийт 147 оролцогч, үүнээс 85 эмэгтэй, 62 эрэгтэй) УАГ-ын аудиторүүд, холбогдох мэргэжилтнүүд оролцон, 2016-2022 оны Монгол улсын ТХЗ-ын хэрэгжилт, ТХЗ-той холбоотой үндэсний зорилт, шалгуур үзүүлэлт, үндэсний зорилтод гарсан ахиц дэвшлийн талаар нэгдсэн ойлголттой болсон. 2022 оны 12-р сард (нийт 112 оролцогч, үүнээс 67 эмэгтэй, 45 эрэгтэй) зохион байгуулсан ТХЗ хэрэгжилтийн аудитын цахим сургалт нь дараах сэдвүүдээр явагдсан болно. Үүнд “ТХЗ-12 Хариуцлагатай хэрэглээг дэмжих”, ТХЗ-13 “Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах”, ТХЗ-8 “Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих”, ТХЗ-9 “Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх” зорилтууд багтсан. Цахим сургалтууд нь ТХЗ-ын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийх, гүйцэтгэлийн аудитын аргачлалыг түгээн дэлгэрүүлэх зорилготой байв.
- 2022 оны 12-р сард зохион байгуулагдсан "Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт" сургалтад Үндэсний аудитын газрын удирдах түвшний албан тушаалтнууд, аудиторүүд “Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалын талаарх хамгийн сүүлийн үеийн шинэ хандлага, олон улсын туршлага, Монгол улсад нэвтрүүлэх үйл явцын талаар нэгдсэн ойлголтыг олж авсан. Сургалтад нийт 54 албан тушаалтан (26 эрэгтэй, 28 эмэгтэй) хамрагдсан.
- Үндэсний аудитын газрын 2024 оны жилийн төлөвлөгөөг Төслийн дэмжлэгтэйгээр үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалаар боловсруулж, УИХ-ын Төсвийн байнгын хороонд өргөн барьж, 2024 оны төлөвлөгөөг төсвийн байнгын хорооноос сайшааж, амжилттай баталсан. 2024 оны Үндэсний аудитын газрын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэл, Үндэсний аудитын газрын 81 аудитор, холбогдох албан тушаалтнуудыг хамруулан сургалтыг зохион байгуулсан.
- 2023 оны 3-р сард Гүрж улсын Үндэсний аудитын газарт туршлага судлах аяллыг зохион байгуулсан. Гүрж Улсын Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудит, ТХЗ хэрэгжилтийн аудит, Үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалын талаар туршлага солилцсон. Сургалтын явцад



төсвийн хяналт, ТХЗ хэрэгжилтийн аудитад олон нийтийн оролцоог хангахтай холбогдуулсан ололт, амжилт, сургамжууд, гүйцэтгэлийн аудитад тулгарч буй практик асуудал, төсвийн мониторингийн цахим системүүдтэй танилцсан.

- 2023 оны 11 дүгээр сарын 2-3-ны өдрүүдэд ҮАГ, Нийслэл болон Орхон аймаг дахь төрийн аудитын газрын нийт 69 аудиторыг хамруулан Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, Удир 5290, Удир 9020, гүйцэтгэлийн аудитын стандартын талаар сургалт зохион байгуулсан. Сургалтаар гүйцэтгэлийн аудитын арга зүйг үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн зарчмын дагуу боловсронгуй болгох, Үндэсний түлхүүр индикаторуудын боловсруулалт болон ашиглалтад аудит хийх удирдамж 5290, Төрийн бодлогын үнэлгээ удирдамж 9020 удирдамжийг танилцуулсан.

## БҮРЭЛДЭХҮҮН С. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖУУДЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Төсөл дараах үндсэн дөрвөн чиглэлээр үр дүнд хүрэхийг зорьж байна. Үүнд:

- С.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг сайжруулах , харилцан уялдаатай болгох.
- С.2 Инновац, гарааны бизнес, бизнес инкубац, бизнес эрхлэхэд ээлтэй экосистемийг бэхжүүлэх.
- С.3 Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх үр чадвар, чадавхыг нэмэгдүүлэх.
- С.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үр дүнтэй сургамж цуглуулах, улмаар бодлогод тусгах зорилгоор түршилтын төслүүдийг эхлүүлэх

### С.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ САЙЖРУУЛАХ , ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ БОЛГОХ

#### Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Төслийн дэд зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	2023 оны хэрэгжилт
Дэд зорилт С.1.1 Одоо хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн зураглалыг гаргаж, саад бэрхшээлийг тодорхойлох.	С.1.1.4 Үндэсний хөтөлбөрүүдийг хянаж, шинэчлэх	Чиглэл дутмаг	Шинэчилсэн хөтөлбөрүүд	<b>Хэрэгжсэн.</b> ХЭДХ-үүд нь ҮДСТ-ийн дагуу шинэчлэгдэж ХЭДҮЗ-өөр батлагдсан ба цаашид нэмэлт сайжруулалт шаардлагатай.
Дэд зорилт С.1.2 Үндэсний хөтөлбөрүүд болон яамны төсөвт тусгагдсан дэмжих үйлчилгээ.	С.1.2.1 Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломжтой салбар\төслүүдийг тодорхойлох	0	4 хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн төсөл хэрэгжиж байна	<b>Хэрэгжиж байгаа.</b> Профайлингийн үйлчилгээг аргачлал, бүтцийн шинэчлэлийн хамтаар нэвтрүүлсэн. Санхүүгийн дэмжлэг, мэргэжлийн сургалт, дадлагажих хөтөлбөр болон бусад дэмжих үйлчилгээний агуулга, загваруудыг сайжруулсан.
	С.1.2.3 Зөвлөгөө өгөх дэмжлэгийг орон нутгийн хоршоод, бизнес, зах зээлтэй уялдуулах	0	1 холбох үйлчилгээ	
Дэд зорилт С.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх яамны төсөвт бодит тусгалаа олсон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	С.1.3.1 байгууллагын менежмент болон зохицуулалтыг дэмжих үйлчилгээг хянах, шинэчлэх	0	1 шинэчлэл	<b>Хэрэгжсэн.</b> Анхан шатны нэгж дээр ажиллаж буй ХЭ-ийн мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагыг боловсруулсан. <a href="http://www.ejob.gov.mn">www.ejob.gov.mn</a> цахим платформ дээр профайлингийн модулийг хөгжүүлсэн. <a href="http://www.ezuvshuurul.gov.mn">www.ezuvshuurul.gov.mn</a> сайжруулж, удирдлага зохицуулалтыг сайжруулсан.
	С.1.3.2 Үндэсний хөтөлбөрүүд дэх дэмжих үйлчилгээ нь			<b>Хэрэгжсэн</b> Профайлингийн үйлчилгээний болон Дадлагажих хөтөлбөрийг төсөв

	ХНХЯ-ны төсөв туссан байна.			ХНХЯ-ны төсөвт суусан. Үйлчилгээний хөлсийг шинэчлэн ХЭДХ/ХЭДС-ын төсөвлөлтөд ашигласан.
--	-----------------------------	--	--	--

### С.1.1 Үндэсний хөтөлбөрүүдэд хийсэн шинэчлэл.

- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулсан.** Өмнөх жил төслийн хүрээнд гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээнд үндэслэн **2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд (ХЭДХ)**-ийн загварыг шинэчлэн, 2023 оны 2-р сард Хөдөлмөр Эрхлэлтийн Дэмжих Үндэсний зөвлөл (ХЭДҮЗ)-өөс баталсан. Гол өөрчлөлт, загварын шинэчлэлийг Төслийн 2022 оны Жилийн тайлангаас<sup>14</sup> харах боломжтой. Хөтөлбөрүүдийн шинэчилсэн загварын хувьд орон нутагт илүү боломжуудыг олгосон, хүн амын бүлгүүдэд чиглэсэн байдлыг арилгах замаар сангийн уян хатан байдлыг нэмэгдүүлсэн, хөтөлбөрүүд доторх давхардлыг арилган, илүү бодит ГШҮ-ийг оруулах байдлаар ҮДСТ-ийн аргыг шингээсэн, гүйцэтгэлд суурилсан тайлагналтыг оруулсан зэрэг давуу талуудтай.
- ХЭДХ-ийн хэрэгжилт, зарцуулалтын хяналт, бодлогын нөлөөллийн судалгаа, ҮДС аудитын үр дүн зэргээс харахад ХЭДХ-г (бүхэлд нь болон дангаар нь) цаашид сайжруулах хэрэгцээ, шаардлага байсаар байна. Тиймээс ХНХЯ-аас цаашид хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөг тооцоолох зорилгоор “Санхүүгийн дэмжлэг” арга хэмжээний үр нөлөөний үнэлгээ хийлгэх ажлыг 2023 онд эхлүүлсэн. Төслийн зүгээс үнэлгээний суурь (ex-ante) судалгааг гүйцэтгэхэд техникийн болон аргазүйн дэмжлэг үзүүлсэн бөгөөд уг судалгааг ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институци гүйцэтгэж байна. Үр нөлөөний үнэлгээний талбарын мэдээлэл цуглуулах хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийг сургахад төслийн зүгээс мөн дэмжлэг үзүүлэн ажилласан.
- Төслийн дэмжлэгтэйгээр “**2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх гарын авлага**”-ыг боловсруулсан бөгөөд уг гарын авлагад хэрэгжүүлэх алхам, үйл явц, арга барил, жишиг зардал зорилтод бүлэг зэргийг дэлгэрэнгүй тусгасан. Энэхүү гарын авлагыг анхан шатны нэгж дээр ажиллаж буй бүх Хөдөлмөрийн мэргэжилтнүүдэд түгээсэн бөгөөд ингэснээр шинэчилсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэчилсэн хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилт, хүлээгдэж буй өөрчлөлтийн талаар тодорхой, ижил ойлголттой болсон.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний **ХШҮ-ний гарын авлага** 2023 онд боловсруулсан бөгөөд ХНХЯ-д хүргүүлээд байна.
- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй санхүүгийн дэмжлэгийн загвар сайжруулалт. Санхүүгийн дэмжлэг олгох одоогийн тогтолцоод хийсэн нөхцөл байдлын үнэлгээг** 2023 онд ХНХЯ-ны хүсэлтэд үндэслэн хийсэн. Үнэлгээний хүрээнд санхүүгийн дэмжлэг авах шалгуур, холбогдох үйл явц, санхүүжилт олгох гарын авлага, асуулга (бизнес профайлинг) зэргийг шинээр боловсруулсан. Санхүүгийн дэмжлэг олгох шинэчилсэн загварыг боловсруулан холбогдох оролцогч талуудтай зөвшилцөх шатанд байна.
- Засгийн газраас 2024 онд хэрэгжүүлэхээр '**Ажил олгогчийг дэмжих төсөл**' санаачилсан бөгөөд уг түршилтын төслийг Засгийн газрын хүсэлтээр төслийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ. Ажил олгогчийг дэмжих төсөл нь дадлагажих хөтөлбөрийн загвараар хэрэгжих ба уг төсөлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-с 11 тэрбум төгрөгийг хуваарилсан. Энэхүү төслийн санаа нь 2022-

<sup>14</sup> Төслийн 2022 оны жилийн тайлан

2023 онд төслийн зүгээс туршин хэрэгжүүлсэн Дадлагажих хөтөлбөрийн сургамж, загвар дээр үндэслэн гарсан болно (С.1.2 хэсэгт дурдсан).

- **Бүрэн бус цагийн хөдөлмөр эрхлэлт ба цалин хөлсний** судалгааг ХНХЯ-ны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран 2023 онд төслийн дэмжлэгтэйгээр хийж эхэлсэн. Энэхүү судалгаа нь Монгол Улсад анх удаа хийгдэж байгаа юм. Уг судалгаагаар улсын хэмжээний бүрэн бус цагийн хандлага, цагийн хөлс, ажлын цагийг тодорхойлох зорилготой бөгөөд мөн бусад улс орны туршлага дээр үндэслэн нийтийн албанд бүрэн бүс цагийн хэлбэрийг нэвтрүүлэх боломжуудыг судлах юм. Судалгааг 2023 оны сүүлээр гүйцэтгэж дуусгана.
- **Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг** 2023 онд 3 аймагт (Дорноговь, Орхон, Өвөрхангай) гүйцэтгэх ажлыг эхлүүлсэн. Цаашид хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зэрэг орон нутгийн институцийн бүтцийг ашиглах замаар орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг гүйцэтгэдэг болох үр дүнтэй зохицуулалтыг бий болгоход төсөл ажиллана.
- Хууль тогтоомжийн тухай хууль заасан шаардлагын дагуу Хуримтлалын нэгсэн санг байгуулах тухай **Хуулийн төсөл болон дагалдах материалуудыг** боловсруулаад байна. Одоогоор Хуулийн төсөл, Үзэл баримтлал, Хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд зэргийг боловсруулан ХНХЯ-д хүргүүлээд байна. ХНХЯ-ны холбогдох газруудын 27 хүний төлөөлөл бүхий техникийн зөвлөлдөх үүлзалтыг 10-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгээр дээрх баримт бичгийн төсөлд сайжруулах санал, дүгнэлтийг авахад чиглэсэн.

**С.1.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх уялдаа холбоо бүхий дэмжих үйлчилгээний загварыг бий болгосон байна.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэчилсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжих үйлчилгээний загвар, хэрэгжилтийн горимыг нэвтрүүлсэн.

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг илүү хувь хүний хэрэгцээ онцлогт нийцүүлсэн байдлаар хүргэх зорилгоор Профайлингийн үйлчилгээг нэвтрүүлэх ажил 2023 онд төслийн дэмжлэгтэйгээр үргэлжилсэн. **Профайлингийн багц асуулга, хувь хүний төлөвлөгөөний загвар,** болон бусад холбогдох гарын авлагын хамтаар боловсруулан 2022 оны 11-р сарын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын даргын тушаалаар албажуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнийг кейсээр ажиллах чиг үүрэгтэй уялдуулах зорилгоор аймаг, дүүргийн хөдөлмөрийн газар, хэлтсийн бүтэц чиг үүргийг шинжилгээ хийсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн бүтэц, чиг үүргийг Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний зохион байгуулалтын дагуу шинэчлэн, боловсруулж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраар батлуулсан. **Кейс ажилтны ажлын байрны тодорхойлолтын төслийг DACUM<sup>15</sup>** үнэлгээ дээр үндэслэн боловсруулан батлуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын цахим платформ болох <http://www.job.gov.mn/> профайлингийн үйлчилгээний модулийг хөгжүүлэн суурилуулсан. Программын хамтаар цахимаар профайлингийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар зааварчилгааг хөдөлмөрийн мэргэжилтнүүдэд зориулан оруулсан.

<sup>15</sup> <https://facilitation.eku.edu/what-developing-curriculum-dacum>

Профайлингийн аргагүйгээр Сургагч багш бэлтгэх сургалтыг 2023 оны 6-р сард зохион байгуулж, ХНХЯ, ХХҮЕГ, 9 дүүрэг, 21 аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийт 65 хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн хамрагдсан. Эдгээр бэлтгэгдсэн сургагчид нь улсын хэмжээнд профайлингийн үйлчилгээ, иргэн төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг кейс менежментийн арга барилаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх юм.

- **Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг шинэчлэх, туршилтууд.** 2023 онд дөрвөн төрлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг 1 аймаг (Баянчандмань сум) болон Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ арга хэмжээний загвар, хэрэгжилтийн горимын турших, эерэг үр дүн сургамжийг цашид хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд нэвтрүүлэх зорилготой байв. Эдгээр нь:

i) **Аж ахуй эрхлэлт.** Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулсан дэмжих үйлчилгээний загварыг 2022 онд аж ахуй эрхлэлтийг дэмжих болон менторын үйлчилгээ үзүүлэх замаар 20 бизнесийг дэмжиж ажилласан. Эдгээр 20 бизнес (профайлингийн үнэлгээнд үндэслэн сонгосон) 2022 оны 12-р сард амжилттай төгссөн. Туршилтын үр дүнд бизнес, аж ахуй эрхлэлтийн дэмжлэг, менторын үйлчилгээ, үйлчилгээний давтамж, алхмууд зэргийн загварыг эхний байдлаар боловсруулан тодорхойлсон. Аж ахуй эрхлэлтийн дэмжлэг, менторын үйлчилгээний туршилтын арга хэмжээний үр дүн, сургамж, санал болгож буй загварыг ХНХЯ болон холбогдох дүүргийн удирдлагуудад танилцуулсан.

**Аж ахуй эрхлэлтийн түр сургалтын модуль** (5 өдөр) ХНХСҮСИ-тэй хамтран боловсруулж нэвтрүүлэхээр ХНХЯ-д хүргүүлээд байна. Энэхүү сургалтын модуль нь санхүүгийн дэмжлэг хүссэн иргэнд үзүүлдэг одоогийн сургалтыг (1 өдөр нь хэрхэн төсөл бичих, 2 өдөр бизнесээ хэрхэн удирдах талаар нийт 3 өдрийн сургалт) шинэчлэх зорилготой. Санал болгож буй сургалтын модулийг 2024 оноос эхлэн хэрэглээнд оруулна. Ажил хайгч иргэдийн хөдөлмөр эрхлэх чадавхыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд, түр сургалтын байгууллагуудаар үзүүлж буй мэргэжлийн сургалтын агуулгад (хамгийн эрэлттэй 20 мэргэжил) чанарын үнэлгээг гүйцэтгээд байна. Энэхүү үнэлгээний ажлын зэрэгцээ, зах зээлийн эрэлттэй байгаа цахим үр чадвар олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Судалгааны ажлын баримт бичгийг төслийн нэгж, ХНХЯ, БШУЯ-ны төлөөлөлд танилцуулах, хянуулах шатандаа байна.

ii) **Мэргэжлийн сургалт.** Чадамжид суурилсан түр сургалтын (45 хоног хүртэл) арга хэмжээний загварыг шинэчлэх зорилгоор 2022 онд туршсан бөгөөд энэхүү шинэ загвар, хэрэгжилтийн горимыг 2023 онд кейс менежментийн дагуу үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэг болгохоор ажиллаж байна. Туршилтад ажил хайж байсан бүлэг иргэдийг сонгож, үр чадварын үнэлгээ хийсэн ба ингэхдээ ажилтай болоход нь мэргэжлийн сургалтын хэрэгцээ байгаа иргэдийг нь тодорхойлж хамруулсан. Туршилтад хамруулах богино хугацааны сургалтын мэргэжлүүдийг тухайн иргэдийн хэрэгцээнд үндэслэн хувийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах явцад сонгосон. Хамгийн эрэлттэй 10 мэргэжлийн (үсчин, маникюр, фермер, нарийн боовчин, тогооч, машины операторч, оёдолчин гэх мэт) сургалтын үйл ажиллагааг ажил хайгч, ажилгүй иргэдэд үзүүлсэн. Зөөлөн үр чадварын агуулгыг сургалтын зайлшгүй судлах нэгэн чадамж болгон нэмж оруулсан.

Туршилтын түр сургалтын арга хэмжээ 2023 оны 2-р сард дууссан бөгөөд үр дүнг ХНХЯ-д танилцуулсан. Түр сургалтыг нийт 59 иргэн төгсөж, чадамжийн гэрчилгээг гардан авсан. Түр сургалтын агуулгад зөөлөн үр чадварын агуулгыг нэмж оруулахыг санал болгосон.

Туршилтын горим одоогийн хэрэгжилтийн зохицуулалтаас дараах 4 онцлогоор ялгаатай байв; i) хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн суралцахуйн хэрэгцээнд үндэслэсэн, ii) сургалтын байгууллагуудын хувьд уян хатан (автоматаар хуваарилаагүй), iii) мэргэжил тус бүрт шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг зах зээлийн бодит ханшаас доогуур тогтсон ХЭДС-аас баталсан ханшаар бус зах зээлийн ханштай нийцүүлсэн, iv) Оролцогчдын мэдлэгийн түвшинд нийцүүлэн сургалтын агуулгад тохируулга хийсэн.

Туршилтаар үзүүлсэн түр сургалтын арга хэмжээний загвар, хэрэгжүүлэх шинэ горим, түр сургалтын байгууллагуудыг зохион байгуулалт зэргийг боловсруулан ХНХЯ-д зөвлөмж хүргүүлсэн. Профайлингийн аргыг ашиглан иргэдийг оновчтой тодорхойлох, шинэчилсэн жишиг зардлын задаргаа, сургалтын агуулгад тохируулга хийх, сургалтыг зохион байгуулах горим зэргийг зөвлөмжид тусгасан.

iii) **Дадлагажих хөтөлбөр.** Дадлагажих хөтөлбөрийг зохион байгуулах нь хөдөлмөр эрхлэлтийн үр дүнтэй хэлбэр болохыг 2022 онд туршсан бөгөөд үр дүнг 2023 оны 4-р сард ХНХЯ болон бусад оролцогч талуудад танилцуулсан.

Дадлагажих хөтөлбөрийг Ажил олгогч эздийн холбоо хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд туршилтын загвар 4 үе шаттай хэрэгжсэн – i) профайлингийн үйлчилгээгээр дадлагажих хөтөлбөрт (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өөр бусад дэмжлэг бус) хамрагдах нь үр дүнтэй нь тогтоогдсон, ii) ажлын нөхцөлд бэлтгэх зорилгоор зөөлөн үр чадварын сургалтад хамруулах, iii) ментороор ажиллах ажил олгогчийг тодорхойлж тэднийг дадлагажих хөтөлбөрт оролцоход нь сургах iv) дадлагажих хөтөлбөрийг 6 сарын хугацаатайгаар хэрэгжүүлэх. Анх 60 иргэнийг хамруулахаар төлөвлөсөн ч 27 иргэн бүртгүүлсэн. Дадлагажих хөтөлбөр 2023 онд дууссан бөгөөд ирээдүйн дадлагажих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэгтэй холимог үр дүн, томоохон сургамж авсан. Туршилтын үр дүнд үндэслэн Дадлагажих хөтөлбөрийн давтамж, алхмууд, хэрэгжилтийн удирдлага зохион байгуулалт зэргийг боловсруулан ХНХЯ болон ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөлд танилцуулсан.

iv) **Хоршоо.** Хөдөө орон нутгийн хоршоог дэмжиж, тэднийг нэмүү өртгийн сүлжээнд холбох арга хэмжээг 2022-2023 онд төслийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. Туршилт нь 3 үе шатаас бүрдсэн, i) орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба дээр ирж профайлингийн үнэлгээ хийлгэсэн хувиараа хөдөлмөр эрхлэх эсвэл хоршоо байгуулан ажиллах сонирхолтой иргэдийг тодорхойлж, ii) сонгогдсон иргэдийг аж ахуй эрхлэлтийн талаар туршлагатай бизнес зөвлөхийн сургалтад хамруулах, сонирхлын бүлэг байгуулах, iii) тухайн орон нутагтаа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бизнес санаатай, эсвэл нэмүү өртгийн сүлжээнд нэгдэх иргэд болон хоршоодыг хөдөө аж ахуй, хоршооны мэргэжилтний тусламжтайгаар тодорхойлох, iv) ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн засаг захиргаагаар дамжуулах санхүүжилт олгох, v) бизнес хөгжлийн явцад хяналт тавих.

Нийт 6 аж ахуйн нэгж аж ахуй эрхлэлтийг дэмжих сургалтад хамрагдсанаас энэхүү туршилтын арга хэмжээнд гурван хоршоо сонгогдсон. Эдгээр нь хурдны морь асаргааны ферм, малын ванн, арьс шир боловсруулах гэсэн бизнес санаа байв. Бүх 3 хоршоо нь Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын газрын хамтын ажиллагааны хүрээнд төслийн зүгээс санхүүжилт олгосон. Төслийн хүрээнд ХХААХҮ-ийн байгууллагын зохион байгуулсан 5 өдрийн хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх сургалтад хоршоод хамрагдсан. Дэмжлэг үзүүлснээс хойш нэг жилийн дараа хоёр хоршоо нь идэвхтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, амжилттай яваа бол нэг хоршоо нь найдвартай ажиллах хүч дутагдалтай зэрэг зарим нэг бэрхшээлтэй тулгарсаар байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээтэй (профайлинг) хослуулах байдлаар хоршоодыг дэмжих, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, санхүүгийн дэмжлэг үзүүлж дараа нь тогтмол хянаж ажиллах энэхүү туршилтын загвар нь одоогийн нэг удаагийн буцалтгүй тусламж байгаагаас илүү үр дүнтэй болох нь туршилтаас харагдсан.

- **Төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийг оролцуулах нь.** Төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгүүлэх зорилгоор хөдөлмөрийн хувийн биржүүдтэй хамтран ажиллах боломжийн талаарх үнэлгээ хийгдэж байна.
- **Хөдөлмөрийн албадыг дахин зохион байгуулалтад оруулаа.** Ажлын байранд илүү үйлчлүүлэгчид чиглэсэн үйлчилгээний соёлыг бий болгох зорилгоор зан үйлийн онцлогт нийцсэн аргагүйг ашигласан бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд 3 энгийн техникийг түршин үзсэн; i) Үйлчлүүлэгчидтэй харилцаж буй байдалд хяналтын хуудас ашиглан өдөр тутам хяналт тавих, ii) үзүүлсэн бүх үйлчилгээний бүртгэлийн хуудсыг ажиллуулах болон iii) хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөгт иргэдийг хамруулах зорилгоор хэд хэдэн өөр хэлбэрийн захидлыг иргэд рүү илгээж хариу үйлдэлд нь шинжилгээ хийсэн. Энэхүү туршилтын арга хэмжээ нь иргэдийн зан үйлд хэрхэн өөр өөр байдлаар нөлөөлж буйд анхан шатны нэгж дээр ажиллаж буй мэргэжилтнүүд харсан бөгөөд иргэдийн онцлогт нийцүүлэх замаар үзүүлж буй үйлчилгээгээ хэрхэн иргэдэд хүргэж болох талаар суралцсан.

Энэхүү аргачлалыг 2022 онд Сонгинохайрхан дүүрэгт туршиж үзсэн бөгөөд үр дүнг танилцуулах ажлыг дүүрэг, хорооны мэргэжилтнүүдийн дунд 2023 оны 3-р сард зохион байгуулсан.

**С.1.3 Үндэсний хөтөлбөрүүд дэх дэмжих үйлчилгээ нь ХНХЯ-ны төсөв түссэн байна.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд дэх дэмжих үйлчилгээг сайжруулах нь үндэсний хэмжээнд тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжуудыг бий болгоход ихээхэн чухал ач холбогдолтой. Төслийн баримт бичигт “Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй удаан байсан иргэд гэх мэт бүлэгт зориулсан зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх нь тэдний хөдөлмөрийн нөөцийг ашиглах замаар хөдөлмөрийн зах зээлд оруулах нь институцийн бүтцэд оруулж буй нэг хэлбэр” юм хэмээн дурдсан байдаг. Тиймээс, энэхүү дэд үр дүнгийн хүрээнд төслийн зүгээс түршсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон зөвлөх үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцад шингээхийг зорин ажиллаж байна.

Тайлант хугацааны явцад төслийн зүгээс ХЭДХ-т дэмжих болон зөвлөх үйлчилгээг шигтгэн оруулахад дараах ажлууд дээр ахиц дэвшил гарган ажилласан. Үүнд:

- Туршилтын үр дүнд үндэслэсэн i) профайлингийн үйлчилгээ, ii) аж ахуй эрхлэлт, дадлагажих хөтөлбөр, богино хугацааны сургалт, хоршоо зэрэг арга хэмжээний загвар, хэрэгжилтийг шинэчлэн сайжруулж ХНХЯ-д хүлээлгэн өгсөн. Профайлингийн үйлчилгээний гарын авлага Засгийн газраар батлагдсан. Зөвлөх болон дэмжих үйлчилгээг нэвтрүүлэх тал дээр төсөл үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж улмаар “Ажил олгогчийг дэмжих төсөл” (дадлагажих хөтөлбөр) боловсруулан ХЭДС-аас санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Хувийн хөдөлмөрийн биржүүдтэй хамтран ажиллах хэлбэр, загварыг сайжруулах тал дээр ажиллаж байна.

- Профайлингийн үйлчилгээ үзүүлэх төсвийг 2023, 2024 оны ХНХЯ-ны төсөвт тусгав. **Профайлингийн үйлчилгээний жишиг зардлыг** Төслийн багаас боловсруулан төсөв бэлтгэх үйл явцад ашигласан.

“Ажил олгогчийг дэмжих төсөл” (дадлагажих хөтөлбөр)-ийн төсөв нь ХЭДС-ын төсөв туссан.

2023 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний жишиг зардал 2023/2024 оны ХЭДС-ын жишиг зардлыг ХЭ-г дэмжих арга хэмжээ, үйл ажиллагааны өмнөх зардал дээр үндэслэн тус тус шинэчлээд байна.

## С.2 ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, БИЗНЕС ИНКУБАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭХЭД ЭЭЛТЭЙ ЭКОСИСТЕМИЙГ БЭХЖҮҮЛЭХ

### Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Төслийн дэд зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	2023 оны хэрэгжилт
С.2.2 Донор/ОУ-ын байгууллагуудын хэрэгжүүлсэн санаачилга, төслийн зураглал, нэгдсэн үнэлгээ	С.2.2.1. Иж бүрэн үнэлгээний зураглалыг гаргах	0	1 шинэчлэл	<b>Хэрэгжсэн.</b> Доноруудын дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн төслүүдийн нэгдсэн системийг шинэчлэн ХНХЯ-д хүлээлгэн өгсөн.
	С.2.2.2. Хамтарсан дэмжлэг үзүүлэх платформыг бий болгох	Байхгүй	1 уулзалт	<b>Хэрэгжиж байгаа.</b> 4-р улиралд хэрэгжинэ
	С.2.2.3. Хөдөлмөрийн эрхлэх чадварыг бэхжүүлэх чиглэлээр оролцоог хангах	Байхгүй	Хамруулалтын үнэлгээ	<b>Хэрэгжиж байгаа:</b> Тэгш хамруулалтыг үнэлэх функцийг системд нэмж оруулсан.
С.2.3 Залуучууд, алслагдсан бүсийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түлхүү хамруулсан гарааны бизнесийг дэмжих	С.2.3.1. Шинэлэг/гарааны бизнесийн санааг дэмжих хүрээг тодорхойлох	Байхгүй	4 үнэлгээ	<b>Хэрэгжиж байгаа.</b> Хакатоноор дамжуулан зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахимжуулах санаа бүхий 3 инновацын гарааны бизнесийг дэмжсэн.

**С.2.1. Инноваци, гарааны бизнесийн нэгдсэн платформ бий болгоно.** Төслийн 2022 оны жилийн тайланд дурдсанчлан шинэ платформ бий болгохоос илүүтэйгээр одоогийн байгаа платформуудад хувь нэмэр оруулах тал дээр ажиллаж байна.

**С.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр донор/ОУ-ын байгууллагуудын хэрэгжүүлсэн санаачилга, төслийн зураглал, нэгдсэн үнэлгээ.** Олон улсын байгууллага, хөгжлийн түншүүдийн санхүүжилттэйгээр хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжсэн төслүүдийн цахим мэдээллийн сан болох (<https://projects.mlsp.gov.mn>) шинэчлэн 2023 онд үйл ажиллагаанд оруулаад байна. Мэдээллийн сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хөгжлийн түншүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудын санхүүжилттэйгээр хэрэгжсэн **төсөл, хөтөлбөрүүдийн талаар**



**мэдээллийг үүсгэх, ашиглах, хадгалах, хамгаалах талаар** журмын төслийг боловсруулан ХНХЯ-д батлуулахаар хүргүүлээд байна.

**С.2.3 Залуучууд, алслагдсан нутгийн ажил хайгч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гарааны бизнесийг дэмжинэ, мөн гадаад хүчин зүйлсийн улмаас түр хугацаанд ажилгүй болсон иргэдэд богино, дунд хугацааны боломжуудыг бий болгоно.**

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт ба зохистой хөдөлмөр эрхлэлтийн инновацийн санаа, шийдэл гаргах зорилгоор цахим **ХАКАТОН**-ыг төслийн зүгээс (НҮБХХ, ОУХБ баг) 2023 оны 9-р сард зохион байгуулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг D.1.6. хэсэгт тусгав.

Хакатон нь шинэ санааг бойжуулах талбар болохоос гадна дан гарааны бизнес рүү чиглэх гэхээсээ илүү одоогийн дутагдалтай байгаа Засгийн газраас үзүүлдэг гарааны бизнесийг олгох загвар горимыг бий болгох боломжтой. Гарааны бизнесийг экосистем нь одоо хэлбэржих шатандаа явж байна.

**С.3 ЦАЛИНТАЙ БОЛОН ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ.**

Бүрэлдэхүүн С.2 нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд илүү анхаарал хандуулсан бол Бүрэлдэхүүн С.3 нь сургалт, боловсрол, үр чадварын хөгжил, ажил мэргэжлийн чиг баримжааны механизмыг сайжруулах, зөөлөн үр чадвар, ажил олгогч ажилтны хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шинэ инноваци бүхий аргазүйг нэвтрүүлэх замаар хөдөлмөр эрхлэх боломжуудыг нэмэгдүүлэх чиглэсэн.

**Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр**

Төслийн дэд зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	2023 оны хэрэгжилт
С.3.1 Загварлан бүтээх сэтгэлгээ, зан үйлд суурилсан аргачлалын талаар чиглүүлэгчийн чадавх хөгжүүлэх үйлчилгээ, мөн бизнес санаагаа үйл хэрэг болгох үр чадварт суурилсан сургалтын аргыг боловсролын байгууллагын бүтцэд оруулж хөгжүүлнэ	С.3.1.2 Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх шинэ загвар боловсруулах	0	1 загвар баримт бичиг	<b>Хэрэгжиж байна.</b> Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх шинэ загвар боловсруулж байна.
	С.3.1.3 Бизнес санаагаа үйл хэрэг болгох, зөөлөн үр чадвар, технологи зэрэг чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах	0	2 сургалтын модуль	<b>Хэрэгжсэн.</b> Сургалтын хөтөлбөр, багш, сурагчдад зориулсан гарын авлага боловсруулан түгээсэн.
	С.3.1.4 Тусгайлсан болон чадвар олгох сургалтын хөтөлбөрүүдийг турших	0	10 ТМБ Сургууль	<b>Хэрэгжиж байна.</b> 5 ТМБ-ын сургуульд туршсан, загварлах сэтгэлгээний санаачлагчийг дэмжиж тэтгэлэг олгосон.
	С.3.1.5. Ажил хайгчдад зориулсан бизнес санаагаа үйл хэрэг болгох сургалтын хөтөлбөр боловсруулах	0	10 ТМБ сургууль, 1 ахлах сургууль	
	С.3.1.6. Холбогдох сургалт үйлчилгээг өргөжүүлэх	на	-	<b>Хэрэгжиж байна.</b> ТМБС-д зориулсан инноваци бүхий сургалтын модулийг нэвтрүүлэх хүсэлтийг БШУЯ-д хүргүүлсэн.

Төслийн дэд зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	2023 оны хэрэгжилт
	С.3.1.7 Ур чадвар олгох сургалтууд, Зөвлөгөө өгөх үйлчилгээ хэрэгжих	0	3 сургалтын модуль баталгаажуулсан	2024 онд баталгаажин, улсын хэмжээнд нэвтрүүлнэ.
С.3.2 Зайн/цахим платформыг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээний мастер сургалт явуулах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зайнаас хүргэх чадавхыг дээшлүүлэх замаар хүртээмж, хамрах хүрээг сайжруулна	С.3.2.1. Эмзэг бүлгийн хүн амыг тодорхойлох	na	Нэмэлт модулийг шинэчилсэн	<b>Хэрэгжиж байна.</b> Профайлингийн Д бүлгийн иргэдэд зориулсан нэгдсэн үйлчилгээг тодорхойлох (нийгмийн үйлчилгээг оролцуулаад)
	С.3.2.2 Цахим сургалтын хөтөлбөр боловсруулах	0	1 багц модуль	<b>Хэрэгжсэн.</b> Багш болон сурагчийн гарын авлагын цахим хувилбар боловсруулсан.
	С.3.2.3 Туршиж сайжруулна	0	150 иргэнийг хамруулсан байна	Хараахан эхлээгүй
С.3.3 Ажил олгогчдод чиглэсэн арга хэмжээ, ажил олгогч-ажилтны харилцааг дэмжсэн байнгын ажиллагаатай механизм бий болгоно	С.3.3.1 Ажил олгогчдод чиглэсэн арга хэмжээ, ажил олгогч-ажилтны харилцааг дэмжих байнгын ажиллагаатай механизм бий болгож, ажиллуулах	0	1 уулзалт	<b>Хэрэгжиж байна.</b> Байнгын ажиллагаатай платформыг бий болгох талаар 2 саналыг туршиж, зарим шинэ санаачилгыг тодорхойлсон
	С.3.3.2 Ажил олгогч, ажилтан, ажил хайгчдад зориулсан түршлага, шинэ санаа, арга техник, технологи солилцох арга хэмжээ зохион байгуулах	0	1 АБ-ны өдөрлөг/ТХЗ-ын арга хэмжээ	<b>Хэрэгжиж байна.</b> Ажлын байрны өдөрлөгийг 2023 оны 10-р сард зохион байгуулсан.
	С.3.3.3 Тухайн ажлын байртай холбоотой сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	0	40 байнгын ажилтныг сургасан байна.	<b>Хэрэгжиж байна.</b>

### С.3.1 Загварлан бүтээх сэтгэлгээ (Design Thinking-DT), ухаалаг шийдвэр гаргах зөв дадал-зан төлөв суулгах (Behavioral Insights-BI) чиглэлээр чадавх бэхжүүлэх

**Энтрепренершип ба инноваци сургалтын хөтөлбөрийг** 2023 онд дуусгаж, сургалтын хөтөлбөрийг БШУЯ-д цаашид сургалтанд нэвтрүүлэх талаар шийдвэр гаргуулахаар хүргүүлсэн. Энэ нь Монгол

улсын МТБС-д <sup>16</sup>анх удаа нийцүүлсэн Энртепренершип ба инноваци сургалтын хөтөлбөрийг боловсруулсан юм. Уг хөтөлбөрийг таван МТБС-ын байгууллагад (Төв аймгийн Баянчандмань сум, Баянхонгор аймаг, Налайх дүүрэг дэх политехникийн коллеж болон Улаанбаатар хот дахь 2 коллеж; Үйлдвэр, урлалын политехникийн коллеж, Хүнсний технологийн политехник коллеж) дээр туршилтын журмаар нэвтрүүлж, туршилтын үр дүнг хөтөлбөрт тусган сайжруулсан. Сургалтын хөтөлбөрийн модулийг туршихад нийт 167 суралцагч, 107 багш хамрагдсан бөгөөд оролцогчдоос маш эерэг санал өгсөн. Туршилтын хүрээнд 48 сургагч багш бэлтгэгдэж, суралцагчдын таван гарааны бизнес санааг цаашид хөгжүүлэх зорилгоор бага хэмжээний тэтгэлэгт хамруулсан.

**МТБС-ын тогтолцооны суурийг бэхжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажлуудыг 2023 онд гүйцэтгэсэн.** Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж байсан асуудлуудыг тодорхойлох системийн шинжилгээг оны эхэнд хийсэн. МТБС-ын салбарын чанарын баталгаажуулалт нь Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт төсвийн дэмжлэг үзүүлэх нэг үзүүлэлт юм.

- **Мэргэжлийн чиглэл, индексийг төслийн дэмжлэгтэйгээр 2023 онд шинэчилсэн.** Боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED 2011) болон YAMAT-08 гэгддэг Олон улсын мэргэжлийн ангилал (ISCO-08)-ын дагуу эдийн засгийн үндсэн арван салбарын нийт 280 орчим мэргэжлийн нэр, индексийг шинэчилсэн. Мэргэжлийн индексийн шинэчилсэн төслийг БШУЯ-нд хянуулж батлуулахаар хүргүүлсэн.
- **Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц (МУШБ) болон холбогдох аргачлалыг** Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран төслийн техник түслалцааны дэмжлэгтэйгээр боловсруулах ажлыг 2023 онд эхлүүлсэн. Энэхүү ажлыг боловсрол, хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэлийн төлөөлөл, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэл зэрэг олон талуудыг татан оролцуулах замаар гүйцэтгэх ба 2024 оны тавдугаар сард багтаан дуусгахаар төлөвлөж байна.
- **МТБСБ-ын чанарын үнэлгээ.** Төслийн дэмжлэгтэйгээр БСШУЯ-ны Боловсролын үнэлгээний төвөөс нийт 69 МТБСБ-ыг (Улаанбаатарт 30, аймагт 39) (төрийн болон хувийн хэвшлийн) үнэлэв. Үнэлгээнд байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанар, багш нарын ур чадвар зэрэг гурван чиглэлийг хамруулсан. Үнэлгээнд харилцан адилгүй санал ирүүлсэн ба энэ нь МТБСБ-ыг ХНХЯ-аас БШУЯ-д шилжүүлсэнтэй холбоотой зөрүүтэй аргачлал ашигласан нь нөлөөлж байна. Төслийн дэмжлэгтэйгээр 2022 онд боловсруулсан МТБСБ-ын чанарын баталгаажуулалтын хүрээнд төслөөс санал болгосон аргачлалыг бүрэн ашиглаагүй байна. МТБСБ-ын чанарыг үнэлэх арга зүй, журмыг олон улсын стандарт жишигт нийцүүлэн боловсронгуй болгох талаар түншлэгч, хамтрагч талуудтай санал солилцож байна.

**С.3.2. Мэргэжлийн зөвлөгөө өгөх мастер сургалт явуулах зайн/онлайн платформыг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зайнаас хүргэх чадавхыг дээшлүүлэх замаар хүртээмж, хамрах хүрээг өргөжүүлнэ.**

Энэхүү үр дүнгийн зорилго нь алслагдсан бүс нутгийн залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил хайгчид зэрэг зорилтот бүлгийн иргэдэд хэрэгцээтэй байгаа үр чадварыг олгох сургалтуудыг технологид суурилсан нэмэлт модулийг ашиглах замаар институцийн бүтцэд оруулахад оршино.

---

<sup>16</sup> Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газраас 2023 онд БОЯ-наас баталсан ЕБС-ийн суралцагчдад зориулсан Бизнес эрхлэх сургалтын модулийг боловсруулсан үү?


Тайлант хугацааны туршид төслийн зүгээс ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээний мастер сургалтын цахим платформыг бий болгох, зайнаас хөдөлмөр эрхлэлтийг үйлчилгээг үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх талаар дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Анхан шатны нэгж дээр ажиллаж буй хөдөлмөрийн мэргэжилтнүүдэд зориулан заавал үзэж, судлах сургалтын нэг болгон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим сургалтыг хөгжүүлж байна. Энэ нь төслийн дэмжлэгтэйгээр боловсруулж буй тайлангийн эхний хэсэгт дурдсан ажил мэргэжлийн чиг баримжааны сургалтын агуулгын хүрээнд хийгдэх юм. Ажил, мэргэжлийн зөвлөхүүдэд тавигдах шаардлагыг мөн боловсруулж байна. Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх хүрээг боловсруулсан бөгөө ХНХЯ болон БШУЯ-ны сайд нарын хамтарсан тушаалаар батлуулахаар төлөвлөж байна.
- 2022 онд төслийн дэмжлэгтэйгээр 3 мэргэжлээр (Архивын ажилтан, Оффисын түслах, Цахим үйлчилгээний ажилтан) сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Сэргээн засах үндэсний төв дээр уг хөтөлбөрүүдийг туршсан. Үр дүнд нь хөгжлийн бэрхшээлтэй 28 сурагч 2023 онд төгсөж хоёр мэргэжлээр чадамжийн гэрчилгээгээ гардан авсан.

**Архив, Оффисын ажилтан, Цахим үйлчилгээний ажилтан мэргэжлээр багшийн гарын авлага** - 2023 онд хэвлэн гаргасан. **Цахим ажилтны сурагчийн гарын авлагыг** хянаж, хэвлэлд өгөхөд бэлэн болгоод байна. Гарын авлагын PDF хувилбарыг цахим сургалтад зориулан онлайнд байршуулсан.

2023 оны хичээлийн шинэ жилээс эхлэн Баянчандмань Политехник коллеж<sup>17</sup> хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан **цахим үйлчилгээний ажилтан мэргэжлийн сургалтыг** зааж эхэлж байна. Энэ Баянчандмань Политехник коллежийн 54 жилийн түүхэнд **анх удаа** ХБИ-д зориулсан ангийг нээсэн явдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн элсэлтэд бэлтгэн сургалтын орчныг сайжруулах зорилгоор засварын ажлыг хийсэн ба стандартад нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдан авч өгсөн. 2023 оны 8-р сард ТМБ-ын Үндэсний форумын үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шинэ анги элсэлтээ авч буй талаар албан ёсоор мэдэгдсэн.

### С.3.3 Ажил олгогчдод чиглэсэн арга хэмжээ, ажил олгогч-ажилтны харилцааг дэмжсэн байнгын ажиллагаатай механизм бий болгоно.



Зураг 2: “Цахим Үйлчилгээний ажилтан” багш, сурагчийн гарын авлага

Энэхүү үр дүнгийн зорилго нь тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд чиглэх, ажиллах зорилгоор ажил олгогч, ажилтан, сургалтын байгууллагын хоорондын харилцаа хамтын

ажиллагааг сайжруулахад чиглэж байна. Ажил олгогч, ажилтан хоорондын нэгдмэл ойлголт, харилцааг сайжруулах талаар саналыг хувийн хэвшил, нийгмийн байгууллагуудаас авах зорилгоор төслийн зүгээс 2022 онд зар гаргасан.

<sup>17</sup> Улаанбаатар хотоос 72 км-ийн зайд орших Төв аймгийн Баянчандмань сум.



Зураг 3, 4: Хүртээмжтэй сургалтын орчин, Баянчандмань политехникийн коллеж 11-р сарын 10.

“Ухамсартай манлайлал” болон “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын манлайлалд зан үйлийн өөрчлөлт хийх нь” хэмээх 2 төсөл шалгарсан. Эдгээр хоёр дэд төслийн туршилтаар дараах үр дүнд хүрсэн.

- **‘Ухамсартай манлайлал’** санаачилгыг орон нутгийн ТББ хэрэгжүүлж нийт 20 удирдагчдыг хамруулсан бөгөөд 2022 оны 10-р сараас 2023 оны 5-р сар хүртэл үргэлжилсэн<sup>18</sup>. Бизнес хүний эрх, тогтвортой санхүүжилт, албан бусаас албан эдийн засагт шилжих зэрэг сэдвүүдээр хэд хэдэн хамтын хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулсан. Нийт 20 байгууллагын ес нь **хүний эрхийн магадлан шинжилгээ** хийлгэсэн ба хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийг сайжруулах талаар хэд хэдэн зөвлөмж үр дүнд нь гарсан.
- ЖДҮ эрхлэгчдийн дунд зохистой хөдөлмөрийг сурталчлах, ажил олгогч ажилтны хамтын ажиллагааг сайжруулах саналыг хоёр дах баг болох **“Дэм”** (дэм дэмэндээ) төслийн хүрээнд өөр нэгэн дотоодын ТББ<sup>19</sup> хэрэгжүүлсэн. Энэхүү дэд төсөлд хүнс, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй 20 компани, хоршоод оролцсон. Төслийн төгсгөлд хувь хүний түвшинд (хувь хүний хөгжил, суралцах үйл явц болон эрүүл мэндийн хувьд анхаарал хандуулах болсон), гэр бүлийн түвшинд (гэр бүлтэйгээ илүү цаг зарцуулах, хайрлах, хайрлуулах хэрэгцээг хангах, харилцан ойлголцох), байгууллагын түвшинд (ажиллагсдын үзэл бодлоо илэрхийлэх нь нэмэгдсэн, захирлууд босс байхаас илүү манлайлагчид болсон, харилцан бие биеэ ойлгож итгэх болсон, ажилдаа сэтгэл хангалуун, байгууллага ерөнхийдөө эерэх соёлтой болсон) тус тус эерэг үр дүн ажиглагдсан.

Дэд төсөл нь 6 үе шаттайгаар хэрэгжсэн; i) сонирхлоо илэрхийлсэн байгууллагуудаас оролцох бизнесүүдийг сонгосон, ii) асуулга болон урлагийн эмчилгээний аргыг ашиглан ажлын байран дээрх хүний эрх, зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаар нөхцөл байдлыг тодорхойлох (Улаанбаатар хот, Өмнөговь, Төв, Баянхонгор, Увс аймгийн бизнесээс 225 хүн), iii) өмнөх шатанд мэдээлэл цуглуулалтын үеэр илрүүлсэн асуудлуудын шалтгаан-үр нөлөөнд шинжилгээ хийж, уг асуудлуудыг шийдвэрлэх аргагүйг боловсруулсан, iv) Загварчлах сэтгэлгээний аргыг ашиглан шийдлийн Хакатоныг зохион байгуулсан (27 бизнесийн удирдлага), v) Хакатоны үеэр өгсөн амлалтын хэрэгжилтийг хамтран мөшгөх хамтын багийг байгуулсан бөгөөд, амлалтын

<sup>18</sup> International Women’s Federation of Commerce and Industry (IWFCI), established in 2017.

<sup>19</sup> Women Associations of Mining Sector (WAMS) [www.wams.mn](http://www.wams.mn)

хэрэгжилтийг хэд хэдэн арга хэрэгсэл ашиглаж хангахад дэмжих үзүүлсэн vi) төслийг дүгнэж, гарсан үр дүнг хуваалцсан.

Төсөлд оролцсон ЖДҮ-д зориулж Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн хялбаршуулсан гарын авлагыг боловсруулсан ба одоогийн мөрдөгдөж байсан албан ёсны гарын авлага ойлгоход амаргүй байдаг байна.

- 2023 оны 10-р сард Ажилд **Зуучлах Арга хэмжээг** ажил олгогчид болон хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдын дунд зохион байгуулсан. Ажилд зуучлагчийн тусламжтайгаар ажил олгогч болон ажил хайгчдын урьдчилсан үнэлгээ хийсэн ба нийт 50 ажил хайгчдаас 28% нь амжилттай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үлдсэн нь үргэлжлүүлэн зуучлах үйлчилгээнд хамрагдсаар байна.

#### **С.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХЭД ҮР ДҮНТЭЙ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ НОТӨЛГӨӨ, СУРГАМЖ ЦУГЛУУЛАХ, БОДЛОГОД ТУСГАХ ЗОРИЛГООР ТУРШИЛТЫН ТӨСЛҮҮД ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

Төслийн хүрэх үр дүн С.4-ийн хүрээнд таван тодорхой үр дүнд хүрэхээр зорьж байна. Үүнээс НҮБ-ын ХХААБ-д С.4.1-С.4.4 хэсгүүд, НҮБ-ын ХХ-т С.4.5 хэсэг хамаарна.

#### **Төслийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийн явц**

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023	Хэрэгжилт 2023
С.4.1. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг улам сайжруулах, залуучуудыг ХАА-н нэмүү өртгийн сүлжээнд олноор ажиллуулах боломж бүхий төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны загварыг боловсруулж, туршина	С.4.1.1 Амжилттай хэрэгжүүлсэн ТХХТ-ийн тоо (Эцсийн хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн байна)	0	2 бүтээгдэхүүн сайжирсан байна	<b>Хэрэгжиж байна.</b> Хоёр НӨС хөгжүүлэлт: Хос бөхт ингэний сүү, Дотор мах
	С.4.1.2 Ур чадварын Хэрэгцээг тодорхойлж, сургалт явуулах	0	50 хүнд сургалт – үйлдвэрлэлийн чанар, тоо сайжирна	<b>Хэрэгжиж байна.</b> Нийт 29 төгсөгч үр чадвар эзэмшсэн. Үүнээс 14 нь “Мал төхөөрөх ажилтан” мэргэжлээр, 15 нь “ХАА-н машин, механизмын засварчин, оператор” мэргэжлээр төгссөн.
	С.4.1.3 Сүлжээний платформыг сурталчлах	0	4 уулзалт	<b>Хэрэгжиж байна.</b> "Agripreneurship Challenge" тэмцээнийг амжилттай зохион байгуулав.
	С.4.1.4 Хөдөө аж ахуйн салбарт сонгосон өртгийн сүлжээг дэмжих	0	Бүтээгдэхүүний чанар, тоо сайжирна	<b>Хэрэгжиж байна.</b> Фермийн аж ахуй эрхлэх зохистой дадал, Ариун цэвэр, эрүүл ахуйн дадал, Чанар, аюулгүй байдлын стандарт, тэмээний ноос боловсруулах арга, технологийн зэрэг чадавх бэхжүүлэх сургалтуудыг Ингэний сүү үйлдвэрлэгч-малчдын хоршооны гишүүд болон ХАА-н бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан. Үйлдвэрлэлийн чанар, гарцыг сайжруулах зориулалттай

				тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж байна.
С.4.2 Монгол улсын агробизнесийн чиглэлийн аж ахуйн нэгжүүдэд ХАА-н нэмүү өртгийн сүлжээг боловсронгуй болгох бүтэц зохион байгуулалтын болон техникийн шинэчлэлийг хийхэд дэмжлэг үзүүлнэ	С.4.2.1 Хоёроос доошгүй тооны ХАА-н шинэ бүтээгдэхүүнийг тодорхойлж, бойжуулан хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэх	0	2-оос доошгүй шинэ бүтээгдэхүүн хөгжүүлсэн байна	<b>Хэрэгжиж байна.</b> 1. Хос бөхт ингэний сүүн бүтээгдэхүүн 2. Дотор мах, махан бүтээгдэхүүний хөгжүүлэлт, судалгааны ажил явагдаж байна.
	С.4.2.2 Яамдын ердийн төсвийн хүрээнд өргөжүүлэх	0	1-ээс доошгүй бүтээгдэхүүн ийг ХХААХҮЯ-ны төлөвлөгөөн Д тусгуулах	<i>*Туршилтын үйл ажиллагаа хэрэгжсэний дараа ХХААХҮЯ нь өөрийн төсөвт тусган, цар хүрээг өргүүлэх ажлыг шийдвэрлэнэ.</i>
С.4.3 Үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц, үндэсний болон олон улсын чанар, аюулгүйн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүний үндэсний брэндүүд бий болгохыг дэмжинэ	С.4.3.1 Брэнд болох боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойлох	0	2 шинэ бүтээгдэхүүн	<b>Хэрэгжиж байна.</b> 1. Хос бөхт ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн 2. Дотор мах, махан бүтээгдэхүүн
	С.4.3.2 Хэрэглэгчийн зах зээлийн хөндлөнгийн судалгаа хийх			
	С.4.3.3 Сургалтад хамрагдсан 150 залуусын дунд бизнес төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах			
	С.4.3.4 Сонгосон хүнсний брэнд бүтээгдэхүүнийг түрших			
С.4.4 Агрибизнес т суурилсан хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, сорилт бэрхшээлийг тодорхойлж, түршина	С.4.4.1 С4.1-4.3-д дүн шинжилгээ хийх		Дүн шинжилгээ хийсэн байх	<b>Хэрэгжиж байна.</b> 1000 ботгоны фестиваль, Монгол улсад Ингэний сүүний кластер байгуулах боломж зэрэг уулзалт, хэлэлцүүлэгт талуудын оролцоог өндөр түвшинд ханган зохион байгуулав.
	С.4.4.2 Үндэсний хэмжээний семинар зохион байгуулах			
	С.4.4.3 Дээд түвшний семинар зохион байгуулах			

#### **С.4.1. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг улам сайжруулах, залуучуудыг ХАА-н нэмүү өртгийн сүлжээнд олноор ажиллуулах боломж бүхий төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны загварыг боловсруулж, туршина**

2022 онд төслийн дэмжлэгтэйгээр Ингэний сүү үйлдвэрлэгч-малчдын хоршоо байгуулж тухайн нэмүү өртгийн сүлжээг ТХХТ-ийн загварт суурилан бэхжүүлэх ажил 2023 онд амжилттай үргэлжлэн хэрэгжиж байна. ТЭСО Группт нийлүүлж буй ингэний сүүний нийлүүлэлт нэмэгдсээр байгаа ба энэ нь Саудын Арабын вант улс болон БНХАУ-ын зах зээлд бүтээгдэхүүн гаргах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа бөгөөд зарим нэр төрлийн зайрмагийг Хятадын зах зээлд аль хэдийнээ нийлүүлж эхлээд байна.

Өмнөговь аймгийн Ханхонгор суманд хувийн хэвшил, Солид Партнерс Групп ХХК (SPG LLC)-тай хамтран ингэний сүүний хагас эрчимжсэн аж ахуйг байгуулах ажил явагдаж байгаа бөгөөд сүү хөргөх танк, сүүний найрлага шинжлэх төхөөрөмж, автомат саалтуур, болон бусад хэрэгцээт тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлийн бүтээмж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад дэмжлэг болгон төслийн хүрээнд худалдан авч, суурилуулаад байна.

Өнгөрсөн жил төслийн дэмжлэгтэйгээр боловсруулан Эрдэнэ МСҮТ-д хэрэгжүүлж буй “Мал төхөөрөх ажилтан” бэлтгэх богино хугацааны чадамжийн сургалтаар 2023 оны байдлаар 14 ажилтныг бэлтгэн төгсгөв. Тус МСҮТ-ийн Мал төхөөрөх сургалтын төвийн сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлж хөргөх-хөлдөөх өрөө, цэвэр усны худгийг байгуулан 2023 онд хүлээлгэн өгөв.

Баянчандманийн Политехникийн коллежид хэрэгжүүлж буй “ХАА-ын машин механизмын оператор, засварчин” мэргэжлийн 6 сарын хугацаатай сургалтад 2023 онд 15 оюутан хамрагдан төгссөн ба сургалтын дадлага хийх орчныг бүрдүүлэхэд дэмжин ХАА-н техник, тракторын симуляторын багцыг тус коллежид хүлээлгэн өгөв.

Сургалтад хамрагсдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр дээрх 2 чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг сурталчлан танилцуулах ажлыг мөн зохион байгуулан ажиллалаа.

“Agripreneurship Challenge” буюу ХАА-ын салбарын шинэлэг, инновацлаг бүтээгдэхүүн, бизнесийг шалгаруулах тэмцээний хүрээнд төрөл бүрийн ХАА-н шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний санааг дэвшүүлсэн 100 гаруй материал хүлээн авсны 20 орчим хувь нь тусгай хэрэгцээт иргэдийн бизнес байв. Оролцогчид 3 хоногийн эрчимжүүлсэн сургалтад хамрагдан, тэмцээний ялагчид нийт 50 сая төгрөгийн санхүүжилтийг бизнесээ өсгөн томруулах зорилгоор хүлээн авсан ба төслийн хүрээнд 1 жилийн туршид бойжуулалтын хөтөлбөрт хамрагдаж байна.

2023 оны 8 сард “Олон улсын худалдаа, экспортын стратеги” сэдэвт 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан ба нийт 73 бизнес эрхлэгчид хамрагдсанаас 41 хувь нь экспортын чиг баримжаатай үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд байв.

Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд суманд байгуулагдсан “Галбын Говийн Баялаг Эрдэнэ” ингэний сүү үйлдвэрлэгч-малчдын хоршооны 2023 оны сарын дундаж орлого 13,4 сая төгрөг байгаа нь өмнөх оныхоос 108 хувиар нэмэгдсэн байна. Тус хоршоог сайжруулах, чадавхыг бэхжүүлэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үүнд: 1) Торомны ноос бэлтгэх, ноос ноолуур бэлтгэх, ноосны шинж чанар, холбогдох стандарт, болон зах зээлд бүтээгдэхүүн гаргах боломж зэрэг сургалтууд, 2) Нарны сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг блокчэйнд суурилсан гарал үүслийг мөшгөх системээр



тоноглогдсон хүйтэн хэлхээний систем бүхий сүү хөргөх, хадгалахад зориулсан бага оврын ачааны тэргийг гишүүн өрх бүрд хүлээлгэн өгсөн зэрэг болно.

#### **С.4.2 Монгол улсын агробизнесийн чиглэлийн аж ахуйн нэгжүүдэд ХАА-н нэмүү өртгийн сүлжээг боловсронгуй болгох бүтэц зохион байгуулалтын болон техникийн шинэчлэлийг хийхэд дэмжлэг үзүүлнэ:**

Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг Монгол хос бөхт ингэний сүү болон бог малын дотор махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ (НӨС)-ний түвшинд хэрэгжүүлж байна. ТЭСО Групп болон Эс Пи Жи ХХК-тай бий болгосон ТХХТ-ийн хүрээнд хийж буй ажлууд нь тухайн компаниудын ингэний сүүн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих зорилготой. Энэ нь бүтээгдэхүүнийг зах зээлд танигдахыг хөхиүлэн дэмжих, өрсөлдөөн бий болгох, хөдөө орон нутагт ажлын байр бий болгох замаар тухайн НӨС-г сайжруулах нөлөөтэй юм.

Түүхий эдийн аюулгүй байдал, чанарыг эх үүсвэр, анхан шатны боловсруулалтын түвшинд сайжруулах зорилгоор ингэний сүүний хагас эрчимжсэн фермд мал эмнэлгийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд малын үзлэг, эмчилгээ, урьдчилсан болон яаралтай тусламжийн үйлчилгээ, вакцинжуулалт, халдваргүйжүүлэлт, болон сүү, сүүнд бүтээгдэхүүнд тавигдах ариун цэвэр, хүнсний аюулгүй байдлыг хангахад мөрдөх дүрэм, журмын сургалтууд багтаж байна. Энэ хугацаанд тэмээний эрүүл мэндийг хангах зорилгоор “Галбын Говийн Баялаг Эрдэнэ” хоршооны 20 гишүүний нийт 6,573 толгой тэмээ болон Ханхонгор сум дахь сүү үйлдвэрлэгчдийн бүлгийн 7 тэмээчин өрхийн нийт 980 толгой тэмээг үзлэг үйлчилгээнд хамруулаад байна.

ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн сургуультай хамтран бог малын дотор махан шим тэжээлээр баялаг шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, үйлдвэрлэлийн оновчтой технологийг боловсруулах судалгааны ажил хийж байна.

“Agripreneurship Challenge” тэмцээний шилдэг оролцогч, гарааны бизнесүүдийн үйлдвэрлэлийн үе шатыг боловсронгуй болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг тодорхойлсон. Тухайлбал, зөгийн хорыг ашиглан өвдөлт намдаах үйлчилгээтэй тос үйлдвэрлэдэг “Мэжик Би” ХХК-ийн хувьд эмульгатор болон насос нь тос үйлдвэрлэх үе шатыг механикжуулж бүтээгдэхүүний чанарыг сайжруулах ач холбогдолтой. Харин аргалаар цаас үйлдвэрлэдэг “Спек Материалс” ХХК-ийн хувьд түүхий эдийг буталж, боловсруулахад шаардлагатай төхөөрөмж авах нь оновчтой гэж үзсэн. Эдгээр тоног төхөөрөмжүүд нь үйлдвэрлэлийн хүчин чадал, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

#### **С.4.3 Үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц, үндэсний болон олон улсын чанар, аюулгүйн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүний үндэсний брэндүүд бий болгохыг дэмжинэ:**

ХААИС-ын Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран бэлчээрийн менежмент, нэмэгдэл тэжээл болон тэжээлийн менежментийг сайжруулах замаар ингэний сүүний гарц, тэжээлийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилго бүхий судалгааны ажил үргэлжилж байна. Одоогийн байдлаар лабораторийн шинжилгээний үр дүнд суурилан тэжээлийн түршилт хийх зорилгоор 7 төрлийн нэмэгдэл тэжээлийн жор, технологийг боловсруулж байна. Эдгээрээс хамгийн тохиромжтой жорыг сонгох бөгөөд энэ нь тухайн бүтээгдэхүүнийг дотоодын болон олон улсад мөрддөг стандартад нийцүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэгт эерэг нөлөөтэй юм.

Монголын Махны Холбоотой хамтран бог малын дотор мах, дотор болон дайвар махны гарц, хэрэглээний чиг хандлага, эрэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, тус бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжийг үнэлэхийн сацуу түүний үр дүнг үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд сурталчлан таниулах зорилго бүхий цогц судалгааг эхлүүлээд байна. Судалгааны үр дүнг хэрэглэгч болон үйлдвэрлэгчдийн аль алинд нь дотор мах, дотор махан бүтээгдэхүүний үнэ цэнийг таниулан сайжруулах зорилго бүхий борлуулалт, маркетингийн стратеги боловсруулахад ашиглана.

“Rural Invest” буюу “Хөдөөгийн Хөрөнгө Оруулалт” нэртэй 5 өдрийн сургалтыг 2023 онд долоон удаа Өмнөговь аймаг, Эрдэнэ МСҮТ, Баянчандмань ПК, Хэнтий аймаг, болон Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. Тус сургалтаар хөрөнгө оруулалт босгохоор зэхэж буй хөдөө орон нутагт ХАА-н бизнес эрхлэгчид болон залууст аливаа бизнес санааг төсөл, төлөвлөгөө болгон боловсруулдаг программыг хэрэглэж сургаж. Сургалтыг НҮБ-ын ХХААБ-ын Хөрөнгө оруулалтын төвөөс бэлтгэгдсэн ХААИС-ийн Эдийн Засаг, Бизнесийн сургуулийн мастер сургагч багш нар удирдан явуулсан ба суралцагсад бичил, жижиг, дунд хэмжээний хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, бизнес төлөвлөгөө гаргах, төслүүдийг хооронд нь харьцуулах, санхүүгийн шинжилгээ, үнэлгээ хийх чадварыг эзэмшив. Түүнчлэн, бизнес санаа, төлөвлөгөө боловсруулдаг тусгай программ хангамжийн Монгол хэл дээрх хувилбарыг үнэ төлбөргүйгээр суралцагсад олгов.

Дээрх сургалтад “Agripreneurship Challenge” тэмцээнд материалаа ирүүлсэн бизнес эрхлэгчид, МСҮТ-ийн сурагчид, аймаг орон нутгийн албан хаагчид, болон бусад бизнес эрхлэгчдийн төлөөлөл зэрэг нийт 160 хүн хамрагдсанаас 45 нь эрэгтэй, 115 нь эмэгтэй байжээ. ОУХБ-тай хамтран “Зохистой хөдөлмөр эрхлэлт”-ийн талаарх сургалтыг хөтөлбөрт нэмэн оруулж “Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ”-ний сургагч багш нар уг хичээлийг заав.

#### **"С.4.4 Монгол Улсын агро-бизнес суурилсан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тулгамдаж буй сорилт бэрхшээлийг тодорхойлон, загварыг боловсруулж, туршина**

Төслийн зүгээс ингэний сүүний кластер байгуулах боломж, уг салбарыг цаашид хөгжүүлэх бэлтгэл хангах зорилгоор хэд хэдэн арга хэмжээ, түүний дотор 100% ботгоны баяр, төр - хувийн хэвшлийнхний олон талт оролцоог ханган мэргэжлийн хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт зэргийг зохион байгууллаа.

Өмнөговь аймгийн Ханбогд суманд 2022 оны 11 дүгээр сард зохиогдсон 1000 ботгоны баярт ЕХ-ны Элчин сайд, НҮБ-ын ХХААБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч тэргүүтэй төлөөлөгчид оролцсон болно. Энэ үеэр орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх, ажлын байр бий болгох болон сумын хөгжлийн бодлогод төслийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа эерэг нөлөө үзүүлж буйг нутгийн захиргааны зүгээс цохон тэмдэглэв. Түүнчлэн ихэвчлэн эмэгтэй гишүүдээс бүрдсэн “Галбын говийн баялаг эрдэнэ” ингэний сүү үйлдвэрлэгч малчдын хоршоог байгуулсан нь уул уурхайн бус ажлын байр, орлогын эх үүсвэрийг бий болгож буйг тэмдэглэсэн билээ. Хоршооны гишүүдтэй уулзах үеэр төслийн хүрээнд нийлүүлсэн хүйтэн хэлхээ бүхий хөргөлтийн төхөөрөмж нь сүүний чанарыг алдагдуулалгүй хадгалах нөхцөлийг бүрдүүлэн өгч, ТЕСО Групп-д сүү нийлүүлэх замаар орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг болж байгаад талархсанаа илэрхийлж байв. Энэхүү үеэр хэлэлцсэн асуудлуудыг төслийн цаашдын төлөвлөгөө, үйл ажиллагаанд тусгасан болно.

Ингэний сүүний аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх боломжийн талаар зөвлөлдөх уулзалтыг Азийн Тивийн Сүүний Түншлэл, ХХААХҮЯ, ЕХ-ны “Монгол Улсад олон улсын худалдааг хөгжүүлэх нь” төслийн хамтаар 2023 оны есдүгээр сард зохион байгуулав. Уулзалтын үеэр төрийн болон олон улсын байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөгчид өөрсдийн үзэл бодол, хийх шаардлагатай ажлын саналыг солилцсон болно.

ХХААХҮЯ, Монголын Махны Холбоотой хамтран мах боловсруулах салбарын оролцогч талуудын уулзалтыг 2023 оны есдүгээр сард зохион байгууллаа. Уулзалтын оролцогчид салбарын тулгамдсан асуудал, цаашид баримтлах чиглэлийн талаар харилцан ярилцаж, экспортын боломж, салбарын хөгжлийн төлөв, шийдлийн талаар хэлэлцэн, санал бодлоо солилцов. Хоёр уулзалтын мөрөөр нэгдсэн санамж, зөвлөмж боловсруулан цаашдын үйл ажиллагаанд нь чиг болгох зорилгоор оролцогч талуудад хүргүүлсэн болно.

### **Сорилт, бэрхшээлүүд**

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж буй гол бэрхшээлүүдийн нэг нь хүний нөөцийн талаар төрөөс баримтлах цогц бодлого байхгүй, энэ нь залуучуудын ХАА салбарт ажиллах сонирхол, ажил эрхлэлт багасахад нөлөөлж байна. Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2019 оны ажиллах хүчний судалгааны тайлангаас харахад нийт ажиллах хүчний 25.3% нь хөдөө аж ахуйн, 21.6% нь үйлдвэрлэлийн салбарт (<https://www.1212.mn>) байна. Ажиллагчдын 24.6% нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан байна. Нийт ажиллагчдын 7.7% нь 15-24 насны залуучууд байна. Залуу ажиллагчдын хувьд арван хүн тутмын гурав нь дипломын болон бакалаврын дээд мөн гурав нь бүрэн дүнд боловсролтой, таван хүн тутмын нэг нь техникийн болон мэргэжлийн боловсролтой залуучууд байгаа бол 2.4 хувь нь боловсролгүй байна. Энэ тоо баримт тус салбарт чадварлаг боловсон хүчин маш их дутагдалтай байгааг харуулж байна.

ТХХТ-ийн загварт суурилан Дотор махан шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх ажил нь цаг хугацаа их шаардаж байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгах саналыг эергээр шийдвэрлэвэл тухайн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, сурталчлан таниулах, зах зээлд амжилттай нэвтрүүлэх, экспортлох боломжийг нээх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын техникийн болон зарим нэгэн үйл ажиллагааг хариуцсан албан хаагч, хүний нөөцийн хомс байдлыг бууруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч энэ нь сорилт хэвээр байсаар байна.

**С.4.5 Хүнсний бус салбарын үйлдвэрлэлийн (арьс шир, нэхмэл) сургалтын төвийн загварыг бий болгон турших.** Энэхүү үр дүнгийн хүрээнд сургалтын байгууллагууд болон салбарын холбоодын хамтын ажиллагааны хүрээнд үр чадварын зөрүү, үр чадвартай ажиллах хүчний дутагдлын асуудлыг хөндөх замаар арьс шир, нэхмэлийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэсэн.

**Арьс шир, нэхмэлийн салбарт эрэлттэй байгаа ажиллах хүчин, үр чадварын талаар судалгааг** 2022 онд эхлүүлж 2023 онд дууссан бөгөөд судалгааны үр дүнг холбогдох бүх талуудад танилцуулсан. Салбар дахь хэрэгцээтэй ажиллах хүчнийг бэлтгэх, зохистой хөдөлмөрийн орчныг бий болгоход уул уурхайн салбартай харьцуулахад цалин бага, сургууль төгсөгчдийн дунд үг салбарын талаарх ойлголт муу, ТМБС-ын квот, үр чадвартай багш дутагдалтай, багш нарын цалин бага, салбарт шаардлагатай мэргэжлийн тодорхойлолтууд дутмаг зэрэг асуудлуудыг энэхүү судалгааны үр дүнд илрүүлсэн.

МУТИС-ын нэхмэлийн инженерийн ангийн элсэлтийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн зүгээс 2022-2023 онуудад тэтгэлэг олгох хөтөлбөрийг салбарын мэргэжлийн холбоодтой хамтран хэрэгжүүлсэн. Тэтгэлэгт хөтөлбөр нь дангаараа энэ салбарын элсэлтийг барих эсвэл нэмэгдүүлж чадахгүй бөгөөд энэ нь арьс шир, нэхмэлийн салбарын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх багц арга хэмжээний нэг хэсэг нь байсан.

## БҮРЭЛДЭХҮҮН Д. ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

ОУХБ-аас хэрэгжүүлж Бүрэлдэхүүн хэсэг D-ийн хүрээнд Төслийн доор дурдсан зорилтуудыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

**D.1** Хууль эрх зүйн орчныг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх

**D.2** Хөдөлмөрийн хяналтыг бэхжүүлж, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах.

### ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮР ДҮН – ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

Төслийн зорилт 8-ын хэрэгжилтийг хангах хүрээнд:

Зорилт 8	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
Хууль эрх зүйн орчныг олон улсын хөдөлмөрийн стандарт, хэм хэмжээнд нийцүүлсэн.	Төлөвлөгөөт бус & урьдчилан мэдэгдээгүй хөдөлмөрийн хяналтын тоо	Байхгүй	Хамгийн багадаа 10 удаа	<b>Хэрэгжсэн.</b> 550 төлөвлөгөөт бус хяналт шалгалт <sup>20</sup> /иргэдийн гомдлын дагуу/

2022 онд төслийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ОУХБ-с (i) урьдчилан мэдэгдэлгүйгээр хяналт шалгалт хийх, (ii) хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах эрх бүхий албан тушаалтан, (iii) хяналт шалгалтын хугацаа, тоо давтамж зэрэг чиглэлээр техникийн санал, зөвлөмж өгч ажилласан байна.

2023 онд ХНХЯ-д хууль эрх зүйн орчны техникийн туслалцааг үргэлжлүүлэн хүргэж Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцод нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд холбогдох баримт бичгийг боловсруулах тухайлбал хууль эрх зүйн орчны дүн шинжилгээ, эдгээр конвенцод нэгдэн орох хуулийн үзэл баримтлалын төслийг нэгдэн орох хуулийн төслийн хамт боловсруулахад дэмжиж ажиллалаа. Одоогоор уг хуулийн үзэл баримтлалын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайд нар батлах шатандаа байгаа ба үүний дараа Гадаад харилцааны сайдад хүргүүлэх юм. Олон улсын гэрээний тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үзэл баримтлалд гурван сайд гарын үсэг зурсны дараа нэгдэн орох саналыг ХНХЯ-наас Засгийн газрын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлэх юм. Засгийн газар уг саналыг дэмжсэн тохиолдолд УИХ-д өргөн мэдүүлнэ. ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын тухай конвенцуудад нэгдэн орох, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх ажлыг ОУХБ-аас 2024 онд үргэлжлүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалд ОУХБ-с техникийн санал өгч ажилласан.

<sup>20</sup>ХНХЯ-ны "урьдчиланмэдэгдээгүй" буюу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу явуулдаг гэж ХНХЯ мэдэгдсэн. Гэнэтийн хяналт шалгалтыг i) Иргэдийн өргөдөл, гомдлын дагуу, ii) улсын ахлах байцаагчийн баталсан удирдамжийн дагуу оны эхэнд нийтэд зарласан тодорхой объектууд дээршалгалт хийхгэсэн хоёр хэлбэрээр явуулдаг байна.

## ДЭД ЗОРИЛТЫН ТҮВШНИЙ ҮР ДҮН

### Төслийн дэд зорилтын хэрэгжилтийн явц

Зорилт 8	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
Зорилт D.1.1. ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны 81-р конвенц, Хөдөлмөрийн хяналтын тухай (Хөдөө аж ахуйн) 1969 оны 129-р конвенцод нэгдэн ороход дэмжлэг үзүүлэх	D.1.1.1 Бодлогын болон техникийн хэлэлцүүлгийн тоо	0	1	Хэрэгжсэн.

**D.1.1. ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны 81-р конвенц, Хөдөлмөрийн хяналтын тухай (Хөдөө аж ахуй) 1969 оны 129-р конвенцуудад нэгдэн орох, ОУХБ-ын суурь конвенцууд болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой конвенцуудын үр дүнтэй хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэв:** Тус ажлын хүрээнд дээр дурдсан ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцуудад нэгдэн ороход ХНХЯ-д үзүүлсэн техникийн дэмжлэгээс гадна, төслөөс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт, шалгалтын журмын төсөлд уг журмын төслийг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх техникийн тайлбарыг хүргүүлж ажилласан. Уг хөдөлмөрийн хяналтын журмын төслийг ХНХЯ-аас хараахан эцэслэж батлаагүй байна.

[ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын ерөнхий зарчмуудын талаарх техникийн удирдамжийг](#) (2022 оны 3-р сард батлагдсан) 2023 онд орчуулж хэвлүүлсэн. Удирдамж нь өнөөгийн практик, тулгамдсан асуудлын хүрээнд ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцод агуулагдах үндсэн зарчмуудын талаар дэлгэрэнгүй техникийн зааварчилгааг танилцуулсан байдаг. 2023 оны 5 болон 9 дүгээр сард ХНХЯ-тай хамтран семинар зохион байгуулж тус удирдамжийг танилцуулсан ба эдгээр арга хэмжээнд 130 хөдөлмөрийн байцаагч, 60 ахлах байцаагч оролцсон.

Төслийн хүрээнд ХНХЯ, ХАБЭА-н төв, ХХҮЕГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон ХАБЭА-н гурван талт үндэсний хорооноос зохион байгуулж буй улс орны бүх салбарт аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэх зорилготой ХАБЭА-н үндэсний аяныг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүллээ. [Нэг сарын хугацаанд үргэлжилсэн мультимедиа кампанит ажил](#)-ын хүрээнд холын зайн автобусанд нийтийн үйлчилгээний зар сурталчилгаа (НҮЗС)-г байрлуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр контент боловсруулан түгээх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг зохион байгуулав. Эдгээр арга хэмжээг Европын холбооны санхүүжилтээр ОУХБ-аас хэрэгжүүлж буй “Зохистой хөдөлмөр ба худалдаа” төсөлтэй уялдуулан зохион байгууллаа. Энэхүү аяны хамрах хүрээг тэлэх зорилгоор НҮЗС-г Монгол Улсын аймгуудыг дамжин өнгөрөх 400 автобусанд байрлуулж олон нийтийн хүртээл болгов. Осол, мэргэжлээс шалтгаалан өвчлөлд нэрвэгдэх өндөр эрсдэл бүхий уурхайн ажилчдад чиглэсэн НҮЗС нь алслагдсан бүс нутгийн олон иргэд, оршин суугчдыг хамарч чадсан. Үүнд Рио Тинтогийн далд уурхай, Ухаа худаг, Баянголын нүүрсний уурхай зэрэг говь дахь уул уурхайн газруудыг зорьж буй зорчигчид багтсан байна. НҮЗС-ны дүрс бичлэгийг 21 мянган зорчигч үзсэн гэсэн тооцоо гарсан. Цаашилбал олон нийтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор НҮЗС-г нэр хүнд бүхий гурван телевизээр 20 хоногоос дээш хугацаанд оргил цагаар цацсан нь үр дүнгээ өгсөн.

Фото челленждэд ойн аж ахуйн ажилчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, уурхайчин, цагдаа, галт тэрэгний буудлын ажилчин, нийтийн автобусны жолооч, сургуулийн багш зэрэг төрөл бүрийн мэргэжлийн 1600 гаруй оролцогч идэвхтэй оролцлоо. Тэд фото челленждэд өөрсдийн фейсбүүк хуудсаараа дамжуулан оролцсон бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн самбар барьж зургаа авхуулж, нийтэлсэн. Энэхүү аянд төрөл

бүрийн салбарын компани, үйлдвэрчний эвлэлийн салбар байгууллагууд, сургуулиуд зэрэг олон тооны оролцогчид оролцов.

**D.1.2. Хөдөлмөрийн хяналтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар техникийн зөвлөмж өгч ажиллана.**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
Зорилт 1.1.2. Хөдөлмөрийн хяналтын үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах, түүний дотор Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг чиглэлээр зөвлөмж боловсруулах	D.1.2.1 ОУХБ-аас өгсөн хууль зүйн зөвлөгөөний тоо	0	1	Хэрэгжсэн.

**D.1.2. Хөдөлмөрийн хяналтын үр ашгийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар зөвлөгөө өгч ажиллаа.** Төслийн хүрээнд хөдөлмөрийн хяналтын хууль тогтоомжийг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцүүлэх чиглэлээр ХНХЯ болон нийгмийн түншүүдэд дараах дэмжлэгийг үзүүлэв.

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) 2021-2025 он хүртэлх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад ХНХЯ-д дэмжлэг үзүүлж ажиллав. Тус ажлын хүрээнд төслөөс ХНХЯ, нийгмийн түншлэгч байгууллагууд, судлаачид, ХНХЯ-ны харьяа нэгж болох ХАБЭА-н төвийг оролцуулсан гурван талт зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Уулзалт нь бүх оролцогч талуудын санал, хүсэлтийг нэгтгэх платформ болж чадсан. Үр дүнд нь үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ХНХЯ-ийн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулав.
2. ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг (ХАБЭМ)-г дэмжих тогтолцооны тухай 187 дугаар конвенцын дагуу холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын орчинд нийцлийн дүн шинжилгээ хийхэд техникийн дэмжлэг үзүүлсэн. Уг конвенц нь ОУХБ-ын суурь конвенцуудаас Монгол Улс хараахан нэгдэж амжаагүй цорын ганц конвенц юм. Уг судалгааны зорилго нь ХАБЭМ-ийн хууль эрх зүйн орчны нийцлийг тодорхойлж, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлоход чиглэсэн. 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан гурван талт зөвлөгөөнөөр ХНХЯ-ны ХАБЭА-н хэлтэс, Уул уурхайн яам, ХНХЯ-ны харьяа ХАБЭА-н төв, МАОЭНХ, МҮЭХ зэрэг байгууллагын төлөөлөгчдөд ХАБЭА-н ОУХБ-ын 187 дугаар конвенцын хууль эрх зүйн орчны нийцлийн судалгааны үр дүнг танилцуулсан. Ирэх онд Европын Холбооны санхүүжилтээр ОУХБ-аас хэрэгжүүлж буй "Зохистой хөдөлмөр ба худалдаа" төсөлтэй хамтран 187 дугаар конвенцод нэгдэн ороход ХНХЯ-д дэмжлэг үзүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана.

**D.1.3. Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх гурван талт Дэд хорооноос Монгол Улсын хүлээх үүргийн хэрэгжилтийг судалж, хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлнэ.**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
D.1.3. Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх Дэд хорооноос Монгол Улсын хүлээх үүргийн хэрэгжилтийг хянаж, хэлэлцэхэд дэмжиж ажилласан.	D.1.3.1 Монгол хэл рүү орчуулсан ОУХБ-ын конвенцыг хянан засварласан тоо	0	1	Хэрэгжиж байгаа.
	D.1.3.2 Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх дэд хорооноос гаргасан зөвлөмжийн тоо	0	1	Биелсэн. 1 (Засгийн газрын тайлан бэлтгэх техникийн зөвлөгөө)

**D.1.3. Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын хүлээж буй үүргийн хэрэгжилтийг дүгнэх хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулав.** Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх гурван талт дэд хорооноос өмнө нь нэгдэн орсон бөгөөд энэ онд ОУХБ-д хүргүүлэх хуваарийн дагуу засгийн газраас боловсруулан конвенцын хэрэгжилтийн тайланг бэлтгэх, хэлэлцэхэд дэмжлэг үзүүлэв. “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай конвенц, 1964 (No122)” -ийн хэрэгжилтийн тайланг ХНХЯ бэлтгэж, [Конвенци, зөвлөмжийг хэрэгжүүлэх шинжээчдийн хороо](#)-нд хүргүүлсэн.

2021 онд Хөдөлмөрийн тухай хууль батлагдсаны дараа Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн үндэсний гурван талт хороо 2022 онд байгуулагдаж, холбогдох салбар хороод байгуулагдсаны нэг нь Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт дэд хороо юм. 2023 онд энэ дэд хороог шинэчлэн байгуулсан. Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын конвенцуудыг хэрэгжүүлэх, тайлагнах талаар дэд хорооноос зөвлөмж боловсруулахад төслийн зүгээс 2024 онд үргэлжлүүлэн дэмжин ажиллана.

**D.1.4: Хөдөлмөр хүрээний зарчим, суурь эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хяналтын талаар олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ (ОУХХХ)-тэй үялдуулах, хэрэгжүүлэхэд учир дутагдалтай асуудал, чиглэлийг тодорхойлох зорилгоор хууль, практикийн судалгааг зохион байгуулна.**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
D.1.4: ОУХХХ-тэй үялдуулах чиглэл, хэрэгжилтийн дутагдалтай байдлыг тодорхойлох зорилгоор хууль, практик судалгааг зохион байгуулна.	D.1.4.1 ТХЗ-ын чиг хандлага, хөдөлмөрийн үндсэн эрх, хөдөлмөрийн хуулийн талаарх мэдлэгийн бүтээгдэхүүний тоо	0	1	Биелсэн.

2019 онд хийгдсэн ОУХБ, ҮСХ-ний “Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, улс орны төлөв байдал - Монгол Улс” судалгааны мэдээллийг шинэчлэх зорилгоор Үндэсний статистикийн хороотой хамтын ажиллагааны гэрээ байгуулах шатандаа явж байна.

**D.1.5. Хөдөлмөрийн хүрээний зарчим ба суурь эрхийг хэрэгжүүлэх, зохистой хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийг албажуулах, хамтын хэлэлцээг үр дүнтэй дэмжих хүрээнд МАОЭНХ, МҮЭХ-нд дэмжлэг үзүүлсэн.**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
D.1.5: МАОЭНХ болон МҮЭХ хөдөлмөрийн хүрээний зарчим, суурь эрхийг үр дүнтэй сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.	D.1.5.1 Ажилтан, ажил олгогчдын байгууллагаас сайжруулсан буюу шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний тоо	0	МАОЭНХ-ны 1 МҮЭХ-ноос 1	Хэрэгжиж буй

Төслийн хүрээнд Монголын ажил олгогчид болон бизнесийн гишүүнчлэлтэй байгууллагууд, тухайлбал Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас үзүүлж буй гишүүнчлэлийн үйлчилгээг сайжруулах зорилгоор аж ахуйн нэгжийн түвшинд хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Филиппин улсад танилцах аялал зохион байгуулсан. Туршлага судлах энэхүү танилцах аялыг 2023 оны 8-р сард Манила дахь ОУХБ-ын төлөөлөгчийн газар болон Филиппиний Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой (ФАОЭНХ) хамтран зохион байгуулав. Монголын ажил олгогч, бизнесийн гишүүнчлэлтэй байгууллагууд ФАОЭНХ болон Филиппиний Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас танилцуулсан гишүүнчлэлийн үйлчилгээний шилдэг туршлагад суралцсан. Оролцогчид аж ахуйн нэгжийн түвшинд хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд гишүүнчлэлийн үйлчилгээг сайжруулах тухай ойлголт, мэдлэг, туршлагыг харьяа байгууллагуудад дамжуулан түгээж, танилцах аялын үеэр хүримтлүүлсэн ойлголт, туршлагад үндэслэн төслийн санал боловсруулсан.

Эрсдэл ихтэй салбаруудын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ХНХЯ-ны хөдөлмөрийн хяналтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих зорилгоор Үйлдвэрчний эвлэлийн холбоод болон 12 аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга нараас бүрдсэн 50 төлөөлөгчийг хамруулсан Хөдөлмөрийн тухай хуулийн сургалтыг Баянхонгор аймагт МҮЭХ-ноос зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв.

**D.1.6. Мэргэжлийн бүлгүүд болон Монголын Зохистой Хөдөлмөр Залуучуудын Сүлжээ (DW4YN) хөдөлмөр эрхлэлтийг албажуулах зорилгоор Монголын залуучуудын хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэг, үйл ажиллагааг дэмжихэд дэмжлэг үзүүлэв.**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
D.1.6: Мэргэжлийн бүлгүүд болон Монголын Залуучуудын Зохистой Хөдөлмөр Сүлжээ (DW4YN) хөдөлмөр эрхлэлтийг албажуулахад чиглэсэн Монголын залуучуудын хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.	D.1.6.1 Зохистой ажил, хууль тогтоомжийг дагаж мөрдөх кампанит арга хэмжээний тоо	0	1	1 (хэрэгжилтийн шатандаа)



**D.1.6. Мэргэжлийн байгууллагууд болон Залуучуудын Зохистой Хөдөлмөр Сүлжээ (DW4YN) - DWYN)-ний залуучуудад хөдөлмөрлөх эрхийг нь эдлүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох зэрэгт чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.** Төслийн хүрээнд Залуучуудын Зохистой Хөдөлмөрийн сүлжээнээс (DWYN) 2023 онд хоёр хакатон (цахим болон цахим бус) зохион байгуулахад НҮБХХ-тэй хамтран дэмжлэг үзүүлж ажилласан. Эдгээр хакатоны зорилго нь 18-34 насны залуучуудын хөдөлмөрлөх эрх, зохистой хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, техник, мэргэжлийн боловсролын сургуулийн зайны сургалтын боломжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн. Хакатон тэмцээнд 21 багийн 100 залуус оролцож дараах сэдвүүдээр шалгарсан гурван хакатон төслийн хэрэгжилтэд нийт 5000 ам.долларыг дэмжлэг болгон санхүүжүүлсэн.

- СУ сүлжээ дэлгүүрт залуу ажилчдын дунд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний зарчмуудыг сурталчлах
- ТМБС-ийн оюутнуудад Хөдөлмөрийн тухай хуулийг шинэлэг тоглоом-- аппликейшн (программ хангамж)--ий тусламжтай таниулах
- Харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэлэг тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх

Хөдөө аж ахуйн салбарын 150 орчим залуучуудад зориулсан хөдөлмөрийн хуулийн сургалт семинарыг 2023 онд Залуучуудын Зохистой Ажиллах Сүлжээ (DWYN)-ээс НҮБ-ын ХХААБ-аас хөдөө орон нутгийн хөрөнгө оруулалтын чиглэлээр зохион байгуулсан сургалттай хамтруулан зохион байгуулахад дэмжиж ажилласан.



*Зураг 5: Дижитал шийдлийн хакатон, 2023 оны 9-р сарын 29*

**D.2.1. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны жилийн стратеги төлөвлөгөө (Хуулийн хэрэгжилтийг хангах стратеги төлөвлөгөө)-г боловсруулахад дэмжлэг үзүүлсэн.**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
------------	------------------	--------------	-------------------------	-------------------

D.2.1: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн.	D.2.1.1 Жилд хэрэгжүүлсэн стратеги төлөвлөгөөний тоо	0	1	1 хэрэгжиж байгаа
--	--	---	---	-------------------

ХНХЯ нь ОУХБ-аас нэвтрүүлсэн **Хуулийн хэрэгжилтийг хангах стратеги төлөвлөлтийн**<sup>21</sup> аргачлалыг ашиглан 2023 онд хийх хяналт шалгалтын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөг боловсруулсан. Стратеги төлөвлөлтийн аргачлалыг хэрэгжүүлсний үр дүнд уул уурхай, барилга, хөнгөн үйлдвэрлэл, бага оврын эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарыг тэргүүлэх ач холбогдол бүхий дөрвөн салбар гэж хөдөлмөрийн хяналтын байцаагчид тодорхойлсон. Хөдөлмөрийн хяналтын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эдгээр өндөр эрсдэлтэй салбаруудын нийт 2315 ажлын байрыг шалгалтад хамруулахаар тусгасан. 2023 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн байдлаар эдгээр хөдөлмөрийн хяналт шалгалтаар Хөдөлмөрийн тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг дагаж мөрдөөгүй аж ахуйн нэгжүүдэд нэг тэрбум орчим төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Төслийн хүрээнд 2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-д хөдөлмөрийн хяналтын тогтолцоог үр дүнтэй бий болгоход дэмжлэг үзүүлэхийг чухалчилсан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас /МХЕГ/ хөдөлмөрийн хяналтын чиг үүргийг ХНХЯ-анд шилжүүлэхтэй холбогдуулан энэ асуудал онцгой ач холбогдолтой байв. Мөн төслийн зүгээс олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулалтын тогтолцоо, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд онцгойлон анхаарч ажилласан. Өмнө дурдсаны дагуу төслийн багаас хөдөлмөрийн хяналтын журмын төсөлд техникийн санал өгч ажиллалаа.

2023 онд хөдөлмөрийн хяналтын ахлах байцаагч, байцаагч, хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагч, нийгмийн хамгааллын байцаагч зэрэг нийт 190 гаруй байцаагчийг хамруулсан 2 удаагийн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулсан. ОУХБ-ын 81, 129-р конвенцод үндэслэсэн хөдөлмөрийн хяналтын техникийн удирдамжийг семинарын үеэр танилцуулав. Мөн арга хэмжээгээр ХНХЯ ба ХХҮЕГ болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн хяналтын асуудал эрхэлсэн орон нутгийн нэгжүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэв. ХНХЯ-ны хөдөлмөрийн хяналтын ахлах байцаагч 2023 оны 10-р сард Итали улсын Турин хотод болсон [Хөдөлмөрийн удирдлага, хөдөлмөрийн хяналт, ажлын байрны дүрэм журам](#) сургалтад хамрагдан хөдөлмөрийн хяналтын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийн туршлага хүримтлуулсан.

**D.2.4: Улс, аймаг, сумын хэмжээнд нийгмийн даатгал, эрүүл ахуй, хөдөлмөрийн хяналтын байцаагч нарыг ажлын байран дахь хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрлөх эрхийн талаарх сургалтын хөтөлбөрт хамруулж Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн албатай нэгтгэв. (аймагт 4 удаа, Улаанбаатар хотод 2 удаа)**

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он	Хэрэгжилт 2023 он
------------	------------------	--------------	-------------------------	-------------------

<sup>21</sup> Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны стратеги төлөвлөлт гэдэг нь ОУХБ-аас илүү тэргүүлэх ач холбогдол бүхий, идэвхтэй арга барилд чиглэсэн уламжлалт хэрэгжилтийн загваруудын хязгаарлалтыг арилгах зорилгоор хөдөлмөрийн хяналтын газрын үйл ажиллагааны стратегийг илэрхийлэхэд ашигладаг нэр томъёо юм. Зорилго нь мэдээлэл цуглуулах, үндсэн шалтгааныг шинжлэх, нэмэлт арга хэмжээ авах, бусад оролцогч талууд, ялангуяа ажил олгогч, ажилчдын байгууллагуудтай стратегийн түншлэлийг сайжруулах замаар хөдөлмөрийн хяналтын хязгаарлагдмал нөөцийн нөлөөллийг нэмэгдүүлэх явдал юм.

D.2.4 Улс, аймаг, сумын хэмжээнд нийгмийн даатгал, эрүүл ахуй, хөдөлмөрийн байцаагч нарт ажлын байран дахь хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрлөх эрхийн талаарх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэв.	D.2.4.1 Хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийг албажуулахад чиглэсэн цогц үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, үр дүнтэй арга барилыг тодорхойлсон үнэлгээний тайлангийн тоо хэмжээ.	0	0	Хэрэгжиж буй 1 (сургалтын хэрэгцээний үнэлгээний тайлан)
---	--	---	---	--

Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх тухай ОУХБ-ын шинэ сургалтын хөтөлбөр-ийг монгол хэлнээ орчуулсан. 2024 онд энэхүү шинээр орчуулсан сургалтын хөтөлбөрт суурилсан сургалтыг ХНХЯ-тай хамтран зохион байгуулна.

#### 4. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тус тайлангийн заасан хугацаанд төсөл нь олон салбарыг хамарсан, үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжсээр ирсэн. Энэхүү хамтын ажиллагаа, түншлэлүүд нь уг тайлангийн өмнөх хэсгүүдэд дурдсан үр дүнгүүдэд хүрэхэд чухал ач холбогдолтой байсан. Төслийн гол хамтрагч байгууллагуудыг доор нэгтгэн оруулав.

- **Засгийн газрын хамтрагч байгууллагууд:** СЯ, ЭЗХЯ, ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ, СоЯ, БТСҮХ, Төрийн бүтээмжийн үндэсний хороо, үр дүнд суурилсан төлөвлөлт ба төсөвлөлт чиглэлээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, хөдөлмөрийн хяналт шалгалт, хөдөлмөрийн хуулийг мөрдөх чиглэлд ХНХЯ, ҮАГ, төсвийн хяналтын чиглэлээр Улсын их хурлын төсвийн байнгын хороо;
- **Орон нутгийн удирдлага:** Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйн чиглэлээр Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсүүд болон 21 аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Аймаг болон сумдын түвшний ҮДСТ-ийн туршилтын чиглэлээр Дорноговь аймаг, төр-хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хэнтий болон Өмнөговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн хэлтсүүд, мөн Өмнөговь аймгийн мал эмнэлгийн хэлтэс;
- **Хоршоод:** Өртгийн сүлжээ, ТХХТ чиглэлээр Баянчандмань сумын 3, Өмнөговь аймгийн 2 хоршоод;
- **Ажил олгогчдын холбоод ба Үйлдвэрчний эвлэлүүд:** Хөдөлмөрийн хуулийг мөрдөх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн чиглэлээр МАОЭНХ, МҮЭХ, Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим;
- **Хувийн хэвшил, үйлдвэрлэлийн холбоод:** Монголын махны холбоо, Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо болон хувийн компаниуд, тухайлбал Эдүкэйтэд Энтерпрайз ХХК, Стартап Маркетинг Спэйс ХХК, ТЭСО Групп, Солид Партнерс Групп ХХК, Тек Партнерс ХХК, Долоонболдог ХХК, , Айрээ фэлт ХХК, Спэк материалс ХХК;
- **Академи, иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд:** ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургууль болон Эдийн засаг бизнесийн сургууль, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Монгол улсын их сургууль, Хөгжлийн шийдэл ТББ, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, СЭЗИС, Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ зэрэг газруудтай хамтран ажиллаж байна.

## 5. МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төслийн баримт бичигт тусгагдсан мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийн хүрээнд төслийн оролцогч талууд болон олон нийтэд төслийн үйл ажиллагаа, үр нөлөөг сурталчлан таниулах ажлыг 2023 оны мэдээлэл харилцааны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу амжилттай хэрэгжүүллээ. Тайлангийн хугацаанд хийгдсэн төслийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, материалд санхүүжүүлэгч Европын Холбооноос үзүүлж буй дэмжлэгийг тусган харуулсан болно.

Тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн мэдээлэл, олон нийттэй харилцах ажлын хүрээнд хийгдсэн гол үр дүнгийн хураангуйг доор оруулав. Тайлангийн хугацаанд хийгдсэн бүтээгдэхүүний бүрэн жагсаалтыг [Хавсралт 5. Мэдээлэл харилцааны хяналт шинжилгээний хүснэгт](#)-д нэгтгэн оруулав.

### **Төслийн үйл ажиллагаа, ололт амжилтын талаарх мэдээллийг зорилтот бүлэгт хүргэсэн байдал:**

Төслийн гол үйл ажиллагаа, үйл явдлын мэдээг (товч нийтлэл, гэрэл зургийн өгүүлэмж, богино хэмжээний видео сурвалжилга, инфографик хэлбэрээр) НҮБХХ-ийн вэбсайт болон олон нийтийн мэдээллийн сувгууд (нийт 68 пост) фейсбүүкийн нийт 44,000 болон Твиттерийн 15,000 гаруй дагагчдад нийтлэн хүргэсэн бөгөөд хамтрагч төрийн болон төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийнхний олон нийтийн хэрэгслээр идэвхтэй хуваалцаж түгээсэн. Орон нутагт хэрэгжиж буй ажлуудыг тухайн орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж сурталчлав.

Төслийн үр шимийг хүртэгчдийн хүрээнд [У.Даваадорж](#) (хүртээмжтэй сургалтын дэмжлэг), болон [Б.Хоролцэцэг](#) (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ) нарын хувь хүний амжилтын түүх, [“Чандмань Алтан Төл”](#) (шинэлэг орон нутгийн хоршооны дэмжлэг) орон нутгийн хоршооны амжилтын видеог олон нийтэд хүргэсэн.



*Зураг 6: Төв аймгийн Баянчандмань сумын “Чандмань Алтан төл” хоршооны малын эмч У.Пүрэвдорж*

Мөн [Баянчандмань Политехникийн коллеж](#) дээр хүртээмжтэй сургалтын орчныг байгуулах ажил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг орон нутгийн засаг дарга, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан нээлтийн арга хэмжээний видеог олон нийтэд хүргэв.

Эдгээр амжилтын видеог (төлбөрт идэвхжүүлэлтгүйгээр) зөвхөн НҮБХХ-ийн олон нийтийн мэдээллийн сувгуудаар нийт 15,000 гаруй хүн үзэж, 400 гаруй хариу үйлдэл үзүүлсэн юм.

"Хүртээмжтэй Хөдөлмөрийн Өдөрлөг-2023" арга хэмжээ нь ажил идэвхтэй хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгайлан чиглэсэн бөгөөд хүртээмжтэй ажлын байраар хангах боломжтой ажил олгогч нарыг хооронд нь холбож, аль алинд нь техникийн дэмжлэг үзүүлж, мэргэжлийн ажлын байрны дадлагажуулагч нар ажилд зуучлах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх шинэлэг замаар тогтвортой, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой зохион байгуулагдав.

Тус өдөрлөгийн үр дүнд зорилтот нийт 50 ажил хайгч ХБИ-ээс 28 хувь нь хөдөлмөрийн гэрээгээ амжилттай байгуулсан бол үлдсэн иргэдийг цаашид ажлын байранд зуучлах, дэмжлэг туслалцааг үргэлжлүүлэн үзүүлж байна. Энэхүү арга хэмжээнд нийтдээ 120 гаруй хүн шууд оролцож, үр шимийг нь хүртсэн бол хамгийн багадаа 900 гаруй хүн шууд бусаар хамрагдсан юм.



Зураг 7: "Хүртээмжтэй Хөдөлмөрийн Өдөрлөг", 2023 оны 10-р сарын 25

**Үр дүнд суурилсан менежментийн арга зүйг шийдвэр гаргагчид болон олон нийтийн дүнд сурталчилж буй нөлөөллийн ажил:** Төсөв бодлогын уялдаатай байдлын ач холбогдлыг цогц үйл ажиллагаагаар (ТВ-ийн бодлогын хэлэлцүүлэг, нийтлэл, олон нийттэй харилцах суваг, видео контент) дамжуулан олон нийтийн мэдлэгийг сайжруулах замаар шийдвэр гаргагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна.

Үр дүнд суурилсан бодлого, төсвийг боловсруулах чиглэлд сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх тэдний чадавхыг бэхжүүлэх нь нөлөөллийн ажлын нэгэн чухал хэсэг учраас төслөөс эдийн засаг, төсөв, парламентын чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчдэд зориулсан Хэвлэл мэдээллийн сургалт арга хэмжээг зохион байгууллаа.

Түүнчлэн уг ажлын хүрээнд сэтгүүлчдийн хэлэлцүүлэг, зорилтот контентыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр "Эдийн засгийн сэтгүүлчдийн клуб"-тэй хамтран ажиллаж эхэлсэн. Өглөөний цайны хоёр удаагийн хэлэлцүүлгийг "Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлт" сэдвээр эдийн засаг,

парламентын сэтгүүлчдэд зориулан, салбарын тэргүүлэгч эдийн засагч, шинжээчдийг зочин илтгэгчээр урьж зохион байгууллаа.

Төсөл анх удаа орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, төсөвлөлтийг үр дүнд чиглэсэн байдлаар боловсруулж, хэрэгжүүлэхэд сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагын оролцоог идэвхжүүлэхэд чиглэсэн сургалт семинарыг Дорноговь аймагт зохион байгууллаа. Тайлант хугацаанд нийт 130 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, ИНБ-ууд чадавхаа бэхжүүлсэн байна.

#### **Төслийн мэдлэгийн бүтээгдэхүүнийг хамтрагч талууд болон олон нийтэд хуваалцсан байдал:**

Төслийн хүрээнд боловсруулсан хэвлэлүүдийн цахим хувилбарыг НҮБХХ-ийн веб хуудас болон олон нийтийн мэдээллийн сувгуудаар олон нийтэд түгээж, хамтрагч төрийн байгууллагуудын холбогдох веб сайтад (Хөдөлмөр нийгмийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийн нэгдсэн самбар ороод) байршуулж мөн төслийн зөвлөхүүд болон түншүүдэд цахимаар илгээж хуваалцсан. Тодорхой хязгаарлагдмал тоогоор хэвлэж, холбогдох төрийн байгууллагуудтай хуваалцаж, сургалт, арга хэмжээний үеэр тараасан.

Түүнчлэн, төслийн зөвлөхүүдийн ҮДСНУ болон ҮДСТ-ийн үндсэн ойлголтуудын талаарх илтгэлүүдийг танин мэдэхүйн видео хэлбэрээр бичиж НҮБХХ-ийн YouTube сувагт байршуулсан.

Төслийн гол ололт амжилт, ахиц дэвшлийг онцолсон I, II-р улирлын эмхэтгэлийг боловсруулж, төслийн түншүүд болон оролцогч талуудтай хуваалцсан.

#### **Олон нийтэд Европын Холбооноос үзүүлж буй дэмжлэгийг сурталчлан таниулах арга хэмжээнд идэвхтэй оролцлоо:**

Төсөл нь Европын Өдөрлөг-2023 арга хэмжээний үеэр залуучуудад чиглэсэн олон төрлийн хүртээмжтэй үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд, тухайлбал нэгэн зэрэг цахимаар болон биечлэн залуусын ирээдүйн карьерт дэмжлэг үзүүлэх богино сургалтууд, ОУБ-ын нээлттэй ажлын байрны мэдээлэл, урлагийн тоглолт зэргийг зохион байгуулж оролцлоо.

Төслийн асарт нийт 2000 гаруй хүмүүс зочилсон ба ажил мэргэжлийн хөгжлийн сургалтад 85 орчим залуус биеэр оролцсон бол цахимаар 4600 гаруй хүмүүс үзсэн байна.



Зураг 8: Залуусын ирээдүйн карьерт дэмжлэг үзүүлэх богино сургалтууд, Европын өдөрлөг, 2023 оны 5-р сарын 14

Дундговь аймагт Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч нар албан [айлчлал](#) хийж “Үр дүнд суурилсан удирдлага” бүсийн сургалт семинарт оролцсон. Түүнчлэн НҮБХХ-ийн шинээр томилогдсон суурин төлөөлөгч, ЕХ-ны төлөөлөгчийн газрын дэд тэргүүн нар [Сонгинохайрхан дүүрэгт ажиллаж](#), төслийн үр шимийг хүртэгчидтэй уулзлаа.

Төслийн брэндийн нийцэл, ЕХ-ны санхүүжилтийн ил тод байдлыг хангах үүднээс “Төслийн лого ашиглах гарын авлага болон төслийн хамтын ажиллагааны удирдамж”-ийг [Англи](#), [Монгол](#) хэл дээр боловсруулж, ЕХ-ны төлөөлөгчийн газраар батлуулж, төслийн зөвлөхүүд болон оролцогч талуудтай хуваалцсан.

Төслийн хэвлэгдсэн материал, техникийн баримт бичгүүдийг **Хавсралт 1-д** хавсаргав.

Тайлант хугацаанд зохион байгуулагдсан сургалтын болон оролцогчдын жагсаалтыг **2-р хавсралтад** хавсаргав.

Хэвлэл мэдээллийн хяналтын холбоосыг **Хавсралт 3-т** хавсаргав.

## 6. ТӨСЛИЙН УДИРДЛАГА

**Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН):** Төслийн үйл ажиллагааг НҮБХХ-ийн удирдлага дор, ХХААБ, ОУХБ-тай хамтран хэрэгжүүлж байна. ТХН нь НҮБ-ын төв байранд байрлаж, НҮБХХ, ХХААБ, ОУХБ-аас бүрдсэн нийт 10 ажилтан (НҮБХХ-ийн 5, ХХААБ-ын 3, ОУХБ-ын 2)-тай баг нь өдөр тутамдаа хамтран үйл ажиллагаагаа явуулж байна.

**Төслийн удирдах зөвлөлийн хурал, жилийн төлөвлөгөө:** Төслийн 2023 оны жилийн төлөвлөгөөг төслийн Удирдах зөвлөлийн ээлжит 2022 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хурлаар баталсан. Төлөвлөгөөний хүрээнд батлагдсан жил (2023 оны 1 дүгээр сараас 12 дугаар сар)-ийн төсөв 3,571,343 ам доллар нь 2023 оны 9 дүгээр сарын 29-нд 3,398,078 ам доллар болж засагдсан. Төслийн Удирдах зөвлөлийн хагас жилийн хурал 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр болж, төслийн хагас жилийн тайланг хэлэлцсэн. Тус хурлын тэмдэглэлийг Хавсралт 4-д нэмж оруулав.

**ЕХ-нд хүргүүлдэг тайлан:** Төсөл санхүүжүүлэгч байгууллага болох ЕХ-нд явцын тайланг сар тутам хүргэж ирсэн бөгөөд тайланд төслийн явцыг мэдээлэхээс гадна төлөвлөж буй арга хэмжээний мэдээллийг өгч, ЕХ-той нягт хамтран ажилласаар ирсэн. Түүнчлэн, төслийн явцын талаарх мэдээлэл хуваалцах албан бус уулзалт хэлэлцүүлгийг 2022 оны 2 дүгээр сард зохион байгуулсан.

**Гэрээний нэмэлт сунгалт:** Төслөөс хийсэн суурь ажлуудыг дэмжин бататгах, төлөвлөсөн ажлуудыг гүйцэлдүүлэх зорилгоор сунгах хүсэлтийг НҮБХХ-өөс Тайланд дахь ЕХ-ны бүсийн суурин төлөөлөгчийн газарт 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлсэн. Одоогоор тус хүсэлт нь хяналтын шатандаа явж байна.

**Худалдан авалт:** Өнгөрсөн тайлант хугацаанд ТХН төлөвлөсөн үйл ажиллагааны үр дүнтэй хэрэгжилтийг хангах, зохицуулах үүднээс нийт 37 зөвлөх-хувь хүн (19 эмэгтэй, 18 эрэгтэй), 11 гэрээт гүйцэтгэгч-хуулийн этгээдтэй хамтран ажилласан.

Нэгдсэн аргачлалаар хийгддэг мөнгөн хөрөнгийн шилжүүлэг (НАСТ)-ийн бичил үнэлгээ, спот шалгалт: НҮБ-ын системийн хэмжээнд нэгдсэн аргачлалаар мөнгөн хөрөнгийг хамтрагч төрийн болон төрийн бус байгууллагад шилжүүлэх журам байдаг. Иймд нэгдсэн аргачлалаар хийгддэг мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн бичил үнэлгээний аргачлалын дагуу төслийн засгийн газрын түвшний хамтрагч байгууллага (Сангийн яам)-ын нэгдсэн аргачлалаар хийгдсэн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн бичил үнэлгээг 2022 онд гадаад аудитын компани гүйцэтгэсэн. Үр дүнд нь, ерөнхий эрсдэлийг “бага” хэмээн үнэлж, нийт 5 зөвлөмжийг өгсөн.

Хоёр спот шалгалтыг НҮБХХ-ийн санхүүгийн дүрэм, журмын дагуу 2023 оны 12 дугаар сард СЯ-нд хийхээр төлөвлөж байна. Спот шалгалт нь хувь-түнштэй хийх мөнгөн шилжүүлгийн санхүүгийн бүртгэлийн нарийн нягт байдал, хөтөлбөрийн төлөв байдал, холбогдох дотоод хяналтад мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан эсэхийг шалгах зорилгоор хийгддэг.

## **7. БЭРХШЭЭЛ/ЭРСДЭЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

Одоогийн салангид системүүд нь тал бүрийн чиг үүргүүдийн хоорондох мэдээлэл солилцоо, баримт боловсруулалт, давхардалт төдийгүй, хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, ХШҮ-ний нэгдсэн мэдээллийн системд сөргөөр нөлөөлж, тэдний дутмаг талыг нэмэгдүүлж байгаа ба гүйцэтгэлийн болон хяналтын чиг үүрэг дэх үр дүнд чиглэсэн аргачлалын хэрэгжүүлэлт болон хэрэглээнд тулгамдаж буй гол асуудлуудын нэг болоод байна.

Албан хаагчдын халаа сэлгээ их, ажлын төлөвлөлтийн дутмаг байдал нь төслөөс оруулсан хувь нэмэр, системийн түвшний өөрчлөлтийн тогтвортой байдлыг дэмжихэд саад бэрхшээл учруулж байна.

## **8. СУРГАМЖ БОЛОН ЦААШДЫН ЧИГЛЭЛ**

Олон-талт оролцоо. Оролцогч талуудын хүчин чармайлтыг үр өгөөжтэй байлгахын тулд янз бүрийн түвшний хамтрагч, түншүүдтэй үр дүнтэй харилцаа холбоог хөгжүүлэх нь маш чухал юм.

Зөвхөн нэг байгууллагыг хамруулахаас илүүтэй өөр өөр бүлгүүдийн төлөөлөл бүхий олон талын оролцоог хангах нь илүү үр дүнтэй шийдэл юм. Сонгуулийн жил ойртож буйтай холбогдуулан төслийн баг арга зүйн зөвлөмжүүдэд түлхүү анхаарах нь чухал байна.

Мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх нь. Төслийн мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг өргөжүүлж, мэдээллийн сувгуудыг төрөлжүүлэхэд анхаарна. Засгийн газрын өнөөгийн тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулан өөрчлөхөд гол хамтрагч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх нь хамгийн үр өгөөжтэй арга механизм байсан. Тиймээс төслийн хэрэгжилтийн эхний гурван жилийн хугацаанд Төсөв, санхүүгийн удирдлага (ТСУ) болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын шинэчлэлтэй холбоотой төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажилласан. Төрийн албан хаагчдын сэлгээ их байсан тул сургалт, уулзалтаас гадна нэгдсэн цахим систем хөгжүүлэх, цахим сургалтын платформ ашиглах, олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зэрэг бусад арга замуудыг харгалзан үзэх болсон.

Засгийн газрын үйл ажиллагааны нэгдмэл арга барил. Орон нутгийн удирдлага, салбарын агентлаг, донор байгууллага зэрэг холбогдох аль болох олон талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангах нь Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг амжилттай нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх нь сүүлийн хоёр жилийн хугацаанд үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ)-ийг ХНХЯ, ХХААХҮЯ-нд туршин хэрэгжүүлсэн туршлагаас харагдаж байна. Төсөв боловсруулах үйл явц нь бие даасан ойлголт биш юм, төсвийн ерөнхий циклийн төлөвлөлт, тайлагнал, хяналт шинжилгээ ба үнэлгээ, удирдлагын мэдээллийн систем зэрэг үйл явцууд бүгдээрээ үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага (ҮДСНУ)-д тууштай шилжих, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Тийм ч учраас тайлант хугацаанд үр дүнд суурилсан төлөвлөлтийг Засгийн газрын хэмжээнд нэгдсэн байдлаар түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Цаашид төсөвлөлт болон тайлагналын чиглэлээр Засгийн газрын бүх түвшинд хүрч ажиллах шаардлага бий болж байна. Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын хэсгээр дамжуулан үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг дэмжин ажиллаж буй нь Засгийн газрын манлайлал сайн байгааг харуулж байна.



Өөрчлөлтийг манлайлагчид. Үр дүнг чухалчлах нь төрийн дунд шатны албан хаагчдын дунд хүлээн зөвшөөрсөн, УИХ-ын гишүүдийн зүгээс шаарддаг болсон нэгэн үзэл баримтлал юм. Энэ чиглэлээр хэрэгжилтийг идэвхжүүлэх, үр дүнг тогтвортой байлгахад төрийн үйлчилгээ болон хууль эрх зүйн тогтолцооны хүрээнд шийдвэр гаргагч нарын манлайлал маш чухал. Тиймээс манлайллын оролцоог хангах нь чухал ач холбогдолтой.

Залуу үеийг идэвхжүүлэх, оролцуулах нь. Бодлого, төсвийн хяналт, хүнс хөдөө аж ахуйн салбар, хөдөлмөрлөх эрхийн чиглэлээр залуучуудыг идэвхжүүлэх, оролцоог хангах, улмаар тэд нөөц бололцоогоо ойлгож мэдэхэд дэмжлэг үзүүлэх нь чухал ач холбогдолтой болох нь түршлагаас харагдаж байна. Тиймээс төслийн баг ирэх жил хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг боловсролын байгууллагууд болон салбарын ажил олгогч нарыг хамруулсан хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Түүнчлэн залуучуудын дунд бодлого, төсвийн хяналтыг хангах чиглэлээр шийдлийн хэлэлцүүлэг өрнүүлэх төлөвлөгөөтэй байна.

Европын Холбоо болон бусад донорын төслүүдийн үйл ажиллагаатай уялдуулах нь. Европын Холбооны санхүүжилттэй “Зохистой хөдөлмөр ба худалдаа” төсөлтэй хамтран Олон улсын хөдөлмөрийн стандартын тухай сургалт зохион байгуулах, Европын өдөрлөг болон ТХЗ-ын Нээлттэй өдөрлөгийг хамтран зохион байгуулж, оролцох замаар төслүүд хоорондын үйл ажиллагааг уялдуулж, зардал хэмнэсэн нь үр дүнтэй байсан.

Европын Холбооны санхүүжилттэйгээр Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөлтэй ҮДСТ-ийн чиглэлээр нягт хамтын ажиллагааг тогтоосон. Цаашид АХБ, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй МТБС-ын салбар, үүр амьсгалын чиглэлийн төсөвлөлт, хөтөлбөрийн төсөв боловсруулахад хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны төсвийг нэгтгэх хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

## **9. САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Төслийн санхүүгийн тайланг хавсаргав.

## **10. ДАРААГИЙН ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ**

2024 оны ажлын төлөвлөгөө

### **11. ХАВСРАЛТ**

Хавсралт 1.

Төслийн хэвлэгдсэн материал, техникийн баримт бичгүүд.

Хавсралт 2.

Тайлант хугацаанд зохион байгуулагдсан сургалтын болон оролцогчдын жагсаалт

Хавсралт 3.

Хэвлэл мэдээллийн холбоос

Хавсралт 4.

Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл